

Улсын бүртгэлийн
дугаар

Аравтын бүрэн
ангилалын код

Нууцын зэрэглэл:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: *ШуСс-2018/29*

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

**“МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ
БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ”
сэдэвт суурь судалгааны ажил**

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

2018 - 2021 он

Төслийн удирдагч:

Ц.Энхжаргал, БШУ-ы доктор, профессор,
НЭМҮТ, НЭМЛЛ, ХСШТЛ-ийн эрхлэгч

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

**Улаанбаатар хот
2022 он**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ТӨСЛИЙН НЭР: **МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ**

- ҮР ДҮНГИЙН НЭР:**
1. “МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ” СУУРЬ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН
 2. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ЗӨВШӨӨРӨЛ
 3. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ГЕМАТОЛОГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)
 4. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ МИКРО БОЛОН МАКРО ЭЛЕМЕНТҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)
 5. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ УУРГИЙН БОДИСУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)
 6. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ АМИНДЭМҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)

АГУУЛГА

РЕФЕРАТ

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

ҮР ДҮН 1. “МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ” СУУРЬ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

ҮР ДҮН 2. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ЗӨВШӨӨРӨЛ

2.1. ЭМЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны тогтоол

ҮР ДҮН 3. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ГЕМАТОЛОГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)

Эрдэм шинжилгээний өгүүлэл дотоодод-1

1. Н.Алтанчимэг, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, П.Гантуяа, Б.Содномцэрэн, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбат, Насанд хүрсэн Монгол хүний цусан дахь зарим үзүүлэлтийн дундаж агууламж ба лавлах хэмжээ, Эрүүл мэндийн лаборатори, 2020, №11, ху 24-27.

Эрдэм шинжилгээний илтгэл олон улсад-1, дотоодод- 3

2. Altanchimeg N, Enkhjargal Ts, Khishigbuyan D, Gantuya P, Sodnomtseren B, Ganbileg D, Ankhtuya S, Naranbat N” Average Values and Reference Ranges for Some Hematology Analytes of Mongolian Adults” Recent Advances in Immunology 2020 International Online Conference, October 16, 2020, S34

3. Н.Алтанчимэг, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, Б.Содномцэрэн, П.Гантуяа, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар “Насанд хүрсэн монгол хүний цусан дахь зарим үзүүлэлтүүдийн дундаж агууламж ба лавлах хэмжээ”, Эрүүл дэлхийн төлөө цусаа бэлэглэцгээе-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 10 дугаар сарын 28, ЭШХ-ын эмхтгэл, 35-36 хуудас

4. Н.Алтанчимэг, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, П.Гантуяа, Б.Содномцэрэн, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар “Хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд оролцох цусан дахь зарим үзүүлэлтийн дундаж агууламж ба лавлах хэмжээ”, Хүрэл тогоот-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 11 дугаар сарын 14, ЭШХ-ын эмхтгэл, 46-50

5. Н.Алтанчимэг, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, П.Гантуяа, Б.Содномцэрэн, Д.Ганбилэг ” Гематологийн зарим үзүүлэлтийн лавлах хэмжээ тогтоосон дүн”, Мэдлэгээ тэлэхүй ЭШ-ний хурал, 2021он, 133-134 хуудас

ҮР ДҮН 4. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ МИКРО-БОЛОН МАКРО-ЭЛЕМЕНТҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)

Эрдэм шинжилгээний өгүүлэл дотоодод-1

1. Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, Б.Содномцэрэн, П.Гантуяа, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбат, Зарим минералын дундаж хэмжээ ба лавлах хязгаар, Эрүүл мэндийн лаборатори, 2020, №11, ху 14-17.

Эрдэм шинжилгээний илтгэл олон улсад-3, дотоодод- 2

2. Enkhjargal Tserennadmid, Khishigbuyan Davaakhuu, Sodnomtseren Batbayar, Gantuya Purevdorj, Altanchimeg Nyam-Orgil, Ganbileg Dashnyam, "Reference Intervals for Some Minerals in the Mongolian Adults Population", ANNALS OF LABORATORY MEDICINE, volume 40, Supplement 1, Published on 23 September 2020, S46
3. Sodnomtseren B, Enkhjargal Ts, Khishigbuyan D, Gantuya P, Altanchimeg N, Ganbileg D, Ankhtuya S, Naranbat N" Mean Value and Reference Intervals for Blood zinc of Mongolian Adults" Recent Advances in Immunology 2020 International Online Conference, October 16, 2020, S61
4. Ts. Enkhjargal, D. Khishigbuyan, B. Sodnomtseren, P. Gantuya, N. Altanchimeg, D. Ganbileg. Reference Intervals for Some Minerals of the Adult Population in Mongolia. AACCC Annual Scientific Meeting 2021, Atlanta, USA, September 26-30, 2021, B-230-E.
5. Б.Содномцэрэн, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, П.Гантуяа, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар "Хүний цусан дахь минералын дундаж ба лавлах хязгаар", Эрүүл дэлхийн төлөө цусаа бэлэглэцгээе-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 10 дугаар сарын 28, ЭШХ-ын эмхтгэл, 65-67 хуудас
6. Ц.Энхжаргал, Б.Содномцэрэн, Д.Хишигбуян, П.Гантуяа, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар "Насанд хүрсэн Монголчуудын цусан дахь зарим минералын дундаж ба лавлах хэмжээ", Хүрэл тогоот-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 11 дугаар сарын 14, ЭШХ-ын эмхтгэл, 32-36 хуудас

ҮР ДҮН 5. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ УУРГИЙН БОДИСУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)

Эрдэм шинжилгээний өгүүлэл дотоодод-1

1. П.Гантуяа, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, Б.Содномцэрэн, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбат, Монгол хүний цусны сийвэнгийн зарим уургийн дундаж хэмжээ ба лавлах хязгаар, Эрүүл мэндийн лаборатори, 2020, №11, ху 28-32.

Эрдэм шинжилгээний илтгэл олон улсад-1, дотоодод- 2

2. Gantuya P, Enkhjargal Ts, Khishigbuyan D, Sodnomtseren B, Altanchimeg N, Ganbileg D, Ankhtuya S, Naranbat N" Average Values and Reference Intervals for Blood Proteins of Mongolian Adults" Recent Advances in Immunology 2020 International Online Conference, October 16, 2020, S32
3. П.Гантуяа, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, Б.Содномцэрэн, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар "Цусны сийвэнгийн зарим уургуудын

- дундаж хэмжээ ба лавлах хязгаар”, Эрүүл дэлхийн төлөө цусаа бэлэглэцгээе-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 10 дугаар сарын 28, ЭШХ-ын эмхтгэл, 102-104
4. П.Гантуяа, Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, Б.Содномцэрэн, Н.Алтанчимэг, Д.Ганбилэг, С.Анхтуяа, Н.Наранбаатар “Цусны сийвэнгийн зарим уургуудын дундаж хэмжээ ба лавлах хязгаар”, Хүрэл тогоот-2020, ЭШ-ний хурал, 2020 оны 11 дугаар сарын 14, ЭШХ-ын эмхтгэл, 37-41х

ҮР ДҮН 6. ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЦУСАН ДАХЬ АМИНДЭМҮҮДИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ӨГҮҮЛЭЛ)

Эрдэм шинжилгээний өгүүлэл дотоодод-1

1. Ц.Энхжаргал, Д.Хишигбуян, П.Гантуяа, О.Анужин, Б.Содномцэрэн, Д.Ганбилэг, Н.Алтанчимэг, С.Анхтуяа, Н.Наранбат. Зарим витамин дундаж болон лавлах хэмжээг тодорхойлсон дүн. Монголын анагаах ухаан, 2022 он

Эрдэм шинжилгээний илтгэл олон улсад-1

2. Enkhjargal Tserennadmid, Khishigbuyan Davaakhuu, Gantuya Purevdorj, Anujin Otgonbaatar, Sodnomtseren Batbayar, Ganbileg Dashnyam, Altanchimeg Nyam-Orgil. Reference Intervals for Some Vitamins in Mongolian Adults. AACCC Scientific Conference 2022, Chicago, USA, July 24-28

РЕФЕРАТ

МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ БОЛОН ЛАВЛАХ ХЭМЖЭЭГ ТОГТООХ

Ц.Энхжаргал¹, П.Гантуяа¹, Д.Хишигбуян¹, Б.Содномцэрэн¹, Н.Алтанчимэг¹,
Д.Ганбилэг¹, О.Анужин¹, С.Анхтуяа², Н.Наранбат³

¹ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

² Улсын хоёрдугаар төв эмнэлэг

³ “Гялс” анагаах ухааны төв

Судалгааны үндэслэл

Хүний эрүүл мэндийн байдлыг үнэлэх, эмчилгээний явцыг хянах, мэс заслын үеийн хүндрэл гарах эсэхийг урьдчилан тооцоолоход хувь хүний хоол тэжээлийн байдлыг анхаарах шаардлагатай байдаг. Манай эмнэлгийн практикт өвчтөний хоол тэжээлийн байдлыг үнэлэхдээ нийт уураг болон альбумины түвшинг ихэнхдээ ашигладаг бол олон улсад уг зорилгоор тодорхой биомаркеруудын багц ашигладаг байна.

Ямарваа эмгэгийг оношлох, эмчилгээний явцыг хянахад лабораторийн шинжилгээний үр дүнг тохирох лавлах хэмжээтэй харьцуулан дүгнэлт гаргадаг. Гэвч одоогийн байдлаар манай эмнэлгийн лабораториудын шинжилгээний үр дүнг дүгнэхэд гадаадын төрөл бүрийн эх үүсвэрээс авсан лавлах хэмжээг баримталж байгаа нь шинжилгээний хариуны дүгнэлтийн үнэн зөв байдлыг бууруулах эрсдэлтэй. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Монгол хүний гематологи, биохимийн лабораторийн шинжилгээний үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоох судалгаа”- г оруулсан байдаг.

Тиймээс хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашиглах боломжтой биомаркеруудын багц боловсруулж, уг үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох шаардлагатай байна.

Судалгааны зорилго

Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашиглах биомаркеруудын дундаж болон лавлах хэмжээг тогтоох.

Судалгааны зорилтууд

Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан болно. Үүнд:

1. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусны гематологийн үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох
1. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элемент (төмөр, зэс, цайр)-үүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох
2. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисуудын дундаж болон лавлах хэмжээг тогтоох

3. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэмүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт орохоор ирсэн хүмүүсээс урьдчилан боловсруулж, батлуулсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан 19-69 насны эрэгтэй 170, эмэгтэй 170 нийт 340 хүнийг сонгон хамруулсан. Шалгуур үзүүлэлтийг агуулсан асуумжийг хариулахад хялбар “тийм”, “үгүй” гэсэн товч хариулттайгаар боловсруулсан. Судалгааны шалгуур хангасан хүмүүст судалгааны талаар мэдээллийг өгч, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн тохиолдолд таниулан зөвшөөрлийн хуудастай танилцуулж, бичгээр зөвшөөрөл авсан.

Судалгааны ёс зүй

Судалгааны аргачлалыг НЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн 2018 оны 06-р сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрлийг Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2018 оны №76 тогтоолоор олгосон болно.

Арга аргачлал

Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх биомаркеруудын дундаж болон лавлах хэмжээг тогтооходоо олон улсын Эмнэлзүйн лабораторийн стандартын хүрээлэн (ЭЛСХ, CLSI)-гээс боловсруулан баталсан “Эмнэлзүйн лабораторийн лавлах хэмжээ тогтоох” удирдамжийн дагуу шаардлага хангасан судлуулагчаас зөвшөөрөл авсны үндсэн дээр асуумж судалгаа авч хураагуур судаснаас өглөөний цусны дээжийг эмнэлгийн лабораторийн нөхцөлд стандарт аргаар авч цусанд нь нийт уураг, альбумины хэмжээг “Humalyzer 2000” хагас автомат анализатораар, Ц урвалжит уураг, преальбумин, трансферрин болон ретинол-холбох уургийн хэмжээг “ELX 880” маркийн бичил самбар уншигчаар, С, В₆, В₁₂, В₉ аминдэмүүдийн агууламжийг “Perkin Elmer” компанийн Flexar LC 6000 маркийн өндөр үзүүлэлтэт шингэний хроматографи (ӨҮШХ)-ийн багажаар, элемент (Zn, Cu, Fe)-үүдийн хэмжээг “Perkin Elmer” компанийн Aanalyst 400 атом шингээлтийн спектрометр (АШС) багажаар, цусны гематологийн үзүүлэлтүүд болох улаан эс, цагаан эс, лимфоцитууд болон гемоглобины хэмжээг гематологийн анализатораар хийж гүйцэтгэв. Шинжилгээний үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS болон Excel программуудыг ашиглан дундаж хэмжээний итгэлцлийн мужийг 95%-иар тогтоож, лавлах хязгаарын доод хязгаарыг тархалтын 2.5, дээд хязгаарыг 97.5 персентиль байхаар тус тус тооцоолон гаргав.

Судалгааны үр дүн

Цусны эсүүд болон гемоглобины лавлах хэмжээг тогтооход цусны цагаан эсийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд $3.98-9.11 \times 10^9$ /л, эмэгтэйчүүдэд $3.50-9.08 \times 10^9$ /л; цусны улаан эсийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд $4.69-6.04 \times 10^{12}$ /л, эмэгтэйчүүдэд $4.10-5.20 \times 10^{12}$ /л; гемоглобины лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 145-176 г/л, эмэгтэйчүүдэд 121.80-148.20 г/л; гематокритын лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 42.6-52.89 %, эмэгтэйчүүдэд 36.08- 44.74 % байв.

Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусны зарим элемент (төмөр, зэс, цайр)-үүдийн дундаж хэмжээг тогтооход төмөр 30.71 мкмоль/л, зэс

16.68 мкмоль/л, цайр 11.40 мкмоль/л байсан ба уг үзүүлэлтүүдийн хувьд хүйс хоорондын статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Цусан дахь элементүүдийн лавлах хэмжээг тогтооход зэсийн хувьд эрэгтэйчүүдэд 9.72-22.34 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 11.18-27.27 мкмоль/л; төмрийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 21.39-37.72 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 19.87-39.67 мкмоль/л; цайр эрэгтэйчүүдэд 8.20-14.92 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 8.52-16.67 мкмоль/л байв. Цусан дахь элементүүдийн лавлах хэмжээнээс харахад эмэгтэйчүүдийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдийнхээс бага зэрэг өндөр байгаа боловч уг ялгаа статистик ач холбогдолгүй байв.

Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисуудын дундаж хэмжээг тогтооход нийт уураг эрэгтэйчүүдэд 74.54 г/л, эмэгтэйчүүдэд 73.59 г/л; альбумин эрэгтэйчүүдэд 48.20 г/л, эмэгтэйчүүдэд 46.28 г/л; преальбумин эрэгтэйчүүдэд 332.43 мг/л, эмэгтэйчүүдэд 381.67 мг/л; трансферрин эрэгтэйчүүдэд 4.01 г/л, эмэгтэйчүүдэд 4.43 г/л; ретинол холбогч уураг эрэгтэйчүүдэд 1.73 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 2.01 мкмоль/л байв. Цусны ийлдсийн уургийн бодисуудын лавлах хэмжээг тогтооход нийт уураг эрэгтэйчүүдэд 55.26-95.79 г/л, эмэгтэйчүүдэд 58.38-84.72 г/л; альбумин эрэгтэйчүүдэд 37.14-60.01 г/л, эмэгтэйчүүдэд 34.97-57.60 г/л; преальбумин эрэгтэйчүүдэд 171.3-485.0 мг/л, эмэгтэйчүүдэд 215.5-535.0 мг/л; трансферрин эрэгтэйчүүдэд 2.20-6.92 г/л, эмэгтэйчүүдэд 2.58-7.05 г/л; ретинол холбогч уураг эрэгтэйчүүдэд 0.73-3.08 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 1.16-3.49 мкмоль/л байв. Цусан дахь уургийн бодисуудаас нийт уургаас бусад нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байв.

Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэмүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтооход С аминдэмийн нийт дундаж хэмжээ 10.76 мг/л, эрэгтэйчүүдэд 11.88 мг/л, эмэгтэйчүүдэд 9.62 мг/л, лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 1.40-19.40 мг/л, эмэгтэйчүүдэд 1.17-18.04 мг/л, В₁₂ аминдэмийн нийт дундаж хэмжээ 904.62 нг/л, эрэгтэйчүүдэд 938.45 нг/л, эмэгтэйчүүдэд 864.03 нг/л, лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 233-1597 нг/л, эмэгтэйчүүдэд 132.45-1623.86 нг/л байв. В₉ аминдэмийн нийт дундаж хэмжээ 7.56 нг/мл байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 8.47 нг/мл, эмэгтэйчүүдэд 6.91 нг/мл, лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 1.04-24.74 нг/мл, эмэгтэйчүүдэд 1.04-21.46 нг/мл байв. В₆ аминдэмийн нийт дундаж хэмжээ 39.22 нг/мл байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 44.42 нг/мл, эмэгтэйчүүдэд 34.67 нг/мл, лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 5.90-79.02 нг/мл, эмэгтэйчүүдэд 5.27-61.72 нг/мл байв.

Дүгнэлт

Энэхүү судалгааны дүнд тогтоосон монгол насанд хүрэгчдийн цусны уургийн бодисууд, зарим элементүүд, аминдэмүүд болон эсүүдийн лавлах хэмжээг өвчтөний хоол тэжээлийн байдлыг үнэлж, эмнэлзүйн шийдвэр гаргахад ашиглах боломжтой юм.

Түлхүүр үг

лавлах хэмжээ, хоол тэжээлийн байдал, элемент, уураг, аминдэм, гематологи

SURVEY ON DETERMINATION OF AVERAGE VALUES AND REFERENCE RANGES OF BIO-MARKERS TO ASSESS THE NUTRITIONAL STATUS OF MONGOLIANS

Enkhjargal Ts¹ Gantuya P¹, Khishigbuyan D¹, Sodnomtseren B¹, Altanchimeg N¹,
Ganbileg D¹, Anujin O¹, Ankhtuya S², Naranbat N³

¹ National Center for Public Health

² Second National Central Hospital

³ “Gyals” Medical Center

Survey rationale

The nutritional status of an individual needs to be considered in assessing his or her health, monitoring the progress of treatment, and predicting complications during surgery. In our medical practice, total protein and albumin levels are often used to assess the patient's nutritional status, while internationally, a set of specific biomarkers is used for this purpose.

To diagnose a disease and monitor the progress of treatment, the results of laboratory tests are compared with appropriate reference values. However, at present, our medical laboratories use reference values from various foreign sources to evaluate the test results, which may reduce the accuracy of the interpretation. The Action Plan for the Implementation of the State Health Policy includes a “Study to determine the reference values of hematology and biochemistry laboratory parameters of Mongolians”.

Therefore, it is necessary to develop a set of biomarkers that can be used to assess the nutrition status of Mongolians, and to determine the average and reference values of these indicators.

Purpose of the survey

Determine the average and reference value of biomarkers to be used to assess the nutritional status of Mongolians.

Objectives of the survey

Within the scope of the research, the following objectives were set. These include:

1. Determine the average and reference values of hematological parameters to assess the nutritional status of adults
2. Determine the average and reference values of some minerals in the blood (iron, copper, zinc) to assess the nutritional status of adults
3. Determine the average and reference values of proteins in the blood to assess the nutritional status of adults
4. Determine the average and reference values of vitamins in the blood to assess the nutritional status of adults.

Scope of the survey

A total of 340 people aged 19-69 (170 men and 170 women) who met the pre-developed and approved criteria were selected from those who came to the hospitals for preventive medical examinations. Questionnaires containing criteria were developed with

short “yes” and “no” answers that were easy to answer. Those who met the survey criteria were provided with information about the survey, and if they agreed to participate in the survey, they were introduced to the consent form and given written consent.

Ethics of the survey

The research methodology was discussed and approved at the meeting of the Scientific Council of NCPH on June 28, 2018. The ethical approval was issued by the 2018 №76 resolution of the Medical Ethics Review Committee of the Ministry of Health.

Methods

Survey participants were selected based on criteria described in the CLSI guidelines. Morning blood samples of the participants were collected under aseptic conditions. The levels of total protein and albumin were determined on “Humalyzer 2000” semi-automatic analyzer, “ELX 880” micro-plate reader was used for C reactive protein, prealbumin, transferrin and retinol-binding protein analyses. The amounts of vitamins C, B6, B12 and B9 were measured by Perkin Elmer's Flexar LC 6000 high performance liquid chromatography (HPLC) instrument. The concentrations of Zn, Cu, Fe were analyzed on Perkin Elmer's Analyst 400 Atomic Absorption Spectrometer (AAS). Red blood cells, lymphocytes, and hemoglobin were examined with a hematological analyzer. Statistical analysis of the test results was carried out using SPSS and Excel programs. The confidence interval was set at 95%, the lower limit of the reference interval was determined as 2.5 percentile and the upper limit as 97.5 percentile.

Results of the survey

The reference values of white blood cells were $3.98-9.11 \times 10^9$ /L for men and $3.50-9.08 \times 10^9$ /L for women; the red blood cells reference values were $4.69-6.04 \times 10^{12}$ /L in men and $4.10-5.20 \times 10^{12}$ /L in women; the reference values for hemoglobin were 145-176 g /L in men and 121.80-148.20 g /L in women; The reference values of hematocrit were 42.6-52.89% in men and 36.08-44.74% in women.

The mean levels of blood minerals were 30.71 μmol /L for iron, 16.68 μmol /L for copper, and 11.40 μmol /L for zinc, with no statistically significant differences between sexes. The reference values for copper were 9.72-22.34 μmol /L for men and 11.18-27.27 μmol /L for women; the reference values for iron were 21.39-37.72 μmol /L for men and 19.87-39.67 μmol /L for women; the reference values for zinc were 8.20-14.92 μmol /L in men and 8.52-16.67 μmol /L in women. The reference values of trace elements in the blood were slightly higher in women than in men, but the difference was not statistically significant.

The mean level of total protein was 74.54 g /L for men and 73.59 g /L for women; of albumin was 48.20 g /L in men and 46.28 g /L in women; of prealbumin was 332.43 mg /L in men and 381.67 mg /L in women; of transferrin was 4.01 g /L in men and 4.43 g /L in women; The mean concentration of retinol binding protein was 1.73 μmol /L in men and 2.01 μmol /L in women. The reference values for serum protein were 55.26-95.79 g /L for men and 58.38-84.72 g /L for women; for albumin were 37.14-60.01 g /L in men and 34.97-57.60 g /L in women; for prealbumin were 171.3-485.0 mg /L in men and 215.5-

535.0 mg /L in women; for transferrin 2.20-6.92 g /L in men and 2.58-7.05 g /L in women. With the exception of total protein in the blood, there were statistically significant differences between sexes.

The mean level of vitamin C was 10.76 mg /L, 11.88 mg /L for men, 9.62 mg /L for women, with the reference range of 1.40-19.40 mg /L for men and 1.17-18.04 mg/L for women. The mean amount of vitamin B12 was 904.62 ng /L, 938.45 ng /L for men, 864.03 ng /L for women, the reference values were 233-1597 ng /L for men and 132.45-1623.86 ng /L for women. The mean concentration of vitamin B9 was 7.56 ng / ml, of which 8.47 ng /mL was for men, 6.91 ng /mL was for women, and the reference range was 1.04-24.74 ng /mL for men, and 1.04-21.46 ng /mL for women. The mean level of vitamin B6 was 39.22 ng /mL, of which 44.42 ng /mL was for men, 34.67 ng /mL was for women, the reference values were 5.90-79.02 ng /mL for men, and 5.27-61.72 ng /mL for women.

Conclusion

The reference values for proteins, vitamins, minerals and blood cells determined in this research can be used for assessment of the nutritional status of Mongolian adults, and for clinical decision making.

Key words

reference values, nutritional status, minerals, proteins, vitamins, hematology

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Цэрэннадмид ЭНХЖАРГАЛ

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, БШУ-ы доктор, профессор, МАУА-ийн гишүүн, ЭШТА

(Судалгааны ажлын аргачлалыг боловсруулж, НЭМҮТ-ийн эрдмийн зөвлөл болон ЭМЯ-ы ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Судалгааны ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, удирдан ажилласан. Төслийн тайлан бичсэн, хянасан)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Пүрэвдорж ГАНТУЯА

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, ХУ-ы магистр, ЭШДэА, химич

(Судалгааны ажлын аргачлалыг боловсруулж, НЭМҮТ-ийн эрдмийн зөвлөл болон ЭМЯ-ы ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Судалгааны ажлын зохицуулагчаар ажиллан, судалгааны дээж цуглуулахад ахалж, цуглуулсан дээжинд шинжилгээ хийж, тайлан бичсэн)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Даваахүү ХИШИГБУЯН

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, БУ-ы магистр, ЭШДэА, Биохимич

(Судалгааны ажлын аргачлалыг боловсруулж, НЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Судалгааны дээж цуглуулахад оролцсон, амин дэм болон уургуудын шинжилгээний аргуудыг туршиж нэвтрүүлэн, цуглуулсан дээжинд шинжилгээ хийж, үр дүнгийн статистик боловсруулалтыг хийж, тайлан бичихэд оролцсон)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Батбаяр СОДНОМЦЭРЭН

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, ЭШДаА, Биохимич

(Судалгааны ажлын аргачлалыг боловсруулж, судалгааны дээж цуглуулахад оролцсон, эрдэсийн шинжилгээний аргуудыг туршиж нэвтрүүлэн, цуглуулсан дээжинд шинжилгээ хийж, тайлан бичихэд оролцсон)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Ням-Оргил АЛТАНЧИМЭГ

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, БУ-ы магистр, ЭШДаА, Микробиологич
(Судалгааны дээж цуглуулах багт орж ажилласан, цуглуулсан дээжинд эсүүдийг тодорхойлох шинжилгээ хийн, тайлан бичихэд оролцсон)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Дашням ГАНБИЛЭГ

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, НЭМ-ийн магистр, ЭШДаА, Химич
(Судалгааны дээж цуглуулах багт орж ажилласан, цуглуулсан дээжинд шинжилгээ хийхэд оролцсон, тайлан бичихэд оролцсон)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Отгонбаатар АНУЖИН

НЭМҮТ, НЭМЛЛ-ийн Хоол судлал, шим тэжээлийн лаборатори, Биохимич
(Шинжилгээ хийхэд оролцсон, тайлан бичихэд оролцсон)

Гарын үсэг:

2022 он сар өдөр

Улсын бүртгэлийн
дугаар

Аравтын бүрэн
ангилалын код

Нууцын зэрэглэл:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: *ШуСс-2018/29*

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

**“МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ
БИОМАРКЕРУУДЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ”
сэдэвт суурь судалгааны ажил**

Шинжлэх ухаан технологийн төслийн үр дүнгийн нэгдсэн тайлан

2018 - 2021 он

Төслийн удирдагч:	Ц.Энхжаргал, БШУ-ы доктор, профессор, МАУА-ийн гишүүн, НЭМҮТ, НЭМЛЛ-ийн ХСШТЛ-ийн эрхлэгч
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан, технологийн сан
Захиалагч байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Төслийн гүйцэтгэгч байгууллага:	НЭМҮТ, НЭМЛЛ, Хоол судлал, шим тэжээлийн лаборатори
Тайланг өмчлөгч:	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улаанбаатар хот, Энхтайваны гудамж 17, Утас:458545, цахим хаяг: www.ncph.gov.mn

Улаанбаатар хот

2022 он

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	17
ОРШИЛ.....	18
НЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ.....	18
ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	19
ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ.....	19
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ БАЙДАЛ.....	20
4.1 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх гематологийн үзүүлэлтүүд.....	20
4.1.1 Гемоглобин.....	22
4.1.2 Улаан эс.....	22
4.1.3 Цагаан эсийн тоо.....	23
4.2 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элементүүд.....	24
4.2.1 Элементүүдийн хүний бие организмд гүйцэтгэх үүрэг.....	25
4.2.2 Төмөр (Fe).....	25
4.2.3 Зэс (Cu).....	26
4.2.4 Цайр (Zn).....	27
4.3 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисууд.....	28
4.3.1 Нийт уураг.....	30
4.3.2 Альбумин нь.....	32
4.3.3 Преальбумин.....	33
4.3.4 Трансферрин.....	34
4.3.5 Ретинол холбогч уураг (РХУ).....	34
4.3.6 Ц урвалжит уураг (ЦУУ)-.....	35
4.4 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэмүүд.....	35
4.4.1 Пиридоксин (В ₆ аминдэм).....	36
4.4.2 Цианокобаламин (В ₁₂ аминдэм).....	37
4.4.3 Аскорбины хүчил (С аминдэм).....	38
4.4.4 Фолийн хүчил (В ₉ аминдэм).....	40
ТАВ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ.....	42
5.1 Судалгааны хамрах хүрээ, арга зүй.....	42
5.1.1 Хамрах хүрээ.....	42
5.1.2 Судалгааны ёс зүй.....	42
5.1.3 Лавлах хэмжээ тогтоох арга зүй.....	42
5.1.4 Лавлах хувь хүнийг сонгох.....	43
5.2 Шинжилгээний сорьц цуглуулах.....	43
5.3 Лабораторийн шинжилгээний аргууд.....	43
5.3.1 Цусан дахь гематологийн үзүүлэлтүүд тодорхойлох.....	43

5.3.2. Цусан дахь элемент (төмөр, зэс, цайр)-үүд тодорхойлох.....	43
5.3.3 Цусан дахь уургийн бодисууд тодорхойлох.....	48
5.3.4 Цусан дахь аминдэмүүд тодорхойлох.....	54
5.4 Судалгааны үр дүнд статистик боловсруулалт хийх.....	60
5.4.1 Лавлах хэмжээ тогтоох.....	60
5.4.2 Судалгааны мэдээллийн бааз үүсгэх, цэвэрлэх.....	61
5.4.3 Лавлах утгыг тогтоох статистик арга.....	61
5.4.4 Өгөгдлийн алдаанд нөлөөлөх хүчин зүйлийг тооцох.....	61
5.4.5 Судалгааны түүврийн хэмжээг тооцох.....	61
ЗУРГАА. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЦЭМЖ	63
6.1 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх гематологийн үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээ.....	63
6.2 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элемент (цайр, зэс, төмөр)-үүдийн дундаж болон лавлах хэмжээ.....	67
6.3 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисуудын дундаж болон лавлах хэмжээ.....	69
6.4 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэм (С, В12, В9, В6)-үүдийн дундаж болон лавлах хэмжээ.....	73
ДОЛОО. ДҮГНЭЛТ	78
НАЙМ. АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ	79
Хавсралт 1. Сдалгааны асуумжийн карт	
Хавсралт 2. Таниулсан зөвшөөрлийн хуудас	
Хавсралт 3. Цусны цайрын агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлох стандарт ажиллагааны заавар - САЗ:ША–3.9	
Хавсралт 4. Цусны зэсийн агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлох стандарт ажиллагааны заавар - САЗ:ША–3.10	
Хавсралт 5. Цусны төмрийн агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлох стандарт ажиллагааны заавар - САЗ:ША–3.11	
Хавсралт 6. Өндөр үзүүлэлтэт шингэний хроматографи (ӨҮШХ)-ийн багажаар биологийн дээжинд усанд уусдаг аминдэм (В ₆ , В ₉ , В ₁₂)-үүдийн агууламжийг тодорхойлох стандарт ажлын заавар САЗ:ША-3.12	
Хавсралт 7. Өндөр үзүүлэлтэт шингэний хроматографи (ӨҮШХ)-ийн багажаар биологийн дээжинд С аминдэмийн агууламжийг тодорхойлох стандарт ажлын заавар САЗ:ША-3.13	
Хавсралт 8. Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх лабораторийн үзүүлэлтүүд (магистрын диплом, илтгэл танилцуулга)	
Хавсралт 9. Төслийн үр дүнгийн нэгдсэн тайланд эрдэмтдийн өгсөн саналууд	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМЛЛ	Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лаборатори
АНУ	Америкийн нэгдсэн улс
ӨХСТ	Өвчний хяналт сэргийлэлтийн төв
БНБ	Биологийн нэмэлт бүтээгдэхүүн
ХЯТМ	Хэт ягаан туяаны муж
ШХ	Шингэний хроматографи
РХУ	Ретинол холбогч уураг
ЭДТА	Этилендиаминтетрацууны хүчил
ФХУ	Фермент холбоот урвал
ЦУУ	Ц урвалжит уураг
ӨҮШХ	Өндөр үзүүлэлтэт шингэний хроматографи
ФМН	Флавинмононуклеотид
ФДН	Флавиндинуклеотид
мкмоль/л	микромоль/литр
HRP	Horseradish peroxidase
HCL	Hollow cathode lamp
АЕ	Acrodermatitis enteropathica
ELISA	Enzyme linked immunosorbent assay

ОРШИЛ

Дэлхийн ихэнх улс орнуудад хоол тэжээлийн байдлыг оношлохын тулд ийлдсийн биомаркеруудыг тодорхойлж, эмчилгээ хийх нь эмчилгээний үр дүн, цаг хугацаа, эмчилгээний зардал хэмнэх ач холбогдол ихтэй байдаг байна. Лабораторийн шинжилгээгээр хоол тэжээлийн байдлыг үнэлэх нь эмнэлзүйн үнэлгээний аргуудаас илүү объектив, нарийвчлалтай арга юм. Лабораторийн шинжилгээ нь хоол тэжээлийн байдлын эмнэлзүйн дүгнэлтийн нотолгооны үндэс болдог.

Анх 1974 онд Баттеруорт [1] хэвтэн эмчлүүлж буй хүмүүсийн дунд хоол тэжээлийн дутагдал их байгааг судалж байсан ба хоол тэжээлийн дутагдалд орвол эмгэгээс нөхөн сэргээх явц удааширч, хүндрэлүүд болон нас баралт нэмэгддэг болохыг олон судалгаагаар баталсан байна [2]. Гэсэн хэдий ч хоол тэжээлийн дутагдалтай байсан ч эрт үед илрүүлж, зохистой хоол тэжээлийн хангамжаар дээр дурдсан эрсдлийг бууруулах боломжтой [3].

Сүүлийн үед хүний хоол тэжээлийн байдалд ихээхэн ач холбогдол өгч судлах нь нэмэгдсэн ба хоол тэжээлийн байдлыг зөв үнэлэх, хоол тэжээлийг зохих ёсоор хангаж байгаа эсэхийг тодорхойлох янз бүрийн үнэлгээний аргууд байдаг. Тэдгээрийн дотроос мэс заслын өмнөх болон дараах үеийн хоол тэжээлийн байдал, хоол тэжээлийн дэмжлэгийн зохистой байдлыг бодитой үнэлэхэд биомаркеруудыг ашиглаж ирсэн байна. Хоол тэжээлийн байдлыг үнэлэх, хоол тэжээлийн тодорхой дутагдлыг тодорхойлохын тулд гадаадын орнуудад уураг, аминдэм, эрдэс бодис болон цусны эсүүдийн үзүүлэлтийн лабораторийн үр дүнг ашигладаг.

Хувь хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний эмчилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын хэмжээнд баталгаажсан нэгдсэн арга зүйг өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлснээр эрүүл мэндийн судалгаа болон өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулах юм.

Судалгаанд орчин үеийн лабораторийн болон статистик дүн шинжилгээний аргуудыг ашиглан 19-өөс дээш насны хүн амыг хамруулан клиник химийн багц үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тодорхойлж, шинжлэх ухааны үндэстэй бодит тоо баримтыг гаргаснаар эмнэлгийн практикт нэвтрүүлэх чухал ач холбогдолтой юм. Энэ нь манай улсын Засгийн газраас хүн амын эрүүл мэндийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг олон улсын шаардлагад нийцүүлэн, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдэж байгаа ба судалгаанд хамрагдагсад, тэдний олон нийтийн эрх ашиг, хүсэл эрмэлзэлд бүрэн нийцэх болно.

НЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Хүний эрүүл мэндийн байдлыг үнэлэх, эмчилгээний явцыг хянах, мэс заслын үеийн хүндрэл гарах эсэхийг урьдчилан тооцоолоход түүний хоол тэжээлийн байдлыг анхаарах шаардлагатай байдаг. Манай эмнэлгийн практикт өвчтөний хоол тэжээлийн байдлыг үнэлэхдээ нийт уураг болон альбумины түвшинг ихэнхдээ

ашигладаг бол олон улсад уг зорилгоор тодорхой биомаркеруудын багц ашигладаг байна.

Ямарваа эмгэгийн оношилгоо болон эмчилгээний явцын хяналтанд лабораторийн тохирох шинжилгээний үр дүнг ашигладаг. Гэвч одоогийн байдлаар манай лабораториуд шинжилгээний үр дүнг дүгнэхэд гадаадын төрөл бүрийн эх үүсвэрээс авсан лавлах хэмжээг баримталж байгаа нь шинжилгээний хариуны дүгнэлтийн үнэн зөв байдлыг бууруулах эрсдэлтэй. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Монгол хүний гематологи, биохимийн лабораторийн шинжилгээний үзүүлэлтийн лавламж хэмжээг тогтоох судалгаа хийх”-ийг оруулсан байдаг.

Тиймээс хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашиглах боломжтой биомаркеруудын багц боловсруулж, уг үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох шаардлагатай байна.

ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашиглах биомаркеруудын дундаж болон лавлах хэмжээг тогтоох.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛТУУД

Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан болно. Үүнд:

1. Хоол тэжээлийн байдлыг үнэлэх биомаркеруудыг тодорхойлох лабораторийн шинжилгээний арга боловсруулж, нэвтрүүлэх.
2. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусны гематологийн үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох.
3. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элементүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох.
4. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисуудын дундаж болон лавлах хэмжээг тогтоох.
5. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэмүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох.
6. Судалгааны үр дүнд үндэслэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж, хэвлүүлэх орсон болно.

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ

Өвчний эмчилгээний үр дүнд тухайн өвчтөний хоол тэжээлийн байдал багагүй нөлөөлдөг. Өвчний эдгэрэх явц, эмчилгээ авах боломж зэргийг тооцоход өвчтөний хоол тэжээлийн байдлын үнэлгээ хийх шаардлагатай байдаг. Уг үнэлгээг хийхэд ашигладаг лабораторийн үзүүлэлтүүдийн багцыг боловсруулснаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх, үүгээр тэдний эмчилгээний үр дүнг сайжруулах боломжтой болно.

Манай эрүүл мэндийн лабораториудын шинжилгээний үр дүнг дүгнэхэд гадаадын эх сурвалжуудаас авсан лавлах хэмжээг ашигладаг. Монгол хүний биохимийн болон гематологийн зарим үзүүлэлтүүдийн лавлах хэмжээг лабораторийн олон улсын байгууллагын баталсан аргаар тогтоосноор манай эмнэлзүйн лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн гаргасан дүгнэлт баталгаатай болно.

ДӨРӨВ. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хүний хоол тэжээл бол хүний бие махбодийн өсөлт, хөгжил, физиологи, бодисын солилцоо, бүтэцтэй холбоотой шинжлэх ухаан юм [4]. Хоол тэжээлийн бодит судалгаа нь 18-р зууны эхэн үеэс эхлэн Францын химич Лавоисер хоол тэжээлийн бодисын солилцоо, амьсгалын үйл явцын хоорондын холбоог илрүүлсэнээр эхэлсэн байдаг. 20-р зууны эхэн үеэс эрдэмтэд зарим нэг өвчний эмчилгээнд тодорхой төрлийн хоол хүнсийг хэрэглэж байсан байна [5, 6].

Эмнэлзүйн хоол тэжээлийн ухаан нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний эмчилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эмнэлзүйн хоол тэжээлийн зорилго нь өвчтөний эрүүл бодисын солилцоог тэнцвэржүүлэх явдал юм. 1939 онд Бигвүүд (Bigwood) хүний хоол тэжээлийн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг судлан үнэлгээ хийж, доорх 4 үндсэн хэмжигдэхүүнүүдийн багцыг боловсруулсан байна [7]. Үүнд:

1. Антропометрийн үнэлгээ
2. Клиник химийн үзүүлэлтүүд
3. Эмнэлзүйн ажиглалт ба үзлэг
4. Хооллолтын түүх

Эдгээр хэмжигдэхүүнүүд нь хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл юм. Хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлсэн мэдээлэл асар их байдаг ч өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд дараах хоёр шалтгааны улмаас шууд хэрэглэх боломжгүй байдаг. Нэгд, хүн амын хоол тэжээлийн байдлын үнэлгээнд олон төрлийн үнэлгээний үзүүлэлтүүдийг хэрэглэдэг, хоёрт, үнэлгээний стандарт аргууд нь хувь хүнд биш харин хүн амд хэрэглэхэд тохиромжтой байдаг. Эмнэлгийн үйлчилгээнд хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд клиник химийн багц үзүүлэлтүүдийг ашигладаг. Үүнд: уургийн бодисууд, аминдэмүүд, эрдэс бодисууд ба цусны зарим эсүүд орно.

4.1 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх гематологийн үзүүлэлтүүд

Цус нь төрөл бүрийн эс (ялтсан, цагаан, улаан эс), түүний хэсгүүд, дүрст элементийн цогц плазман шингэн бөгөөд зөөвөрлөх, зохицуулах, хамгаалах зэрэг олон үйл ажиллагааны үүргийг гүйцэтгэнэ.

1. Ходоод гэдэсний зам болон уушигнаас шим тэжээлийн бодис, хүчилтөрөгчийг биеийн бусад эсүүдэд зөөвөрлөдөг. Мөн бие эрхтний үйл ажиллагаа, бодисын солилцооны үр дүнд үүссэн илүүдэл бүтээгдэхүүн, нүүрсхүчлийн хийг зөөвөрлөх, дотоод шүүрлийн булчирхайнаас ялгарч буй дааврыг шаардлагатай эсэд зөөвөрлөх

2. Биеийн температурыг хэвийн хэмжээнд байлгахад туслах, биеийн шингэний рН-ийн түвшинг зохицуулах
3. Дархлааны хариу урвал, цус бүлэгнэлт зэрэг хамгаалалтын үйл ажиллагааг явуулдаг [8].

Цусны эсийн үүсэл хөгжил, ялгаран хөгжих явцад шим тэжээлийн болон эрдэс бодисууд чухал үүрэгтэй. Тухайлбал: Кальци ба К аминдэм ялтсан эсийн бүлэгнэлтийн үйл ажиллагаанд оролцдог бол цусны улаан эсийн үүсэл хөгжил, дүрст элементийн нийлэгжил, улаан эс бий болох процесст кобальт, зэс, төмөр, А, В₆, В₁₂ аминдэмүүд болон эрдэс бодисууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үүнээс гадна улаан эсийн хэвийн нийлэгжил (морфологи, физиологийн хэвийн үйл ажиллагаа) явуулахад фолийн хүчил, В₁₂ аминдэм тодорхой хэмжээгээр шаардагдах ба ДНХ-ийн нийлэгжилд шаардлагатай фолийн хүчлийн хувиралд В₁₂ аминдэм коэнзимийн үүрэг гүйцэтгэнэ.

Харин зэс, Е аминдэм, фосфор болон бусад шимт бодисууд нь ДНХ, РНХ-ийн нийлэгжилд оролцохоос гадна гемоглобины нийлэгжилд мөн оролцдог бөгөөд В₂ аминдэм, флавинонуклеотид (ФМН), флавиндинуклеотид (ФДН)-ын кофактор болсноор В₁₂, фолийн хүчил, В₆ зэрэг аминдэмүүд бодисын солилцооны процесст дэмжлэг үзүүлдэг [9].

Бас нэгэн чухал эрдэс болох төмөр нь цитохромын найрлагад агуулагддаг ба митохондрын амьсгалын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн ДНХ-ийн нийлэгжил, РНХ-ийн транскрипцийн процесс, бодисын солилцоонд оролцдог ферментийн нийлэгжилд шаардлагатай. Мөн цусны улаан эсийн гемоглобины үндсэн найрлагад орохоос гадна цагаан эсийн ялгаран хөгжих явцад зайлшгүй хэрэгцээтэй байдаг. Ийм учраас төмөр хангалтгүй нөхцөлд цагаан эс төмрийг нөөцөлдөг [8]. Мөн А аминдэм нь цусны цагаан, улаан, ялтсан эсийн ялгаран хөгжих процесст эерэг нөлөө үзүүлдэг.

Цусны эсийн үүсэл хөгжилд их хэмжээний энерги шаардагдах бөгөөд хүн хангалттай хэмжээний илчлэгийг гаднаас авч байж бодисын солилцооны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ [10].

Шим тэжээлийн дутагдалд орсны улмаас хэд хэдэн төрлийн цус багадалтад хүргэдэг. Түгээмэл тохиолддог өвчлөлийн хэлбэр нь төмөр дутлаас үүдсэн цус багадалт юм. Төмөр нь ДНХ-ийн нийлэгжил, эсийн бодисын солилцоонд, улаан эсийн үүсэл хөгжилд оролцдог учраас төмрийн дутагдлаас болж улаан эсийн ялгаран хөгжих процесст сөрөг нөлөө үзүүлдэг байна. Ингэснээр гемоглобины нийлэгжилд саад учруулж улаан эсийн хэмжээ, өнгөний өөрчлөлтөөс өвчлөл үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг. Улаан эсийн тоо бага байхад гемоглобины хэмжээ ч мөн адил бага байх бөгөөд энэ нь эсийн түвшинд хүчилтөрөгч хангалтгүй байгааг илтгэнэ. Цусны улаан эсийн үүсэл хөгжлийн явц хэвийн явагдаж байгааг цусан дахь улаан эсийн эргэлтийн тоо, хүчилтөрөгчөөр хэрхэн хангагдаж байгаагаар нь тодорхойлж болно [11].

Хүний хооллолтын байдал, шим тэжээлийн бодисын хэрэглээнээс хамаарч цусны гематологийн үзүүлэлтэд нөлөөлдөг бөгөөд энэ үзүүлэлтийг харгалзан өвчтөний эмчилгээний үеийн хооллолтыг зохицуулсанаар бодисын солилцоог тэнцвэржүүлдэг. Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд цусны улаан, цагаан эсийн агууламж, гемоглобин, гематокритын үзүүлэлт нь чухал бөгөөд монгол хүний

хувьд эдгээр үзүүлэлтийн дундаж болон лавлах хэмжээг тодорхойлох судалгааг хийх шаардлагатай байна. Бусад улс орон өөрийн бүс нутгийн хэмжээнд мөрдөх гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоох судалгаа хийгдсээр байна. Судалгаануудын дүнд өөрийн орны лавлах хэмжээг тогтоож ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан байна [12].

4.1.1 Гемоглобин нь улаан эсэд агуулагдах хүчилтөрөгч тээвэрлэгч уураг юм. Гемоглобин нь улаан эсийн нийт жингийн 34%, хуурай бодисын 90%-ийг эзэлдэг [13]. Гемоглобин нь хүчилтөрөгч ба нүүрсхүчлийн хийг уушиг болон бусад эрхтэнүүд, эсүүдийн хооронд тээвэрлэх үйл явцад оролцон, цусны хүчил шүлтийн тэнцвэрийг тогтоон барьж байдаг.

Цусан дахь гемоглобины хэмжээ хангалтгүй үед хүчилтөрөгчийг эд эрхтэнд хүргэх явцад хүндрэл үүсч эсүүд хангалттай хүчилтөрөгч авч чадахаа байснаас үүдэн бодисын солилцоо болон бусад үйл ажиллагаа нь алдагддаг [14]. Цусан дахь гемоглобин нь уушигнаас бие махбодийн бусад хэсэгт хүчилтөрөгчийг зөөвөрлөдөг. Эрүүл хүний 100 мл цусанд 12-20 грамм гемоглобин агуулагддаг. Гемоглобин нь олон дэд нэгж бүхий глобуляр уураг, уургийн дөрөвдөгч бүтэцтэй. Ихэнхи гемоглобины амины хүчил альфа мушгиа утаслагтай, тэдгээр нь мушгиа бус богино сегментүүдтэй холбогддог. Хүчилтөрөгчөөр хангагдсан байдлаар нь оксигемоглобин болон дезоксигемоглобин гэж ангилдаг [15].

4.1.2 Улаан эс нь эд, эсэд хүчилтөрөгчийг зөөвөрлөдөг. Улаан эсийн уян хатан ба хэлбэрээ өөрчлөх чадвар нь цусны реологийн шинж чанарыг тодорхойлогч гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд түүнээс захын бичил эргэлт, эд эсийн хүчилтөрөгч, тэжээлийн бодисын хангамж шууд хамаардаг. Мөн улаан эсийн хэлбэрээ өөрчлөх чадвар түүнийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүд нь янз бүрийн шалтгаантай бодисын солилцооны алдагдал, эмгэг өвчнүүдийн үед амархан өөрчлөгдөж байдаг эмзэг үзүүлэлт юм [16].

Бүтэц: Хүний улаан эсийн диаметр 6.2-8.2 мкм голчтой, 2-2.5 мкм зузаан, төв хэсгээрээ 0.8-1 мкм хэмжээтэй, хүний хамгийн жижиг эсэд тооцогддог. Насанд хүрсэн хүнд ойролцоогоор 20-30 триллион улаан эс байдаг ба нийт эсийн 70%-ийг бүрдүүлнэ. Улаан эсийн нэг удаагийн бүтэн эргэлтийн хугацаа 60 секунд орчим байдаг. Улаан эс нь тогтворгүй, уян хатан бүтэцтэй, бусад эстэй наалдах, дархлааны эстэй холбогдох чадвартай байдаг нь түүний мембраны шинж чанартай холбоотой. Эсийн мембран нь 3 давхар бүтэцтэй, гадна талын гликокаликс нь нүүрс усаар баялаг, харин липидийн давхар нь олон тооны трансмембраны уургуудтай байдаг.

Үйл ажиллагаа: Судас агших үед цусны улаан эс аденозин трифосфатыг ялгаруулан судасны ханыг тэлж, цусны урсгалыг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлнэ. Мөн гемоглобины молекул хүчилтөрөгчөөр дутагдахад улаан эс S-нитрозотиол хэмээх органик нэгдлийг ялгаруулж судасны ханыг тэлж хүчилтөрөгчөөр дутагдсан хэсэгт шууд үйлчилдэг. Үүнээс гадна улаан эс нь L-аргининыг субстрат болгон NO-г нийлэгжүүлэх чадвартай ба энэ нь судасны даралтыг зохицуулахад оролцдог. Бас нэгэн чухал үүрэг нь гемоглобин чөлөөт

радикалыг ялгаруулснаар өвчин үүсгэгч организмын эсийн хана болон мембранд үйлчилж үхүүлэх үйлчилгээ үзүүлэн дархлааны хариу урвалд оролцоно [17].

Улаан эсийн тоо цөөрөх нь элэгний дутагдал, цирроз өвчин, жирэмслэлт, цус багадалтын үед нийтлэг тохиолддог. Улаан эсийн тоо олшрох нь эритроцитоз, гемоглобинпати, шингэн алдалттай (шингэн өтгөрөлттэй) хүмүүст элбэг тохиолддог. Улаан эсийн тоо багасах нь төмрийн дутагдал, В₆, В₁₂ аминдэм фолийн хүчил дутагдалын үед тохиолддог [18]. Зарим ферментийн идэвхи нь улаан эсийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой байдаг. Жишээ нь: транскетолаза ферментийн идэвхи. Цусны улаан эсийн транскетолазын үйлдэл нь тиамин (В₁ аминдэм)-ы дутагдалд өртөхөөс сэргийлдэг ба Верникегийн энцефалопати болон В₁ аминдэмийн дутлын хам шинжийг оношлоход ашигладаг [19].

4.1.3 Цагаан эсийн тоо нь зарим төрлийн халдвар буюу эмчилгээний үед эсвэл архаг цус багадалт, хоол тэжээлийн дутагдал, анафилакс зэрэг тодорхой нөхцлүүдийн үед буурч болно [20]. Цагаан эс нь биед нэвтэрсэн гадны биет, халдварт өвчин үүсгэгчийн эсрэг үйлдэл үзүүлдэг дархлааны эс юм. Бүх цагаан эс ясны чөмөг (үүдэл эсээс)-нөөс үүсэж хөгждөг. Цагаан эсийг бүтцээс нь хамаарч гранулоцит агранулоцит, харин эсийн гарал үүслээр нь миелоид эс, лимфоид эс гэж ангилдаг.

Цагаан эсийн төрөл: Нейтрофиль, эозинофиль, базофиль, лимфоцит, моноцит

Нейтрофиль эс: Цусанд эргэлдэж буй цагаан эсийн 60-70%-ийг эзэлдэг. Бактери болон мөөгөнцрийн халдварын эсрэг үйлдэл үзүүлдэг [21].

Лимфоцит: Лимфоцит нь дархлааны тогтолцоонд чухал ач холбогдолтой цагаан эсийн нэг төрөл бөгөөд *лимфоцит* нь эсийн ба шингэний дархлаанд оролцоно. Өвөрмөц авуурынхаа тусламжтайгаар гадны зүйлийг ялган таних чадвартай юм. Лимфоцит нь биед гаднаас орсон эсрэгтөрөгчийг оноох өвөрмөц биеийг үүсгэх, өөрийн хуучирч гэмтсэн болон хувьсан өөрчлөгдсөн эсийг цаг ямагт устгаж хоргүйжүүлдэг [23]. Насанд хүрсэн хүний нийт цагаан эсийн 20-40%-ийг эзэлдэг. Эдгээр нь цусны эргэлтэнд оршдог ба тунгалгийн булчирхайн эрхтэн, эдүүдэд төвлөрсөн байдаг [22].

Цагаан эсийн тоо цөөрөх нь ясны чөмөгний дутагдал эсвэл нэвчилт, элэгний дутагдал (ж.нь В₁₂, төмөр дутагдал) элэг, дэлүү өвчин, хүнд халдварууд, ясны чөмөгний эмгэг, цацрагийн эмчилгээ, антибиотик гэх мэт хэрэглэх үед элбэг тохиолдоно.

Цагаан эсийн тоо олшрох нь халдвар, чөмөгний бус хавдар, үе мөчний болон гэдэсний өвчин зэрэг үрэвсэлт нөхцөл байдал, шингэн алдалт, үрэвсэл, астма, жирэмслэлт, харшилтай, эд гэмтэх, стресс эсвэл цус алдалт, таргалалттай холбоотой (таргалалтын эх суурь нь 10-19 насны хооронд ихэвчлэн үүсдэг) байх боломжтой. Таргалалт, биеийн жинтэй хамааралтайгаар болон хамааралгүйгээр өсвөр насны хүүхдийн (10-19 насны) цусны цагаан эсийн тоо болон бодисын солилцооны өөрчлөлт, хоол тэжээлийн нөхцөл байдлын хамаарлыг судлахад өсвөр насны хүүхдүүдэд хоол тэжээлийн нөхцөл байдал нь цагаан эсийн тоо өндөр байгаа таргалалттай, илүүдэл жинтэй болон үрэвсэлт үйл явцтай холбоотой байна.

Хүний хоол тэжээлийн байдлыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг бол дархлааны байдал юм. Хоол, шим тэжээлийн дутагдалтай үед цагаан эсийн тоо буурах байдал ажиглагддаг. Цайр, магни, төмөр, селени, А аминдэм, С аминдэм, уургийн дутагдлын үед Т- эсийн гажиг, цайр, А аминдэм, уургийн дутагдлын үед В- эсийн гажиг, Е аминдэмийн дутагдлын үед Моноцит эсийн гажиг, зэс, С аминдэм, уургийн дутагдлын үед уламжлалт дархлалын хариу урвалын гажилт, А аминдэм дутагдах үед лимфоцитын түвшин буурах, зэс дутагдахад нейтрофил эс цөөрөх, Е, В₂, В₆, В₁₂, фолийн хүчил, төмөр, зэс, уураг дутагдах үед цус багадалтанд хүргэдэг байна [19].

4.2 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элементүүд

Эрдэс бодис нь уураг, өөх тос, нүүрс ус шиг энерги нөөцлөхгүй ч амьд биеийг эрдэс бодисгүйгээр төсөөлөх аргагүй юм. Бие махбодь эрдсийн дутагдалд маш мэдрэмтгий учраас үүнээс үүсэлтэй эмгэг өөрчлөлт илэрдэг. Эрдэс бодис нь эд эсийн бодисын солилцоонд чухал үүрэгтэй. Жишээлбэл: фосфор, кальци зэрэг эрдэс бодис ясны эдийг төлжүүлэхэд, төмөр цусны улаан эсийн хүчилтөрөгч зөөвөрлөхөд, натри кали зэрэг нь эсийн гадаад дотоод даралтыг бүрдүүлэх гол үүргийг гүйцэтгэнэ. Эрдэс бодис нь ус, давс, хүчил - шүлтийн тэнцвэрт байдлыг хангахад чухал үүрэгтэй тул тодорхой эрдэс бодисын оролцоогүйгээр бие махбод оршин тогтох аргагүй юм. Бие махбодын 1-2%-ийг бүрдүүлдэг бөгөөд эрдэс бодисыг макро эрдэс (Ca, P, Mg, Na, K, Cl, S), бага агууламжаар шаардагддаг эрдэс бодисыг микро эрдэс (Fe, Zn, Cu, I, F), харин 0.001%-иас бага хэмжээгээр шаардагддаг эрдэс бодис (Co, Mo, Se, Ni, W, B, Mn) гэж ангилдаг.

Эдгээр элементүүдийн хэрэглээ хангалтгүй байвал организмын хэвийн үйл ажиллагаанд сөрөг өөрчлөлт гарч болзошгүй юм. Эрдэсүүдийн дутагдал үхэлд ч хүргэж болно. Үүнийг тухайн элемент бүтцэд нь оролцох ферментийн идэвхи буурдгаар тайлбарлана. Элементийн хэмжээ хэвийн хэмжээнд байхад ферментийн үйл ажиллагаа хэвийн явагдах ба элементийн хэмжээ нэмэгдэхэд хариу урвал өсч хэвийн хэмжээнд хүрнэ.

Цаашид хэмжээ нь өсөхөд тухайн элементийн илүүдэл бий болж хорт үйлчлэл үзүүлнэ. Илүүдэж буй элемент бие организмаас гадагшлахгүй бол мөн л үхэлд хүргэнэ. Микро эрдсийн организм дахь тархалт нь тэдгээрийн химийн шинж чанараас хамаарч харилцан адилгүй байна [24]. Тухайлбал, эрдэс бодис төмөр нь гемоглобин, миоглобин болон будагч бодисын бүрэлдэхүүн хэсэг тул хүчилтөрөгчийг шингээж хуримтлуулах, бүх эд эсэд зөөвөрлөхөд оролцоно. Эрдэс бодисын солилцоо хямрах үндсэн хэд хэдэн шалтгаан байдаг. Үүнд:

- Хоногт хэрэглэж буй хоол хүнсний эрдэс бодисын агууламж хангалтгүй байх
- Хоол тэжээлийн бүрэлдэхүүн хэсгийн зохимжгүй харьцаа, уураг, тос, нүүрс ус, аминдэм зэрэг шимт бодисын хэмжээ дутагдалтай, эсвэл илүү байх
- Физиологийн төлөв байдалтай холбоотойгоор эрдэс бодисын хэрэгцээ хувирахад хоол, хүнсний бүтцээ өөрчлөх талаар зохих арга хэмжээ авахгүй байх – жишээлбэл, дулаан нөхцөлд ажиллах үед кали, натри, хлор болон бусад эрдэс бодисын ихэнх хэсэг нь организмаас хөлстэй хамт ялгарах тул хэрэгцээ нь өсдөг [25].

4.2.1 Элементүүдийн хүний бие организмд гүйцэтгэх үүрэг

Химийн элемент нь эрдэс давс, ион, нийлмэл нэгдэл болон органик бодисын хэлбэрээр амьд организмын бүрэлдэхүүнд багтах бөгөөд өдөр бүр хоол хүнсээрээ дамжуулан авах шаардлагатай үл орлогдох шимт бодис юм. Хоол хүнсээрээ дамжуулан авч буй химийн элементүүдийн хэмжээ тогтмол байх шаардлагатай. Эдгээр шимт бодисын хоногийн хэрэгцээг эрдэмтэд тооцож гаргасан байдаг. Мөн түүнчлэн химийн элементүүд нь өдөр бүр бие организмгаас тодорхой хэмжээгээр ялгарч байх ёстой. Өөрөөр хэлбэл, бие организм дахь агууламж нь харьцангуй тогтмол түвшинд байна. Эрдэс бодис нь хоол тэжээлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг биш боловч хүний бие организмд олон чухал үүрэг гүйцэтгэнэ [24].

Эрдэс бодис нь биологийн шингэнд агуулагдаж осмос даралтыг хэвийн түвшинд барих үндсэн үүргийг гүйцэтгэдэг. Осмос даралтын түвшин тогтмол байх нь эс, эдийн хэвийн оршин тогтнох үндсэн нөхцөл юм. Эрдэс бодис нь нарийн нийлмэл бүтэцтэй органик нэгдлийн бүтцэд оролцохоос гадна яс, шүдний эдийг нөхөн сэлбэх материал болно. Мөн ионы хэлбэрээр мэдрэлийн импульс дамжуулахад оролцох бөгөөд цус бүлэгнэх, физиологийн бусад процесст чухал нөлөө үзүүлнэ [27].

4.2.2 Төмөр (Fe) нь цус төлжих процесст оролцох нэгдлийн нийлэгжилтэд зайлшгүй чухал шаардлагатай. Мөн түүнчлэн дархлалын болон исэлдэх-ангиграх урвалд оролцох бөгөөд цитоплазм ба эсийн цөм, зарим ферментийн бүрэлдэхүүнд багтдаг. Бие махбодод зайлшгүй хэрэгтэй төмрийн ихэнхийг амьтны ба ургамлын гаралтай хоол тэжээлийн хамт, үлэмж бага хэсгийг устай хамт авдаг. Хүний бие махбодын төмрийн 60-70 % гемоглобинд, 3-5 % булчингийн миоглобулинд, 16 % ферритин ба гемосидеринд агуулагдах ба үлдсэн хэсэг нь төмөр агуулдаг каталаза, пероксидаза, цитохром гэх мэт 13 ферментийн найрлаганд оролцдог [26].

Төмрийн шимэгдэлтэнд хурган чихний хүчил, фитин саад учруулна. Харин уг эрдэс организмд шингэхэд В₁₂ аминдэм зайлшгүй шаардлагатай. Мөн аскорбины хүчил төмрийн шимэгдэлтэнд эерэг нөлөө үзүүлнэ. Учир нь төмөр бие организмд 2 валенттай ион хэлбэрээр шимэгддэг онцлогтой юм. Төмөр хүний бие организмд дутагдсанаар цус багадалт өвчин үүснэ. Мөн хийн солилцоо, эсийн амьсгал зэрэг амьсгалыг тэтгэх бүхий л тулгуур процессийн хэвийн үйл ажиллагаанд оролцдог. Төмөр дутлын байдал нь дараах нөхцөлд нэмэгдэнэ. Үүнд: Хоногт хэрэглэж буй хоол хүнсэнд төмрийн хэмжээ хангалтгүй байх, ходоодны шүүрлийн идэвхи буурах, аминдэм (ялангуяа В₁₂, мөн фолийн болон аскорбины хүчил)-ийн дутагдал, цус алдах зарим төрлийн өвчин үүсэх гэх мэт. Зөв, зохистой хооллолт нь насанд хүрэгчдийн төмрийн хоногийн хэрэгцээ (14 мг/хоног)-г бүрэн хангаж чаддаггүй. Гэвч нарийн ширхэгтэй гуриланд төмрийн агууламж нь маш бага байдаг тул гурил, гурилан бүтээгдэхүүнийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэх төмрийн дутагдалд хүргэх нь түгээмэл байдаг [102]. Мөн түүнчлэн үр тариагаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь фосфат, фитинээр баялаг юм. Эдгээр нэгдэл нь төмөртэй холбогдон уусах чадвар багатай нэгдэл үүсгэж төмрийн шимэгдэлтийг бууруулна. Төмөр нь малын дайвар бүтээгдэхүүн, мах, өндөг, шош, жимс, жимсгэнэ, хүнсний ногоонд ихээр агуулагддаг [24].

Хүний цусны сийвэнгийн 0.1% орчим төмөр трансферрин байдлаар агуулагдана. Цусны гемоглобин бол глобин хэмээх уураг, төмөр агуулсан гем 2-оос тогтсон нийлмэл уураг юм. Гем нь протопорфирин төмөртэй нэгдсэн нэгдэл мөн. Орчин үед гемийн нийлэгжих зам нь тодорхой судлагджээ. Гемийн бионийлэгжлийн үе шат нь тодорхой бүлэг хэсгүүдийн тусламжаар явагддаг. Гемийн нийлэгжил алдагдах гол шалтгаан нь эритробластад агуулагдах төмрийн дутагдал юм.

Гемоглобины задралын үед чөлөөлөгдсөн төмөр нь ферритин байдлаар хадгалагдаж гемоглобины дахин нийлэгжихэд оролцоно. Хөлс ба шээсээр төмөр бага ялгарна. Ясны чөмгөнд агуулагдах төмөр нь хоногийн төмрийн хэрэгцээг 5 дахин хангах хэмжээний «хөдөлгөөнт» хэлбэрийн төмөр агуулдаг. Энэ нь цусны сийвэнгийн төмөртэй богино хугацаанд солилцоонд орох чадвартай байдаг. Элэг, дэлүүнд төмөр их хэмжээгээр агуулагддаг. Бие махбодын хэрэгцээтэй зохицож төмөр шимэгдэж байдаг учраас хэрэгцээ шаардлагагүй үед хоолтой хамт орсон төмөр бараг тэр хэвээрээ өтгөнөөр гардаг.

Төмөр нь ходоод, 12 хуруу гэдэс, нарийн гэдэсний эхний хэсэгт шимэгдэх бөгөөд органик биш төмөр органикаасаа илүү шимэгдэнэ. Ходоодны шүүсний хүчиллэг чанараас хамаарч хоол хүнсний төмөр ионжсон хэлбэрт шилждэг. Ингэж ионжсон төмөр органик төмрийг бодвол амархан шимэгдэнэ.

Жирэмслэх, цус алдах, хүүхэд хөхүүлэх, биеийн хүчний хүнд хөдөлмөрийн үед бие махбодод төмрийн хэрэгцээ нэмэгдэнэ. Уураг багатай хоол хүнс болон өөх тостой хоол хүнс хэрэглэх үед төмрийн шимэгдэлт удааширдаг [24].

Төмрийн цусанд дахь агууламж нь өглөөнөөс оройдоо буурдаг байна. Төмрийн солилцооны алдагдал нь бие махбодод төмөр дутлын цус багадалт үүсгэнэ. Төмрийн дутал үүсэх шалтгаан олон янз байдаг. Төмөр дутлыг туйлын ба харьцангуй гэж хоёр хуваана. Туйлын дутал нь төмөр шингэх, шимэгдэх явц саатах, төмөр багатай хоол хүнс хэрэглэх, архаг цус алдалт зэрэг тохиолдолд үүснэ. Энэ нь төмрийн нөөц үнэхээр багассаныг гэрчлэх цусны ийлдэсний төмөр, гемоглобины багасалт, эритроцитын эритропорфирины хэмжээ ихсэх байдлаар илэрнэ [27].

Төмөр нь голдуу гэдэсний энтероцит эсвэл ретикулоэндотелийн макрофагуудаас ялгардаг төмрийг агуулдаг тээвэрлэгч трансферринээр дамжин эдэд дамждаг. Төмөр дутагдлыг илэрхийлэх гол үзүүлэлт хоол тэжээлийн дутагдал гэж хэлж болно. 1982 онд Манилад болсон хоол тэжээлийн семинард төмрийн тэжээл дутлын талаар дорвитой хөндөгдсөн байдаг. Төмөр нь бие махбодийн бодисын солилцоонд олон чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний биед насанд хүрсэн эмэгтэйчүүдэд 2.5 гр, насанд хүрсэн эрэгтэйчүүдэд 4 гр байдаг байна. Хүний бие дэх зарим эрдэс бодисууд хүйсээс хамаарсан ялгаа байдаг. Харин наснаас хамаарсан ялгаа сул байдаг нь олон тооны судалгаанаас харагддаг [24].

4.2.3 Зэс (Cu) нь бие организмын бодисын солилцоонд чухал ач холбогдолтой элемент юм. Тэрээр цусны цагаан эс үүсэх, эдээс төмөр чөлөөлөх, араг яс болон төв мэдрэлийн тогтолцоо, холбогч эд хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэнэ. Зэс нь гол төлөв уурагтай холбогдож мэдрэлийн тогтолцоо, холбогч эд хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэнэ. Зэс нь гол төлөв уурагтай холбогдож оршино. Тухайлбал, эритроцит дахь гемокупрен, цусны плазм дахь церулоплазмин гэх мэт. Зэс нь эдгээр уургийн

бүтцийн салшгүй хэсэг юм. Мөн металлотioneин нь зэсийг хуримтлуулах үүрэгтэй чухал уураг юм. Түүнээс гадна зэс агуулсан хэд хэдэн ферментийг ялган авчээ [28]. Жишээ нь: цитохромоксидаза, аскорбины хүчлийн оксидаза, уриказа гэх мэт.

Зэс нь хүнсний бүтээгдэхүүнд маш өргөн тархсан тул хөхүүл эмэгтэйчүүдээс бусад бүх насны хүн амд зэс дутагдах нь бараг байдаггүй. Харин зөвхөн сүүгээр хооллох, өөрөөр хэлбэл, хөхүүл хүнд зэсийн дутагдал тохиолдох боломжтой. Хүний бие организмд зэс илүүдвэл судасны гэмтэл тархаж салст бүрхэвч цочрох, элэг болон бөөр гэмтэх, төв мэдрэлийн тогтолцоо цочрох зэрэг эмгэгүүд илэрнэ. Уг элементийн хоногийн хэрэглээ нь ойролцоогоор 2 мг байна.

Зэс нь супероксиддисмутаза, цитохромоксидаза зэрэг олон ферментийн найрлаганд оролцож эд эсийн амьсгал, цус төлжилт, эластен, коллаген, фосфолипидийн нийлэгжил, төмрийн солилцоонд идэвхитэй оролцоно. Сүүлийн жилүүдэд хийсэн судалгаанаас харахад зэс агуулдаг, зэсээс хамааралтай ферментүүд нь төмрийн солилцоонд оролцдог болохыг баталсан байна.

Зэсийн өндөр агууламж нь элэг, бөөрийг гэмтээж, үхэлд ч хүргэж болзошгүй. Вилсоны өвчний үед зэсийн архаг хордлогын шинж илэрдэг. Элэгний хатуурал, тархины гэмтэл, бөөрний эмгэг, бөөрний өвчний улмаас зэсийн хэмжээ өөрчлөгддөг. Өвчний нөлөөллөөс шалтгаалан шинж тэмдгүүд ялгаатай байдаг байна [25].

Зэс нь хүйсийн хувьд ялгаатай ба насны хувьд статистикийн ач холбогдлын хувьд сул хамааралтай байсан. Эрүүл 240 эрэгтэй, 217 эмэгтэйн бүхэл цус болон ийлдсэн дэх зэсийн агууламжийг атом шингээлтийн спектрофотометрээр тодорхойлоход. Бүхэл цусан зэсийн дундаж агууламж эрэгтэйчүүдийнх 104.8 ± 20.5 микрограмм/100 мл, эмэгтэйчүүдийнх 117.1 ± 20.1 микрограмм/100 мл байсан. Сийвэнд дэх зэсийн дундаж агууламж эрэгтэйчүүдэд 102.3 ± 21.7 микрограмм/100 мл, эмэгтэйчүүдэд 123.9 ± 30.4 микрограмм/100 мл байсан. Бүхэл цусан дахь зэсийн агууламж эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна ($p \leq 0.001$). Насны хувьд бүхэл цусан дахь зэсийн агууламж нь эмэгтэйчүүдэд ($p \leq 0.05$) статистикийн ач холбогдол бага, сөрөг хамаарал ажиглагдсан [28].

4.2.4 Цайр (Zn) нь насанд хүрсэн хүний биед 2.3 гр цайр агуулагддаг ба энэ нь эсэд энергийн солилцоог зохицуулдаг 40 гаруй ферментийн найрлагад оролцдог. Цайрын хэрэглээ сайн байх нь ялангуяа хүүхдэд ач холбогдолтой. Учир нь цайр дутагдсанаар хүүхдийн өсөлт удаашрах, халдварт өртөмтгий болох, суулгалт болон амьсгалын замын өвчний эрсдэл нэмэгддэг. Цайрын хүлцэх хамгийн дээд хэмжээ нь насанд хүрсэн хүмүүст 40 мг байдаг.

Цайрын дутал нь хоол хүнсний хэрэглээ хангалтгүй байснаас үүсдэг. Мөн түүнчлэн хавдар, элэгний өвчин, чихрийн шижин зэрэг өвчнүүдийн үед цайрын дутал тохиолддог. Хоолны дуршил буурах, оюуны чадвар буурах, өсөлт удаашрах, цус багадах, шархны эдгэрэлт удаашрах, арьс батгаших болон үрэвсэх, биеэс таагүй үнэр үнэртэх, суулгалт удаан үргэлжлэх, үс унах зэрэг шинж тэмдэг илрэхээс гадна жирэмсэн эхчүүдэд төрөлт хүндрэх болон удаашрах эрсдэл үүсдэг.

Цайр эрүүл мэндийн ач холбогдол ихтэй ч илүүдэл хэрэглээ нь аюултай юм. Цайрын илүүдлийн шинж тэмдэгт: Огиудас хүрэх, бөөлжих, ходоод өвдөх, гүйлгэх

шинж тэмдэг илэрнэ. Судалгаагаар цайрын илүүдэл нь бөөрний чулуу үүсэхэд нөлөөлж байгааг тогтоосон байна.

Олон тооны өвчин эмгэгүүдийн үед цайрын агууламж өөрчлөгддөг ба хамгийн түгээмэл нь *acrodermatitis enteropathica* (АЕ) нь цайрын солилцооны эмгэг юм. Эдгээр хэлбэрүүд нь гэдэснээс цайрыг шингээх боломжгүй болох. Цайр дутагдах үед арьс ба амны эргэн тойронд арьсны үрэвсэл үүсгэдэг. Мөн хавсарсан байдлаар суулгах, хумсны хэвийн биш ургалт (дистрофи). Сэтгэл хөдлөлийн эмзэг байдал бас тохиолддог. SLC39A4 генийн мутациас үүдэлтэй бөгөөд автосомын рецессив хэлбэрээр өвлөгддөг [24].

Цайр нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд цайрын агууламж нь статистик ач холбогдол бүхий ялгаа байхгүй. Жишээ нь: 239 эрүүл эрэгтэй болон 217 эрүүл эмэгтэйн цусанд цайрын агууламжийг атом шингээлтийн спектрометрээр тодорхойлоход. Эрэгтэй хүний цусан дахь цайрын дундаж агууламж 607.0 ± 105.3 микрограмм/100мл, эмэгтэйчүүдэд 585.2 ± 122.9 микрограмм/100мл байна [101]. Цайрын дундаж агууламж 116.6 ± 55.2 мкг/100 мл, 105.2 ± 66.9 мкг/100 мл эрэгтэй, эмэгтэй тус тус байв. Цус багадалттай, цусан дахь концентраци эмэгтэйчүүдээс ялимгүй ессен боловч статистик ач холбогдол багатай байна. Эрэгтэй, эмэгтэй хүний цусан дахь цайр, цусны ийлдсэн дэх цайр нь эерэг хамааралтай байв. Бүхэл цусний хувьд статистик ач холбогдолтой юм. Эмэгтэйчүүдэд цусан дахь цайрын түвшин статистикийн ач холбогдолгүй ч насны хувьд эерэг хамааралтай байгааг харуулсан бөгөөд ийлдсэнд энэ хамаарал сөрөг, статистик ач холбогдолтой байсан. [29].

Плазмд цайр нь хоол тэжээлийн бус хүчин зүйл нөлөөлж болзошгүй. Халдвар, үрэвсэл, цочмог стресс (түлэгдэл, миокардийн шигдээс, мэс засал) нь сийвэн дэх цайрын агууламжийг багасгадаг. Жирэмсэн үед сийвэн дэх цайр бас буурдаг. Цайрыг тодорхойлохдоо дөлөн атом шингээлтийн спектрометрийн аргаар гүйцэтгэдэг. Хүний эрүүл мэндэд зэсийн хэрэгцээ нь төмрийн солилцоо, антиоксидант хамгаалалт, нейропептидийн нийлэгжил, дархлааны функц зэрэг олон тооны биологийн процесст оролцдогдоос үүдэлтэй юм.

Хоол тэжээлийн зэсийн дутагдлын өргөн цар хүрээтэй эмнэлзүйн шинж чанарууд нь янз бүрийн купроэнзимүүдийн үйл ажиллагааны цочроос үүдэлтэй байдаг. Дутлын шинж тэмдгүүдийн олон янз байдал нь хэдийгээр хүнд хэлбэрийн дутагдал оношлоход харьцангуй хялбар байдаг боловч ахиу дутагдлыг тодорхойлох нь зарим талаар асуудалтай байдаг гэсэн үг юм. Хоолны зэсийн дутагдал нь амьдралын туршид сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Зүрх судасны тогтолцооны хөгжил, ясны гажиг, нярай болон түүнээс дээш насны мэдрэлийн болон иммунологийн хэвийн бус өөрчлөлтийг үүсгэдэг. Насанд хүрэгчдийн зэсийн удаан хугацааны дутагдал нь хожуу насандаа ясны сийрэгжилт үүсэх эрсдлийг нэмэгдүүлдэг, холестерин солилцооны сөрөг өөрчлөлтүүдтэй холбоотой байдаг [30].

4.3 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисууд

Уураг амьдралын үндэсийг тэтгэгч бөгөөд хүний биеийн хуурай жингийн 50%-ийг уургийн молекул эзлэх бөгөөд хүний биед 5 сая орчим төрлийн уураг

агуулагддаг. Амьд биеийн өсөлт, төлжилт, хөгжлийн явцыг зохицуулж, удам зүйн, дасан зохицлын, дархлал хамгаалалтын мэдээлэл, тохируулга хариу үйлдлийг уургийн молекулууд гүйцэтгэдэг учир биед явагдах бодисын солилцоонд голлох үүргийг уургийн солилцоо бүрдүүлдэг. Уургууд нь эрүүл физиологийн хэвийн үйл ажиллагааг зохицуулан тэнцвэржүүлж байдаг бөгөөд өвөрмөгц уураг бүрийн биед гүйцэтгэх үүрэгтэй нь холбоотойгоор янз бүрийн эмгэгүүдийн үед тэдгээрийн хэмжээ хэлбэлзэж, эмгэг хэлбэрт шилжих зэргээр өөрчлөгддөг. Энэ зүй тогтлоос улбаалан клиник оношлогооны практикт, өвөрмөгц уургийн хэмжээ түүний өөрчлөлтүүдийг тогтоох судалгааны ажлууд хийгдэж байна [31, 32].

Хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд биомаркер болгон ашигладаг уургийн үзүүлэлтүүдэд нийт уураг, альбумин, преальбумин, трансферрин, ретинол холбогч уураг (РХУ)-ууд ордог. Эдгээр уургууд нь хагас задралын хугацаатай, тус бүрдээ давуу болон сул талуудтай байдаг тул эдгээр шинж чанаруудыг нь тодорхойлж, өвчтөн бүрийн хоол тэжээлийн байдал эсвэл хоол тэжээлийн дэмжлэгийн зохистой байдлыг үнэлэхэд ашигладаг байна (Хүснэгт 1).

Уураг	Хагас задрал	Давуу тал	Сул талууд	Лавлах хэмжээ	Дундаж
Альбумин	20 хоног	- Хэмжилт хийхэд хялбар бөгөөд хямд - Хялбар нөхөгдөнө	- Хагас задралын хугацаа (20 хоног) - Шингэн алдалт /хэт шингэн алдалтанд нөлөөлдөг - Ихэвчлэн эмчилгээний нэг хэсэг болдог - Элэг, бөөрний өвчлөлд хүргэдэг	3.6~5.5 г/дл	3.0 г/дл
Трансферрин	8 хоног	- Хагас задралын хугацаатай - Хүнд хоол тэжээлийн дутагдлын үед түвшин буурдаг	- Төмрийн дутагдалд нөлөөлдөг - Гормон ба антибиотикт мэдрэмтгий - Элэгний өвчтэй хүмүүст эрс буурдаг - Халдвар, үрэвсэлд нөлөөлдөг	200~400 мг/дл	150 мг/дл
Ретинол холбогч уураг	12 цаг	- Хэт богино задралын хугацаатай - Преальбуминтай сайн зэрэгцэж байна - Хоол тэжээлийн байдалд маш сайн мэдрэмтгий	- Бөөрний өвчинд маш их өртсөн - Элэгний хатуурал /А аминдэмийн дутагдал/ - Халдвар /үрэвсэлд нөлөөлдөг	3.0~6.0 мг/дл	1.6 мг/дл
Пре-альбумин	2 хоног	- Хагас задралын хугацаатай - Хоол тэжээлийн байдалд маш сайн мэдрэмтгий - Триптофан өндөр - Эрсдлийн ангилал	- Элэгний өвчлөлийн шатанд буурсан - Халдвар, үрэвсэлд нөлөөлдөг	17~34 мг/дл	11 мг/дл

Эрүүл биеийн үндсэн үзүүлэлтүүдийн лавлах хэмжээ тогтоох ажил нь өнөөгийн нөхцөлд, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн лавлах хэмжээний

стандарт удирдамж дээр тулгуурлан хийгддэг. Монгол хүний ийлдсийн уургийн солилцооны үзүүлэлтүүдийг судлан тогтоосон эрдэмтдийн судалгааны ажлаас харахад (С.Ямаахай болон бусад) ийлдсийн нийт уураг, альбумин болон өвөрмөгц уургийн дундаж үзүүлэлт болон лавлах хэмжээ нь харилцан адилгүй зөрүүтэй тогтоогдсон байна [31]. Нөгөө талаас орчин үеийн технологийн дэвшилтэй уялдуулан шинжилгээний үзүүлэлтүүдийн хэмжээг шинэчлэн тогтоох шаардлага урган гарч ирж байна. Иймээс бид насанд хүрсэн Монгол хүний ийлдсийн уургийн солилцоонд голлон оролцдог нийт уураг, альбумин, пре-альбумин, РХУ, трансферрин уургуудын дундаж болон лавлах хэмжээг шинэчлэн тогтоож, хувь хүний хоол тэжээлийн байдалд уургийн талаас бүрэн гүйцэд үнэлгээ өгөх боломжтой.

4.3.1 Нийт уураг нь хүний бие махбодид шаардагдах энерги болон амины хүчлийн эх үүсвэр юм. Мөн нийт уураг нь цусны рН-н түвшинг барих, дархлалын тогтолцоог идэвхитэй байлгах, биеийн шингэний тэнцвэрт байдлыг зохицуулах, организмын эд эсийг тогтмол тэжээлийн бодисоор хангаж, тэжээх, бодисын солилцооны эцсийн бүтээгдэхүүнийг зайлуулах, зөөвөрлөх, бодисын солилцооны процессыг зохицуулах, хянах (гормон), каталитик (фермент) үүргийг тус тус гүйцэтгэдэг [33].

Нийт уураг нь илчлэг ихтэй хүнсний хэрэглээг багасгаснаас үүдэлтэй хоол тэжээлийн дутагдалд ордог. Нийт уургийг хувь хүний ерөнхий эрүүл мэндийн байдлыг хянах зорилгоор тодорхойлдог ба нийт уургийн түвшин нь эмнэлзүйн лабораторийн шинжилгээний тайлбар, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээний чухал үзүүлэлт болдог. Нийт уургийн хэмжээг ийлдсэнд хэмжиж [33], хоол тэжээл, элэг, бөөр гэх мэт томоохон эрхтэнүүдийн ерөнхий эрүүл мэндийн байдлын эмгэгийг үнэлдэг. Уургийн биед гүйцэтгэх үүрэгтэй уялдан, эмгэг өвчнүүдийн үед ийлдсэнд байх хэмжээ өөрчлөгддөг учраас нийт уураг нь оношлогооны ихээхэн ач холбогдолтой юм.

Нийт уургийн хэмжээ ихсэх, багасах нь янз бүрийн эмгэг хам шинжийн үед, өвчний шалтгаан, эмгэгийн зүй тогтлыг илэрхийлдэг. Уургийн нийлэгжилт багасах нь шингэний тэнцвэр алдагдах, тэжээлийн дутагдалд орох, уургийн задрал ихсэх зэрэг уургийн хэвийн хэмжээ алдагдах нь олон эмгэг өвчний үед оношийн гол үзүүлэлт болдог. Уураг багасах тохиолдолд нефрозын хам шинж, шингэц алдагдах хам шинж, арьсны өвчин, цус алдах, давс усны шимэгдэлт саатах (бөөрний архаг үрэвсэл), гаммаглобулин багасах, хоолны дэглэм алдагдах, өлсгөлөн үед тус тус ажиглагддаг [17,18]. Түүнчлэн зүрхний декомпенсац, нефрит зэрэг хаван үүсч, шээсээр уураг ихээр ялгардаг өвчнүүдийн үед, хатингар, ужиг үрэвсэлт өвчнүүдийн үед уургийн нийлэгжилт багасч хипопротеинемид болдог.

Бөөрний, гэдэсний гэх мэт архаг үрэвсэлт өвчнүүдийн үед хялгасан судасны ханаар уураг нэвчих үйл ажиллагаа ихсэн, нийт уураг багасдаг. Энэхүү эмгэгүүд нь элэгний нийт уургийн өсөлтийг өдөөж эсвэл саатуулдаг бол элэгний үйл ажиллагааны алдагдалтай холбоотой нөхцөлд нийт уургийн хэмжээ ихэвчлэн буурдаг. Нийт уургийн хэмжээ нь мөн бөөрний үйл ажиллагааны тест болгон ашигладаг. Гломерулонефрит зэрэг эмгэгүүд нь гломерулийг гэмтээсний үр дүнд нийт уургийн түвшин буурсантай холбоотойгоор шээсээр уураг ялгарахад хүргэдэг.

Шээсэн дэх уургийн алдагдал нь цусан дахь уургийн хэмжээ буурахад хүргэдэг. Нийт уургийн өндөр түвшинтэй холбоотой бөөрний эмгэгийн жишээ бол бөөрний үрэвсэл юм [31].

Ийлдсийн уургуудийн үзүүлэлтүүдийн дундаж хэмжээ тогтоосон олон улсын хэвлэлийн тоймтой танилцахад ийлдсийн уургийн солилцоо, уургийн бүлгүүд, ялангуяа трансферрин, ретинол холбогч уургуудын лавлах хэмжээ тогтоосон судалгааны ажлуудын үр дүнгүүд маш бага хэмжээний зөрүүтэй байгаа нь дундаж хэмжээг тогтоох нэгдсэн арга зүйтэй болсонтой холбоотой.

Насанд хүрсэн эрүүл хүний ийлдсийн нийт уургийн лавлах хэмжээ В.К.Кухта ба бусад 1986, В.В. Меньшинков 1987, Капитанеко 1988, нарын судалгаагаар 65-85 г/л байсан. Мөн АНУ болон Англи зэрэг орны судлаачид Robert. E (1985), Peter J.J (1987), Kaplan O. (1985), Henry J (1982) нар эрүүл хүний ийлдсийн нийт уураг 62-82 г/л гэж тогтоосон байна.

Сүүлийн үеийн судалгаануудаас харахад Намибиа улсын Josephine. N (2019) нарын хамтарсан судалгааны дүнгээс харахад нийт уургийн лавлах хэмжээ 51-91 г/л байв. Лавлах хэмжээг хүйсийн хувьд авч үзэхэд эмэгтэй, эрэгтэй хүний лавлах хэмжээ 51-91 г/л ба 51-92 г/л байгаа нь хүйсийн дундаж утгуудын хоорондох клиник ач холбогдол бүхий ялгаагүй байсан байна [59].

Камерун улсад хийсэн судалгааны дүнгээс нийт уургийн лавлах хэмжээ нь 45-107 г/л байсан [60]. АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (ӨХСТ)-өөс зөвлөсөн нийт уургийн лавлах хэмжээ 60-80 г/л байна. Энэхүү судалгаануудын лавлах хэмжээ өөр өөр байгаа нь судалгааны статистик арга, хамрах хүрээ, түүврийн хэмжээ ба насны бүлэг зөрүүтэй байгаа нь лавлах хэмжээний түвшинд нөлөөлөх хүчин зүйл болсон гэж үзэж байна [61, 62].

Пакистан улсад хийсэн Ибрахим нарын судалгааны дүнгээс харахад [63], нийт уургийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 64-80 г/л, эмэгтэйчүүдэд 65-78 г/л байв [64]. Судалгааг параметрийн бус аргаар тодорхойлсон ба эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байсан.

Монгол хүний цусны ийлдсийн уургуудын дундаж болон лавлах хэмжээг тогтоосон судалгааны ажил цөөн байна. Анх 1963 онд С.Ямаахай, Д.Бүрэнжаргал нарын цусны ийлдсийн нийт уургийн бүлгүүдийг тогтоосон байна. Улаанбаатар хотод амьдардаг 158 хүний ийлдэст рефрактометрийн аргаар судлан, нийт уургийн дундаж хэмжээ 7.1% бөгөөд хэлбэлзэл нь 6.28-8.4% байна. Уургийн бүлгүүдийг цаасан электрофоторезлон альбумин 53.1% байна гэж тогтоожээ. Судлаачид Монгол хүний ийлдсийн нийт уургийн дундаж хэмжээ олон улсын жишигтэй ойролцоо харин альбумины хэмжээ 2.5-10.4 хувиар их байна гэж дүгнэлт хийсэн байна. 1971 онд Г.Данзан “Улаанбаатар хотын нялх бага насны хүүхдийн ус эрдэсийн ба уургийн солилцооны норм” нэг сэдэвт ажлын хүрээнд 3 хүртэл насны хүүхдийн уургийн дундаж хэмжээг тогтоосон байна.

1984 онд Г.Батмөнх нар Монгол орны байгаль цаг уурын адилгүй бүс нутгуудад оршин суугч үндсэн хүн амын ийлдсийн нийт уургийн дундаж хэмжээ тогтоох иж бүрэн судалгааны ажил хийсэн байна. Судалгааны дүнгээс харахад эрүүл монгол хүний ийлдсийн нийт уураг $8.55 \pm 0.67\%$ буюу нийтээр баримталдаг нормын дээд хязгаар орчмын хэлбэлзэлд багтаж байна гэж дүгнэжээ.

Мөн 1984-1985 оны хооронд АУДэС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бүлэг дэд профессор Ц.Намсрайн удирдлагаар нийт уураг ба уургийн бүлгүүдийн хэмжээ тогтоох судалгааны ажил хийсэн байна. Улаанбаатар хотод оршин суугч 50 донорын (20-34настай) ийлдэст нийт уургийг Биуретийн аргаар бусад уургуудыг агарын гель дээр электрофорезийн аргаар тогтоосон байна. Эдгээр судлаачдын тогтоосноор эрүүл Монгол хүний цусны ийлдсийн нийт уургийн хэмжээ $8.2 \pm 0.28\%$, альбумин $5.36 \pm 0.72\%$ байсан байна.

1994 онд В.Хадхүүгийн “Монгол хүний ийлдсийн зарим уургуудын лавлах хэмжээ” нэг сэдэвт судалгааны ажилд насанд хүрсэн Монгол хүний ийлдсийн нийт уургийн лавлах хэмжээ 76.09 ± 11.0 г/л, преальбумин уургийн лавлах хэмжээ 0.18 ± 0.06 г/л, альбумин уургийн лавлах хэмжээ 42.93 ± 9.61 г/л буюу нийт уургийн лавлах хэмжээ нь гадны судлаачдын тогтоосон хэмжээнээс харьцангуй өндөр байсан бол преальбумин уургийн хувьд гадаадын судлаачдын тогтоосон хэмжээнээс харьцангуй бага байгаа боловч хэлбэлзлийн хязгаарт багтаж байгааг тогтоосон байна [31].

4.3.2 Альбумин нь эрүүл хүний ийлдсийн нийт уургийн 50 хувийг альбумин эзэлдэг. Хоногт 12 гр альбумин элгэнд нийлэгждэг нь бие дэхь бүх уургийн 10 хувийг эзэлдэг. Альбумин сайтар судлагдсан уураг юм. Цэврээр ялган авахад хялбар, сайн уусдаг, уураг задлагч бодисын үйлчилгээнд тэсвэртэй, шингэн хуурай аль ч хэлбэрээр чанараа алдахгүй удаан хадгалагддаг. Альбумин нь 14-20 хоног хагас задралын хугацаатай, элгэнд нийлэгждэг уураг юм. Энэ нь янз бүрийн эрдэсүүд, даавар, өөх тосны хүчлүүдийн хувьд тээвэрлэгчийн үүрэг гүйцэтгэдэг ба хялгасан судасны осмос даралтыг тэнцвэржүүлдэг [37]. Цусан дахь альбумины хэмжээ хурдан буурах нь хоол тэжээлийн үнэлгээний биомаркер болгон авч үздэг. Хэрэв бие нь удаан хугацааны туршид амины хүчлийн хангалттай нөөцгүй бол альбумины синтезийг хадгалах боломжгүй болно [38]. Гэсэн хэдий ч альбумин нь үрэвсэл ялангуяа элэгний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Жишээлбэл, элэгний гэмтэл, мэс заслын дараах байдал, хорт хавдар зэрэгт альбумины хэмжээ буурч байгааг харж болно. Альбумины түвшинг хэмжих нь хоол тэжээлийн байдлыг оношлох, ялангуяа зүрх шилжүүлэн суулгах өвчтөнүүдэд, мэс засал хийлгэж буй өвчтөнд мэс заслын дараах хүндрэлийг бууруулахын тулд ашиглаж байна [39, 40]. Үүнээс гадна ийлдэс дэх альбумины түвшин нь сууж, зогсох, дунд зэрэг дасгал хийх зэрэгт буурч гардаг. Энэ нь биеийн байрлал өөрчлөгдсөнтэй холбоотой гидростатик ба осмос даралтын өөрчлөлтүүдтэй холбоотой юм [38, 40, 49].

Ахмад настнуудын бүх шалтгаант нас баралт нь альбумины хэмжээтэй тодорхой хамааралтай байдаг. Түнхний хугаралтай өвчтөнүүдэд альбумины хэмжээ нь 35 г/л-ээс доош байвал мэс заслын дараах хүндрэлүүд болон нас баралтыг өндөр түвшинд хүргэдэг. Бусад судалгаануудаас харахад уургийн хэмжээ нь мэс заслын үр дүнг урьдчилан таамаглахад тохиромжтой болохыг тогтоосон байна. Хоол тэжээлийн байдлыг үнэлэх бусад хүчин зүйлүүдтэй харьцуулахад альбумин нь чухал үзүүлэлт гэдэг нь сүүлийн үед хийсэн судалгаануудаар батлагдаж байна [41].

Испаний эрдэмтдийн нийт 306 өвчтөнд хийсэн судалгаанаас харахад жингийн алдагдлыг оношлох биомаркер болох альбумины (өмнөх 6 сарын хугацаанд 5 кг-аас

дээш жин хасагдсан бол) хэмжээ буурсан өвчтөнүүдийн гуравны нэгд нь хорт хавдар оношлогдсон байна. Олон хувьсагчийн шинжилгээгээр неоплазмын хамгийн хүчтэй таамаглалыг >80 нас, лейкоцитын тоо >12,000/мм³, альбумин <3.5 г/дл [42] байгааг тогтоожээ. Н.Келлер нарын судлаачид альбумин хемотаксисын үүргийг судлаж, үрэвслийн голомт руу нейтрофилийн байрлалыг чиглэн идэвхитэй үйлчилдэгийг тогтоосон байна.

Альбумины лавлах хэмжээ насанд хүрсэн хүмүүсийн хувьд 35-55 г/л байгааг судлаачид тогтоосон байна. Цюрихийн их сургуулийн Spichigen өөрийн судалгааны дүнд альбумин лавлах хэмжээ 35-50 г/л гэж, C.W.Denko.P, Gabriel нарын судлагаагаар 21-44 насны эрэгтэйчүүдэд 33.3-61.2 г/л, 45-54 насны эрэгтэйчүүдэд 29.1-61.2 г/л, 55-93 насны эрэгтэйчүүдэд 31.6-54.6 г/л байхад 20-40 насны эмэгтэйчүүдэд 27.8-56.5 г/л, 45-54 насны эмэгтэйчүүдэд 24.6-54.4 г/л, 55-81 насны эмэгтэйчүүдэд 32.0-52.8 г/л мөн 0-5 насны хүүхдүүдэд 38-55 г/л байгаа нь насны хувьд нэлээд ялгаатай байгааг тогтоосон байна [66].

4.3.3 Преальбумин уургийг анх 1960 онд нээсэн 5000-60000 молекул жинтэй, ийлдсэнд бага хэмжээтэй агуулагддаг уураг юм. Преальбумины молекулд триптофан, тирозин зэрэг амины хүчлүүд ихээр агуулагддаг, тус бүр 127 амины хүчлийн үлдэгдлээс бүрдэх 16000 молекул жинтэй полипептидын дөрвөн гинж болдог. Альбумин, преальбумин нь элгэнд нийлэгждэг ч хоорондоо хэд хэдэн ялгаатай уургууд юм. Преальбумины хагас задралын хугацаа 2-3 хоног байдаг нь альбуминаас харьцангуй богино хугацаанд задардаг нэгдэл юм. Эдгээр уургуудын аль аль нь онолын хувьд өвчтөний хоол тэжээлийн байдлын цочмог өөрчлөлтүүдийг үнэлэх илүү найдвартай үзүүлэлт болгож хэрэглэдэг. Преальбумин нь ретинол холбогч уураг (РХУ)-тай нэгдэж, А аминдэм РХУ-ийн комплексийг судаснаас эсийн гадаргуунд хүргэх, улмаар эсийн мембран дээр А аминдэмийг хуралдуулах үүрэгтэй. Преальбумины төрөлхийн дутагдал одоогоор илрээгүй байна. Мөн бөөрний аливаа эмгэгүүд нь ийлдсэн дэх преальбумины түвшинг ихэсгэдэг. Цаашилбал, преальбумины нэг үүрэг нь тироксисны хувьд тээвэрлэлтийн уургийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ бол уургийн дутагдлын нэг үзүүлэлт юм. Өвчтөний байдал сайжрахгүй ч гэсэн преальбумин нь хоол тэжээлийн эмчилгээний үр дүнд нэмэгддэг [43]. Бөөрний үйл ажиллагааны алдагдал, кортикостероид эмчилгээ эсвэл шингэн алдалтын үед пре-албумины түвшинг нэмэгдүүлж болох боловч физиологийн стресс, халдвар, элэгний үйл ажиллагааны алдагдал, хэт их усжилтын үед бууруулж болно [13]. Преальбуминыг хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашигладаг эмч нарт ерөнхий эмчилгээ болон эрчимт эмчилгээний өвчтөнүүдийн хүндрэл, үр дагаврын эрсдэлийг тооцоход чухал ач холбогдолтой байдаг [44]. Эмнэлэгийн эрчимт эмчилгээний тасгийн өвчтөнүүдийн Ц урвалжит уураг /преалбумины харьцаа нэмэгдэх нь нас баралтыг нэмэгдүүлэх [45], мэс заслын өвчтөнүүдэд Ц урвалжит уураг/преалбумины харьцаа бага байгаа нь ходоод гэдэсний эмгэгүүд багасаж байгааг урьдчилан таамаглаж болно [46]. Зүрх судасны эмчилгээ хийлгээгүй өвчтөнд преальбумины хэмжилтийг тогтмол хийх нь үрэвсэл болон хоол тэжээлийн байдлын цаашдын явцыг урьдчилан дүгнэх үзүүлэлт болдог байна [44]. Ходоодны хорт хавдар [47], уушгины хорт хавдар [48], зүрх судасны өвчин [49]-ий эмнэлзүйн

янз бүрийн нөхцөлд өвчний цаашдын явцыг урьдчилан (ихэнхдээ амьд үлдэх) таамаглахад преальбумин чухал үүрэг гүйцэтгэдэг тухай хэд хэдэн нийтлэл гарсан байна.

Ийлдсийн преальбумин эрүүл хүнд 0.1-0.4 г/л хэмжээтэй агуулагдах бөгөөд хэлбэлзэл бага харьцангуй тогтвортой байдаг. Katherine Chen нарын хамтран хийсэн судалгаагаар насанд хүрсэн эрүүл хүний ийлдсийн альбумин 35-52 г/л, преальбумин 0.17-0.42 г/л, трансферрин 2.16-3.99 г/л, РХУ 0.04-0.06 г/л гэж тогтоосон байна [65]. Ritchie нарын (1999 он) судалгаагаар насанд хүрэгчдийн преальбумины түвшин нь хүйс, наснаас хамаарч өөр өөр болохыг тогтоожээ. Судалгаагаар насанд хүрсэн хүмүүсийн преальбумины лавлах хэмжээ нь 0.2-0.4 г/л байна [66].

Германы судлаач Kim Kuling нарын Хюстоны эмнэлэгт явуулсан судалгаагаар эрүүл хүний ийлдсийн преальбумины түвшинг 20-90 насны хооронд тогтооход 49 наснаас эхлэн преальбумины хэмжээ тогтмол буурсаар байдгийг тогтоосон байна [68].

4.3.4 Трансферрин нь хоол боловсруулах явцад үүссэн амины хүчлээс элгэнд нийлэгждэг. Трансферрин нь сийвэнгийн уургуудын нэг бөгөөд хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашигладаг [13]. Трансферрин нь төмөр зөөвөрлөхөд гол үүрэг гүйцэтгэдэг уураг юм. Трансферрины түвшин нэмэгдэхэд (архаг цус багадалт анеми) төмрийн шингээлт нэмэгддэг [36]. Үүний үр дүнд төмрийн хэт ачааллын түвшин буурдаг байна. Энэ нь төмөр ба цайрын тээвэрлэлт юм. Үүнийг бие махбод дахь төмрийн төлөв байдлын маркер болгон ашиглаж болно. Төмрийн дутагдалд сийвэнгийн трансферрин ихэсдэг. Трансферрин нь бодисын солилцооны стресстэй нөхцөлд буурдаг. Шенкин болон бусад судлаачид трансферрины хэмжээ нь зөвхөн уураг уухаас гадна уургийн хэрэглээ нөлөөлдөг гэж бичжээ. Уураг, хоол тэжээл багатай өвчтөнүүдэд сийвэнгийн трансферрин 24 хоногийн дараа буурдаг [50].

Хэвийн болон илүүдэл жинтэй өндөр настай 69 өвчтөнтэй харьцуулсан судалгаагаар өөх тос ба трансферриний түвшин хоорондоо ямар ч хамааралгүй байгаа нь хоол тэжээлийн дутагдлыг үнэлэхэд муу ийлдсийн маркер болж чаджээ. Преальбуминтай нэгэн адил бөөрний дутагдлын үед трансферрины түвшин нэмэгддэг. Жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл буюу эстроген дааврын бэлдмэл нь сийвэнгийн трансферрины түвшинг өөрчилдөг болох нь судалгаагаар батлагдсан байна [51].

4.3.5 Ретинол холбогч уураг (РХУ) нь тэжээлийн байдлыг тодорхойлдог уургийн болон хоол тэжээлийн үнэлгээний индекс гэж үздэг. РХУ нь ихэвчлэн элгэнд нийлэгжиж, бөөрөөр ялгардаг тул ийлдсэн дэх РХУ-гийн хэмжээнд элэг, бөөрний үйл ажиллагаа нөлөөлдөг [52]. Ялангуяа элэгний хатуурлаас болж элэгний үйл ажиллагаа муудахад элэгний доторх РХУ-гийн нийлэгжилт буурч, улмаар ийлдсэн дэх РХУ-ийн түвшин буурдаг [53]. Мөн түүнчлэн, хүнд үрэвсэл, А аминдэм эсвэл цайрын дутагдал, гипертиреозын үед ийлдсэн дэх РХУ-ийн хэмжээ буурдаг [54]. РХУ-ийг бөөрний үйл ажиллагааг үнэлэх маркер болгон ашиглах боломжтойг харуулсан судалгаа байдаг [55].

А аминдэм болон цайр нь РХУ-ийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг ба бичил тэжээлийн бодисын хэвийн бус байдал нь ийлдсэн дэхь РХУ-ийн түвшинд нөлөөлдөг [35]. РХУ нь А аминдэмийг бодвол харьцангуй тогтвортой нэгдэл юм [13]. Мөн бөөрний үйл ажиллагааны доголдол, улмаар бөөрний дутагдал РХУ-гийн түвшинг бууруулдаг байна.

РХУ-ийг ашиглан хоол тэжээлийн байдлыг үнэлэхдээ өвчтөний суурь өвчнийг зөв үнэлэх шаардлагатай. Нэмж дурдахад хагас задралын хугацаа нь маш богино буюу 10-12 цаг бөгөөд, хэмжих арга нь түгээмэл байдаггүй тул эмнэлзүйн хувьд хэрэглэхэд бэрхшээлтэй байдаг. Тиймээс өвчтөний нөхцөл байдлын дагуу зохих дүн шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд олон улсад шинжилгээний аргыг нийтээр ашиглах зайлшгүй шаардлагатай байна. РХУ-ийг Нефелометрийн аргаар иммунохимийн шинжилгээний багаж ашиглан хэмждэг [56].

Ихарагаар ахлуулсан судалгааны багийнхан [57] мэс засал хийлгэхийн өмнө болон мэс засал хийсний дараа уургийн тэжээлийн байдлыг үнэлэхийн тулд альбумин, РХУ-ийг хамт хэрэглэхийг зөвлөсөн байна. Солонгосын Baе et al. нарын судалгаагаар РХУ-ийг ашиглан нойр булчирхай, гэдэс дотрыг тайрах мэс засал хийлгэсэн 36 өвчтөнд мэс заслын дараах хоол тэжээлийн байдал, хоол тэжээлийг хангалттай авч байгаа эсэхийг судлахад РХУ-гийн концентраци нь мэс заслын дараах өдөр мэдэгдэхүйц буурч, дараа нь бага зэрэг нэмэгдсэн байна. Мэс заслын дараах цусны сийвэнгийн концентраци нь хурдацтай, мэдрэмтгий цусны индекс болох нь батлагдсан бөгөөд энэ нь хоол тэжээлийн байдлыг хянахад тустай юм [58].

Burtis CA ба бусад (2012), Ledue TB, Collins MF (2011) нарын судалгаагаар ретинол холбогч уургийн лавлах хэмжээ 0.03-0.06 г/л байна [67].

4.3.6 Ц урвалжит уураг (ЦУУ)-ийн хэмжээ нэмэгдэх нь үрэвслийн үр дүн юм. Энэ нь үрэвсэл, сепсис эсвэл халдварын хариу урвал болгон мянга дахин нэмэгдэх боломжтой. Цочмог үе шатанд стрессийн хариу урвалыг хянахын тулд Ц урвалжит уургийг ашигладаг [39, 40].

4.4 Хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэмүүд

Аминдэмүүд нь хүний эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай шим тэжээл юм. Бие дэхь аминдэмүүд нь ферментийн холбоо ба антиоксидантаар үйл ажиллагаа явуулж, бодисын солилцоо, эрчим хүчний үйлдвэрлэлд идэвхтэй үйлчилдэг. А аминдэм нь эндогенийг нэгтгэдэггүй бөгөөд эрүүл мэндийг сахиж, хор хөнөөлийн үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд байнга гаднаас авч байх ёстой. Лабораторийн шинжилгээ нь хоол тэжээлийн байдлыг үнэлэх, аминдэмийн эмчилгээний бэлдмэлийг хянах зорилгоор хийгддэг [69]. Аминдэмүүд нь биологийн идэвхит бодис бүхий бага молекул органик нэгдлүүд юм. Хүн хангалттай хэмжээний аминдэмийг нийлэгжүүлдэггүй. Аминдэмүүд нь хүний хэвийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй. Аливаа амьд бие махбодийн дотор янз бүрийн хэмжээ, хэлбэртэй агуулагддаг ба эд эрхтэний хэвийн үйл ажиллагааг тэтгэгч биологийн идэвхит бодисыг аминдэм гэнэ. 1880-аад оны үед Оросын эрдэмтэн Н.И.Лунин хүн, амьтны хэрэглэж буй хүнс тэжээлийн дотор уураг, өөх, тос, нүүрс ус, эрдэс зэргээс гадна

өөр чухал бодис байна гэсэн таамаглал дэвшүүлсэн нь аминдэмийг нээх эхлэл болсон гэж үздэг. Аминдэмийн дутагдал хамгийн их илэрдэг хүмүүс бол далайчид байв. Тэд олон сараар тэнгис, далайд аялаж шинэ мах, ногоо зэрэг хүнсний зүйлээр дутагддаг учир чийг баам өвчнөөр нас барах нь элбэг байж. Бас шоронгийн хоригдлуудын дунд ч ийм төрлийн өвчин түгээмэл гарна. Уг өвчнүүд аминдэмийн дутагдлаас үүдэлтэй болохыг эрдэмтэд Лунины таамаглалаас нэлээд хожуу олж тогтоожээ. Ийнхүү өдгөө арваад төрлийн аминдэм эмнэлгийн практикт өргөн хэрэглэгдэж байна. Аминдэм дангаараа бие махбодийн хэрэгцээг хангадаггүй. Харин хүнс тэжээлээр дамжин хүн, амьтны биед орсны дараа бодисын солилцоог хурдасгагч, химийн урвалыг идэвхжүүлэгч ферментүүдийг бий болгох чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, аминдэмгүйгээр амьд организм оршин тогтнож чадахгүй гэж ойлгоход болно [69].

Усанд уусдаг аминдэмүүдийн биологийн үүрэг нь янз бүрийн коэнзимүүдийн үүргийг гүйцэтгэдэг. Тосонд уусдаг аминдэмүүдийн биологийн үүрэг нь нь эсийн мембран болон эсийн бүтцийн функцын хяналтад оролцдогтой холбоотой юм. Биологийн олон янзын хэвийн үйл ажиллагааны үед усанд болон тосонд уусдаг аминдэмүүдийн хэрэгцээ шаардлага нь аминдэм дутагдалтай эрхтэнүүд ба тогтолцооны үйл ажиллагааны задралын эмгэгийг үүсгэдэг байна.

Хувь хүний биологийн дээжин дэх аминдэмүүд, макро микро элементийн шинжилгээний үзүүлэлтүүд нь таны хоол тэжээлийн байдлын талаар нарийвчилсан мэдээлэл өгч, таны бодисын солилцооны амин чухал шим тэжээлийн үзүүлэлтүүд нь ямар түвшинд хаана байгаагаа мэдэж болно. Эдгээр үзүүлэлтүүдийн нэг болох аминдэм нь хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх нэг чухал үзүүлэлт болдог [70].

4.4.1 Пиридоксин (В6 аминдэм) нь бодисын солилцоонд оролцож, амины хүчлийг задлах, диалококсилазацын урвал, сульфидрилын бүлгийн шилжүүлэлт, триптопаны солилцоо, гистидин, метионин болон цистиний исэлдэлт, өөх тосны солилцоо, бие махбодийн ханаагүй тосны хүчлийг идэвхжүүлнэ. В6 аминдэм нь хүний биед онцгой нөлөөлдөггүй ч физиологийн маш олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг ба амины хүчлийн биосинтез болон аминотрансферразагийн коэнзим байдлаар бодисын солилцоонд оролцдог. В6 аминдэм нь декарбоксилаза төрлийн маш олон тооны энзимд коэнзим болдог бөгөөд тархины функц болоод мэдрэл дамжуулагчийн синтезэд маш чухал үүрэгтэй. В6 аминдэмээс болж астма, зарим төрлийн хорт хавдар болон жирэмслэлтийн үеийн диабет үүсдэг. Иймээс В6 аминдэмийн физиологийн үүргийг нарийвчлан судлах шаардлагатай юм.

В6 аминдэм дутагдлын шалтгаан нь хөгшрөлт, архины хэрэглээ болон бусад микро шим тэжээлийн дутагдал нь В6 аминдэм дутагдлын эрсдэлийг нэмэгдүүлдэг [73] байна. Фолийн хүчил, пиридоксин, кобаламин нь нэг нүүрстөрөгчит метил нь бодисын солилцооны гол коэнзимийн үүрэг гүйцэтгэхэд оролцдог ба тэдгээрийн дутагдлаас үүдэн хөхний хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Иран улсын хөхний хавдартай 149 хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх судалгаа хийхэд В6 аминдэмийн лавлах хэмжээ нь 5.47-28.41 мкг/л, дундаж нь 13.74±5.84 мкг/л, В9

аминдэмийн лавлах хэмжээ 2.82-16.98 нг/мл, дундаж нь 9.95 ± 3.89 нг/мл гарсан байна.

Хоол хүнсээр хангалттай хэмжээний аминдэмийн хэрэглээгээ авч чадахгүй байх нь олон өвчлөлийн суурь болдог ба амин дэм (В₆, В₉)-ийн хоол тэжээлийн найрлагад зайлшгүй шаардлагатай юм [74].

4.4.2 Цианокобаламин (В₁₂ аминдэм) нь микроорганизмыг нийлэгжүүлдэг цорын ганц аминдэм юм. Мөн В₁₂ аминдэм нь цусны улаан эсийг үйлдвэрлэх, ДНХ боловсруулахад чухал үүрэгтэй ба бодисын солилцоо, мэдрэлийн системийн үйл ажиллагаа, эрчим хүчний түвшинг дэмждэг [75].

Цус багадалт өвчин нь гадаад ба дотоод шалтгаанаас болж В₁₂ аминдэм организмд дутагддаг. Гадаад шалтгаант хоол тэжээлээр В₁₂ аминдэм хангалтгүй хэмжээтэй орж ирсэн, дотоод шалтгаан нь ходоодонд Кастлын фактор уураг дутагдсан явдал юм. В₁₂ аминдэмийн коэнзим хэлбэрт буюу дезоксиаденозилкобаламинд цианидын бүлэг рибозын хэсийн 5-нүүрстөрөгчийн атомаар кобаламинтай холбогдон 5-дезоксиаденозины үлдэгдлээр халагдсан байдаг. В₁₂ аминдэмийн коэнзимийн үүрэг нь ялангуяа нэг бүлэглэл нэг нүүрстөрөгчийн атомаас зэргэлдээх нэг нүүрстөрөгчийн атом руу зөөгддөг урвалд алкилын бүлэг буюу халагдсан алкилын бүлгийг зөөгчийн үүрэг гүйцэтгэдэг. Авитаминозын үед цус төлжүүлэх, мэдрэлийн, хоол боловсруулах, зүрх судасны системүүд бүгд хямардаг [24].

Судалгаагаар залуучуудад В₁₂ аминдэм дутагдалтай байдаг. Мөн махан хоол иддэггүй хүмүүс, өндөг иддэггүй хүмүүсд энэ аминдэмийн дутагдалд өртөх нь элбэг байдаг. Настай хүмүүсийн 12-15%-д уг аминдэм дутагдалтайг олон улсын судалгаануудын үр дүнгүүдээс харж болно. Ходоодны хүчил дарангуйлагч буюу антацидууд тогтмол хэрэглэдэг хүмүүст В₁₂ аминдэм нь дутагддаг [71, 76].

В₁₂ аминдэмийн дутагдал нь хоол тэжээлийн дутагдлын үед хамгийн түгээмэл тохиолддог. В₁₂ аминдэм нь биеийн генетик код болох ДНХ-ийн үйлдвэрлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг. В₁₂ аминдэм нь зөвхөн мах, тахиа, загас, өндөг, цагаан идээ гэх мэт амьтны гаралтай бүтээгдэхүүнүүдэд агуулагддаг. Тиймээс баялаг хоол хүнс хэрэглэдэггүй хүмүүс В₁₂ аминдэмийн дутагдалтай байдаг. Нэмэгдэл, баяжуулсан хоол хүнс таны В₁₂ аминдэмийн түвшинг сайжруулахад тусалж чадна [77, 78].

Девид Смит нарын судалгаагаар аминдэм В₁₂-ийн дутагдал нь ихэвчлэн танин мэдэхүйтэй холбоотой байдаг. Ахмад настнуудын танин мэдэхүй нь хөгширөлтийн шалтгаанаас гадна В₁₂ аминдэмийн хэмжээнээс хамааралтайг нотолсон байна [79].

Жейкоб Селхуб нарын судалгаагаар цус багадалтыг эмчлэхдээ фолийн хүчлийг их хэмжээгээр хэрэглэх нь В₁₂ аминдэмийн дутагдалд хүргэж сөргөөр нөлөөлдөг бөгөөд энэ нь өндөр настай хүмүүст илүү нөлөөлдөг болохыг нотолсон [80] ба С.Ж.Бейтс нарын судалгаагаар хэвийн амьдралтай болон асрамжийн газрын 65 ба түүнээс дээш насны 313 хүний цусны ийлдэст В₁₂ аминдэмийн агууламжийг тодорхойлоход 20% нь 150 ммоль/л-ээс бага байсан нь нийгмийн байдал, амьдралын түвшин шууд хамааралтай байгааг илрүүлсэн байна [81].

Реган Л. Бейли нар нь фолийн хүчлийн хэрэглээнээс хамаарч В₁₂ аминдэмийн хэмжээг системтэй судлах шаардлага гарснаар судалгаагаа эхлүүлсэн. Америкийн нэгдсэн улсын үндэсний хэмжээнд явуулсан хөндлөн огтлолын судалгаагаар “Эрүүл мэнд, хоол тэжээлийн үндэсний судалгааны 1999-2004 оны өгөгдлөөс 19 ба түүнээс дээш насны 12612 насанд хүрсэн иргэдийг хамруулсан. Оролцогчдын 25% орчим нь В₁₂ аминдэм агуулсан хүнсний нэмэлт тэжээл хэрэглэсэн гэж мэдээлсэн. Шинжилгээг хийн хроматографи, масс спектрометр ашиглан хийж гүйцэтгэсэн. Ойролцоогоор 1% нь В₁₂ аминдэмийн дутагдалтай, 32% нь хэвийн байсан. Залуу эмэгтэйчүүдийн дийлэнх хувьд нь В₁₂ аминдэм багатай үр дүн гарсан [82].

В₁₂ аминдэм дутагдвал толгой эргэх, хумс, арьс өнгө алдах, ой санамж муудах, байнга ядрах, хараанд асуудал үүсэх, булчин сулрах, сэтгэл санаа байнга хувьсах, амтны мэдрэмж буурах, тэнцвэрээ алдах, цус багадалтаас үүдэлтэй амьсгаадалтын шинж тэмдэгүүд илэрч эхэлнэ. В₁₂ аминдэм нь эсэд хүчилтөрөгчийг нэмэгдүүлдэг эритроцитийг бий болгодог. В₁₂ аминдэмийн дутагдлын үед эритроцитуудын түвшингийн эрч буурснаар эдүүдийн хүчилтөрөгчийн хэмжээ багасна. Үүнээс болж зүрх ачаалалтай ажиллаж цусны даралт буурах шинж ажиглагдана. Мөн хичнээн сайн унтаж амарсан ч ядарч эхэлдэг байна [83].

4.4.3 Аскорбины хүчил (С аминдэм) нь 1820 онд Австралийн эмч Крамер буйлнаас цус гарах, арьсны хөхрөлт, экзем маягийн тууралт гардаг, амархан ядардаг, зүрхний үйл ажиллагаа сулардаг зэрэг шинж тэмдэг бүхий нэгэн өвчний тухай бичжээ. Энэ өвчнийг хожим нь чийг баам гэж нэрлэсэн байна. Дундад зууны үед энэ өвчин хамгийн хүнд өвчнүүдийн нэг байсан бөгөөд 19-р зууны сүүлчээр Оросын эмгэг судлаач В.В.Пашутин чийг баам нь ургамлын гаралтай хоол хүнсэнд нэгэн тодорхой хүчин зүйл байхгүйгээс болж байна гэсэн дүгнэлтийг сорилт туршилтын үндсэн дээр хийжээ. 1919 онд Друмонд энэ бодисыг С аминдэм (чийг баам өвчний эсрэг хүчин зүйл) гэж нэрлэжээ. 1918 онд нимбэгний шүүс, байцайнаас талстаар гаргасан, 1927 онд бөөрний дээд булчирхай, улаан перцнээс гарган авсан. Энэ аминдэм бүтцийг Английн Эйлер ба Хирст, немцийн Михель, АНУ-ын химич Каррер нар бараг нэг зэрэг тогтоосон бөгөөд физиологийн үйлчлэлтэй нь холбон аскорбины хүчил гэж нэрлэв. 1932 онд Рейхштейн, үүнээс үл хамааралтайгаар Хирст ба Хеорз нар нийлэгжүүлэн гаргасан.

С аминдэм нь хүний биед шинээр нийлэгжиж бий болдоггүй гаднаас хоол тэжээлээр авах шаардлагатай байдаг. Уураг, нүүрс ус, өөх тосны бодисын солилцооны хэвийн үйл ажиллагааг хангахын тулд исэлдэлтийг бууруулах урвалд оролцдог. Энэ нь усанд уусдаг аминдэм учраас хүний биед С аминдэмийг хадгалахгүй тул та өдөр бүр нэмэлтээр авч байх хэрэгтэй. С аминдэм (аскорбины хүчил) нь хоол хүнсэнд хамгийн их агуулагддаг аминдэмийн нэг бөгөөд хүний биед хоол хүнсээр дамжин орж, бодисын солилцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. С аминдэм нь хүний бие махбодын нүүрс усны солилцоонд исэлдэн ангижруулах үйл ажиллагааг зохицуулснаар цусны бүлэгнэлт, хялгасан судасны нэвчилтийг хэвийн болгох, кортикостероид, коллаген, проколлагены нийлэгжилтэд оролцож биеийн эсэргүүцлийг сайжруулдаг судасны хананы суурийн мембраныг бэхжүүлдэг. Энэ нь бие махбодийн хамгаалалтын шинж чанарыг бэхжүүлж, дархлааны хариу урвалыг

сайжруулж, интерфероны нийлэгжилтэнд оролцдог, склерозын эсрэг үйлчилгээтэй дааврын нийлэгжилтийг бий болгодог. С аминдэмийн дутагдал нь гиповитаминозын үед ноцтой өвчин үүсдэг. Энэ нь дотор эрхтний цус алдалт, буйлны үрэвсэл, үе мөч өвдөх, үс унах, арьс хуурайших, зүрх дэлсэх зэргээр илэрдэг. С аминдэм нь коллаген, L-карнитин болон зарим нейротрансмиттерийн био нийлэгжилтэнд шаардлагатай байдаг; С аминдэм нь уургийн солилцоонд мөн оролцдог [84,85]. Коллаген нь холбогч эдийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд шарх эдгэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. С аминдэм нь физиологийн чухал антиоксидант [86] бөгөөд биеийн доторх бусад антиоксидант, түүний дотор альфа-токоферол (Е аминдэм)-ийг нөхөн сэргээдэг болох нь батлагдсан. С аминдэмийн хэрэглээ хангалтгүй үед ядаргаа, сульдаа, холбогч эдийн сулрал, хялгасан судасны эмзэг байдал зэргээр илэрдэг [87,88].

С аминдэм нь маш энгийн бүтэцтэй молекул юм. Энэ нь нэгэн сахарын хүчлийн лактон бөгөөд дегидроаскорбины хүчил болж хялбар исэлддэг ба аминдэмийн идэвх нь хэвээр үлддэг. Дегидроаскорбины хүчил нь тогтвор муутай нэгдэл учир сул шүлтийн ба саармаг орчинд идэвхигүй дикетогулоны хүчилд хувирдаг. Иймд температурын үйлчилгээгээр исэлдүүлэгчдийн нөлөөгөөр задардаг L-аскорбины хүчил нь аминдэмийн идэвхитэй байхад D-аскорбины хүчил нь идэвхигүй. Биеийн нийт С аминдэмийн хэмжээ 0.3-2 гр орчим байдаг. С аминдэм нь эд эсэд их (миллимолярын концентраци)-ээр агуулагддаг бөгөөд лейкоцит, нүд, бөөрний дээд булчирхай, өнчин тархины булчирхай, тархинд хамгийн их агууламжтай байдаг. С аминдэм нь эсийн гаднах шингэн, тухайлбал сийвэн, цусны улаан эс, шүлсэнд харьцангуй бага (микромольрын концентраци) хэмжээтэй агуулагддаг [87].

С аминдэмийн цочмог дутагдал нь чийг баам өвчнийг үүсгэдэг [49, 89-90]. Өвчний шинж тэмдэг илрэх хугацаа нь С аминдэмийн хэрэглээнээс хамаарч харилцан адилгүй байдаг боловч өдөрт 10 мг-аас бага С аминдэм хэрэглэвэл 1 сарын дотор шинж тэмдэг илэрч болно [89]. Эхний шинж тэмдгүүд нь ядаргаа (карнитины био нийлэгжлийн эмгэгийн үр дагавар байж болзошгүй), бие сулрах зэрэг шинж тэмдгүүд орно [86, 90]. С аминдэмийн дутагдал даамжирснаар коллагены нийлэгжилт муудаж, холбогч эдүүд суларч петехиа, экхимоз, пурпура, үе мөч өвдөх, шархны эдгэрэлт муудах, гиперкератоз, штопорын үс зэрэг өвчин үүсгэдэг [84, 85, 87, 90]. С аминдэмийн бага хэрэглэснээс цус алдалт ихэсч, хоёрдогч төмрийн шингээлт буурснаас болж төмрийн дутагдлын цус багадалт үүсч болно. 18-р зууны төгсгөл хүртэл С аминдэм бага хэрэглэдэг эсвэл огт хэрэглэдэггүй далай тэнгисийн урт аялалд гарч байсан олон далайчид хавчны өвчнөөр өвчилж, нас баржээ. 1700-аад оны дунд үеэр Британийн тэнгисийн цэргийн мэс засалч Сэр Жеймс Линд туршилт явуулж, цитрусын жимс идэх эсвэл цитрусын жимсний жүүс уух нь цэргүүдийг эмчилж болохыг тогтоожээ. Гэхдээ эрдэмтэд 1932 он хүртэл аскорбины хүчил идэвхтэй бүрэлдэхүүн хэсэг байсныг нотолж чадаагүй юм [91].

Тархвар судлалын судалгаанаас харахад жимс, хүнсний ногооны хэрэглээ өндөр байх нь С аминдэмийн агууламжаас шалтгаалан олон төрлийн хорт хавдраар өвчлөх эрсдэл багатай байдаг. С аминдэм нь хорт хавдар үүсгэгч зарим бодис үүсэхийг хязгаарлаж чаддаг, дархлааны хариу урвалыг зохицуулж, антиоксидант

идэвх нь хорт хавдар үүсгэдэг исэлдэлтийн хор хөнөөлийг бууруулдаг. Судалгаагаар хоолны дэглэмийн үед С аминдэмийн хэрэглээ нь уушиг, хөхний, бүдүүн гэдэс, шулуун гэдэс, ходоод, амны хөндий, залгиур, улаан хоолойн хорт хавдар зэрэг өвчнүүдэд урвуу хамаарал байгааг тогтоожээ. С аминдэмийн сийвэн дэх концентраци нь хорт хавдартай хүмүүст эрүүл хүмүүсээс бага байдаг [84-87].

Ходоод гэдэсний хорт хавдараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2008 онд хийсэн С аминдэм болон бусад антиоксидант нэмэлтүүдийг судалж үзэхэд С аминдэм (эсвэл бета-каротин, А аминдэм, Е аминдэм) нь ходоод гэдэсний хорт хавдраас сэргийлдэг гэсэн баттай нотолгоо олдоогүй байна [93, 94]. С аминдэм нь хоруу чанар багатай учраас өндөр хэрэглээнд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэггүй гэж үздэг. Ходоод гэдэсний замд шимэгдээгүй С аминдэмийн нөлөөнөөс болж суулгалт, дотор муухайрах, гэдэс базлах, ходоод гэдэсний бусад эмгэгүүд үүсдэг байна [87, 90].

4.4.4 Фолийн хүчил (В9 аминдэм) нь бүдүүн гэдсэнд ашигтай нянгуудын оролцоотойгоор нийлэгжиж шимэгддэг ба хүний биед олон талын онцгой үйлчилгээ үзүүлдэг. Фолийн хүчил нь эсийн хуваагдлын үед амины хүчлийн бодисын солилцоо болон олон уураг, амины хүчлүүдийн нийлэгжилт, эсийн бүтцийн суурь болох ДНХ-ийн үйл ажиллагаа, нөхөн сэргээлт, үйлдвэрлэлд оролцдог ба төмөр, В₁₂ аминдэмийн хамт цусны төлжилтэд оролцож, эд эсийг нөхөн төлжүүлэх, өсөлтийн процессыг дэмжих үүрэгтэй. Хүн гаднаас буюу хоол хүнсээр дамжуулж фолийн хүчлийг авдаг [94, 95].

Биед байх биологийн идэхитэй фолийн хүчил нь элгэнд дигидрофолийн редуктаза ферментийн тусламжтай тетоагидрафолийн хүчил болон хувирна. Тетоагидрафолийн хүчил үндсэн бодисын солилцооны гол үүрэг нь нэг нүүрстөрөгч агуулсан бүлгийг (жишээ нь: метил, формил бүлэг) зөөвөрлөх юм. Гомоцистейн, метионины нийлэгжил, ДНХ-ийн нийлэгжил, РНХ, ДНХ-ийн модификацийн процесс болон эсийн бодисын солилцооны бусад урвалд чухал нөлөөтэй. Үйлдвэрлэх процесс болон хадгалалтанд харьцангуй тогтвортой байдаг учраас хүнсний нэмэлт болгож ашиглахад хялбар. В₉ амин дэмийн дутагдал нь ургийн хөгжил, үр тогтолт, зүрхний өвчин, хавдар, мэдрэлийн өвчин зэрэгт нөлөөлдөг [96].

Цусны ийлдсийн фолийн хүчлийн агууламж буурснаар цусны ийлдсэн дэх гомоцистейны агууламж ихэсдэг. Мөн цусны улаан эсийн фолийн хүчил буурснаар морфологийн түвшинд ясны чөмөг болон хурдацтай хуваагддаг бусад эдэд мегалобластик өөрчлөлтүүд гарч ирдэг. Эритробласт эс репликаци хийх чадваргүй болсноор эритроцитын хэмжээ буурч, хэвийн бус болж, цус багадалт, цусан дахь хүчилтөрөгч зөөх чадвар буурах, улмаар ядаргаа, цочромтгой байдал, амьсгал давчдах шинж тэмдэг илэрдэг [97].

Фолийн хүчлийг хоол хүнс болон биологийн нэмэлт бүтээгдэхүүнээр гаднаас нэмэлтээр авч хэрэгцээгээ хангадаг учраас хоол тэжээлийн байдлын үнэлгээний судалгаанд фолийн хүчлийг тодорхойлох шаардлагатай байдаг. “Эрүүл мэнд, хоол тэжээлийн үндэсний судалгаа”-гаар АНУ-ын хүмүүсийн дундах ийлдсэн дэх фолийн хүчлийн хэмжээг 6 насны бүлгээр ангилан тодорхойлоход 1-11 болон 60-аас дээш насны хүмүүст 16-17 мкг/л байсан энэ 2 насны завсарт байгаа насны бүлгийн

хүмүүст энэ үзүүлэлтээс бага хэмжээтэй гарсан бол гомоцистейны хэмжээ 20 болон түүнээс дээш насны хүмүүсийн 8 орчим хувь, 60 болон түүнээс дээш насны хүмүүсийн 19 орчим хувь нь 13 мкмоль/л-с их гарсан байна.

Хоол хүнсээр фолийн хүчлийг нэмэлтээр хэрэглэдэг улсын хүмүүсийг, сайн дураар хэрэглэдэг улсын хүмүүстэй харьцуулахад фолийн хүчлийн хэмжээ их байдаг. 4-18 насны хүүхдийг 3 насны бүлгээр ангилж улаан эсийн фолийн хүчлийн хэмжээ болон гомоцистейны хэмжээг тодорхойлоход улаан эсийн фолийн хүчлийн хэмжээ нь нас нэмэгдэх тусам буурч байхад гомоцистейны хэмжээ нэмэгдсэн байсан. Фолийн хүчил нь амьд организмд шаардлагатай бодисын солицооны чухал шим тэжээлийн элементүүдтэй нягт уялдаа холбоотой. Үүнд аминдэм (В₁₂, В₆, В₂)-үүд ордог [97].

Жирэмслэлтэнд хоол тэжээлийн байдал, хоолны дэглэм чухал ба нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд фолийн хүчлийн тохиромжтой хэрэглээ нь ургийн мэдрэлийн хөгжилд сайнаар нөлөөлдөг. Швед улсын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх судалгаагаар фолийн хүчлийг биомаркер болгон тодорхойлоход эритроцитийн фолийн хүчлийн агууламж 317 нмоль/л-ээс бага, ийлдсэн дэх фолийн хүчлийн агууламж нь 6.8 нмоль/л-ээс бага гарсан байна. Мөн нөхөн үржихүйн насны (18-44) эмэгтэйчүүд 45-80 насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад фолийн хүчлийн хэмжээ бага байгаа нь жимс, хүнсний ногооны хэрэглээний ялгаанаас фолийн хүчлийн хэмжээ ийм үр дүн гарсан гэж дүгнэсэн байна [98].

ТАВ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

5.1 Судалгааны хамрах хүрээ, арга зүй

5.1.1 Хамрах хүрээ

Судалгаанд эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт орохоор ирсэн хүмүүсээс урьдчилан боловсруулж батлуулсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан 19-69 насны эрэгтэй 170, эмэгтэй 170 нийт 340 хүнийг сонгон хамруулсан.

Шалгуур үзүүлэлтийг агуулсан асуумжийг хариулахад хялбар “тийм”, “үгүй” гэсэн товч хариулттайгаар боловсруулж (Хавсралт 1), уг асуумжийн үндсэн дээр судалгааны шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлж, судалгааны шалгуур хангасан судлуулагчдыг цааш судалгаанд хамруулсан. Судалгааны шалгуур хангасан хүмүүст судалгааны талаар товч танилцуулга хийж, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн тохиолдолд таниулан зөвшөөрлийн хуудастай танилцуулж, бичгээр зөвшөөрөл (Хавсралт 2) авсан.


5.1.2 Судалгааны ёс зүй

Судалгааны аргачлалыг НЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн 2018 оны 06-р сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2018 оны №76 тогтоолоор олгосон болно. Судалгааны өмнө оролцогч бүртэй урьдчилан ярилцаж судалгааны ач холбогдол, судалгааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч, оролцогч бүрээс таниулсан зөвшөөрлийг авсан.

5.1.3 Лавлах хэмжээ тогтоох арга зүй

Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх биомаркеруудын дундаж хэмжээ болон лавлах хэмжээг тогтоохдоо Эмнэлзүйн лабораторийн стандартын хүрээлэн (ЭЛСХ, CLSI)-гээс боловсруулан баталсан “Эмнэлзүйн лабораторийн лавлах хэмжээ тогтоох” аргачлалыг ашигласан [99]. Лавлах хэмжээг тогтоохдоо дараах схемийн дагуу тодорхойлсон.

Схем 1. Лавлах хэмжээ тогтоох үе шат



5.1.4 Лавлах хувь хүнийг сонгох

Судалгаанд хамрагдах судлуулагчийг сонгохдоо шалгуур үзүүлэлтүүдийг агуулсан асуумж судалгаанд үндэслэсэн. Судалгаанд оролцуулахгүй байх дараах шалгууруудыг баримталсан болно. Үүнд:

- Нас: 19-өөс бага настай эсвэл 69-өөс их настай бол;
- Сүүлд өвдсөн өвчин (хоол боловсруулах замын архаг өвчнүүд, хорт хавдар)
- Зорилтот бодисуудын хэмжээнд нөлөөлөх, эмийн болон биологийн идэвхит бодис, амин дэм, эрдэс бодисууд хэрэглэсэн бол;
- Жирэмсэн бол;
- Архи, согтууруулах ундаа 48 цагийн дотор хэрэглэсэн бол;
- Өдөрт 20 болон 20-оос олон ширхэг тамхи татдаг бол;
- Биеийн жингийн индекс ≤ 18 эсвэл ≥ 30 бол;
- Хооллолтын байдал;
- Ажлын байрны хортой нөхцөл;

5.2 Шинжилгээний сорьц цуглуулах

Судалгааны шалгуур үзүүлэлтийг хангасан судлуулагчийн хураагуур судаснаас ариутгасан нэг удаагийн зүү ашиглаж, ЭДТА-тай болон нэмэлтгүй вакуум хуруу шилэнд ДЭМБ болон ЭЛСХ-ээс баталсан аргын дагуу цус авсан. Авсан цусаа дараах аргын дагуу лабораторийн шинжилгээнд бэлтгэж хадгалсан. Үүнд:

- Нэмэлтгүй вакуум хуруу шилэнд авсан сорьцыг 30-60 минут орчим тасалгааны хэмд байлгаад тагийг авахгүйгээр 1500 эргэлт/мин 15 минут хурилдуулж ийлдсийг ялган авсан. Ийлдсийг 7 ширхэг бичил хуруу шилэнд хуваан хийж сайтар таглан, шинжлэх хүртлээ тогтмол -40°C хэмд хадгалсан. Хэрэв улаан эс задарч гемолиз үүссэн бол ийлдсийг шинжилгээнд ашиглаагүй болно.
- ЭДТА-тай вакуум хуруу шилэнд авсан сорьцыг 10-12 удаа 180 градусын хөдөлгөөнөөр хольсны дараа 2 хуваагаад нэгийг нь -40°C -д хадгалж, үлдсэн сорьцонд гематологийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

5.3 Лабораторийн шинжилгээний аргууд

5.3.1 Цусан дахь гематологийн үзүүлэлтүүд тодорхойлох

5.3.1.1 Цусны эсүүд тодорхойлох: Эс бүрд тохирсон будагч бодисын тусламжтай эсийг будаж харилцан үйлчлэлд оруулсны дараа тухайн эсийн флуоресценци гэрлийн эрчмийн мэдээлэл дээр үндэслэж тодорхойлдог.

Шинжилгээний үйл явц: Судлуулагчийн цусны дээжийг өрөөний температуртай болгосны дараа үйлдвэрлэгчийн оношлуурын зааврын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэнэ. Улаан эсийг гидро-динамик чиглүүлэгчийг ашиглан, цагаан эсийг хагас дамжуулагч лазераар баганан цитометрээр, гемоглобины хэмжээг цианидгүй натрийн лаурил сульфатын аргаар тус тус тодорхойлсон.

5.3.2. Цусан дахь элемент (төмөр, зэс, цайр)-үүд тодорхойлох

5.3.2.1 Цусанд цайр тодорхойлох арга [100-102]: Судалгаанд хамрагдагсдын цусан дахь цайрын агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар

тодорхойлсон. Шинжилгээнд судлуулагчдын судаснаас авсан ийлдсийг ашигласан болно. Энэхүү арга нь цусны ийлдсэнд цайрын агууламжийг хөндий катодын ламп (HCL) ашиглан 213.86 нм долгионы уртад шинжлэнэ. Ийлдсийг магни нитрат агуулсан матриц засах уусмалаар тогтворжуулан тодорхойлох зарчимд үндэслэсэн.

Урвалж:

1. Азотын хүчил (HNO_3), химийн цэвэршилттэй, хүнд металлын агуулга нь <0.1 ppb
2. 1000 мг/л цайрын стандарт уусмал
3. Ионгүйжүүлсэн ус
4. 10 г/л концентрацитай магни нитрат $\text{Mg}(\text{NO}_3)_2$
5. 99.999%-ийн цэвэршилттэй аргон хий
6. Автомат дээж авагчийн 2 мл хэмжээтэй бичил аяга

Урвалж бэлтгэх дараалал

1. Матриц засах уусмал: 10 г/л концентрацитай магнийн нитрат ($\text{Mg}(\text{NO}_3)_2$) стандарт уусмалыг матриц засах уусмал болгож хэрэглэнэ.
2. 30 мг/л цайрын стандарт уусмал бэлтгэх: 1000 мг/л-ийн цайрын стандарт уусмалаас 3 мл-ийг 100 мл-ийн хэмжээст колбонд хийж дээр нь 0.2 мл цэвэршүүлсэн концентрацитай азотын хүчил HNO_3 нэмнэ. Дараа нь ионгүйжүүлсэн нэрсэн усаар хэмжээс хүртэл дүүргэнэ.
3. 0.2%-ийн азотын хүчил (HNO_3)-ийн уусмал бэлтгэх: 500 мл-ийн хэмжээст колбонд 200 мл ионгүйжүүлсэн ус хийж дээр нь концентрацитай азотын хүчлээс 1.5 мл-ийг хийж, хэмжээс хүртэл ионгүйжүүлсэн ус хийнэ.
4. Ажлын уусмал бэлтгэх:

30 мг/л Zn	HNO_3 конц	Хэмжээст колбо	Бэлтгэсэн ажлын уусмалын концентраци
0.167 мл	0.2 мл	50 мл	100 мкг/л
0.330 мл	0.2 мл	50 мл	200 мкг/л
0.500 мл	0.2 мл	50 мл	300 мкг/л
0.667 мл	0.2 мл	50 мл	400мкг/л

Шинжилгээний явц

Атом шингээлтийн спектрометр багажийн программын аргачлалын дагуу тухайн тодорхойлох элементийн долгионы урт, сорьцын хэмжээ, стандарт утга зэрэг аргын өгөгдлүүдийг урьдчилан тохируулна.

Графит зуухны тохируулга

Ажиллах дараалал	Темп. ($^{\circ}\text{C}$)	Налуу (сек)	Барилт (сек)	Хийн урсгал (мл/мин)	Хийн төрөл
Хатаах 1	110	1	25	250	Аргон хий
Хатаах 2	130	15	15	250	
Пиролиз	600	10	20	250	
Атомжуулах	1800	0	5	0	
Цэвэрлэх	2600	1	5	250	

Дээжийг шинжлэх

1. Автомат дээж авагчийн 2 мл-ийн бичил аяганд шингэрүүлсэн ажлын уусмал тус бүрээс 100 мкл-ийг авч +900 мкл матриц засах уусмалаас хийнэ. Энэ нь калибровкийн муруй байгуулах стандарт уусмалууд болно.
2. Дээжийг уншуулахдаа автомат дээж авагчийн 2 мл-ийн өөр бичил аяганд матриц засах уусмалаас 900 мкл + 50 мкл ийлдэс хийж уншуулна.
3. Багажийн мэдрэх хязгаараас их концентрацитай дээж байвал сорьцыг матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлнэ.

Хоосон туршилт

Шинжилгээнд хэрэглэж буй шил сав болон урвалж бодисын цэвэршилтийг хянахын тулд дээжний оронд иогүйжүүлсэн усыг ашиглан дээжийг шинжлэх хэсгийн хоёр дахь аргын дагуу явуулна.

Үр дүнгийн боловсруулалт

Бэлтгэсэн уусмалыг атом шингээлтийн спектрометр багаж дээр хоосон туршилтын хамт уншуулан, тодорхойлох уусмалын хүнд металлын утгаас хоосон туршилтын утгыг хасаж тооцоо хийнэ. Хэрэв дээжийг матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлсэн бол багажнаас гарсан шингээлтийн утгыг 10-аар үржүүлж мкг/л-ээр илэрхийлнэ.

5.2.2.2 Цусанд зэс тодорхойлох арга [101, 103]: Судлуулагчийн цусан дахь зэсийн агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон. Шинжилгээнд судлуулагчдын судаснаас авсан ийлдсэнд зэсийн агууламжийг хөндий катодын ламп (HCL) ашиглан 327.4 нм долгионы уртад шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Зэс тодорхойлоход матриц засах уусмал ашиглахгүйгээр шууд ийлдсэнд үзнэ.

Урвалж

1. Азотын хүчил (HNO_3), химийн цэвэршилттэй, хүнд металлын агуулга нь <0.1 ppb байх
2. 1000 мг/л зэсийн стандарт уусмал
3. Ионгүйжүүлсэн ус
4. 99.999% цэвэршилттэй аргон хий
5. Автомат дээж авагчийн 2 мл хэмжээтэй бичил аяга

Урвалж бэлтгэх дараалал

1. 1 мг/л зэсийн стандарт уусмал бэлдэх: 1000 мг/л-ийн зэсийн стандарт уусмалаас 0.1 мл-ийг 100 мл-ийн хэмжээст колбонд хийж дээр нь 0.2 мл цэвэршүүлсэн концентрацитай HNO_3 нэмнэ. Дараа нь ионгүйжүүлсэн усаар хэмжээс хүртэл дүүргэнэ.
2. Ажлын уусмал бэлдэх

1 мг/л Cu	HNO_3 концентрацитай	Хэмжээст колбо	Бэлтгэсэн ажлын уусмалын концентраци
0.025 мл	0.2 мл	50 мл	0.5 мкг/л
0.05 мл	0.2 мл	50 мл	1 мкг/л
0.150 мл	0.2 мл	50 мл	3 мкг/л
0.250 мл	0.2 мл	50 мл	5 мкг/л
0.5 мл	0.2 мл	50 мл	9 мкг/л

Шинжилгээний явц

Атом шингээлтийн спектрометр багажын программын аргачлалын дагуу тухайн тодорхойлох элементийн долгионы урт, сорьцын хэмжээ, стандарт утга зэрэг аргын өгөгдлүүдийг урьдчилан тохируулна.

Графит зуухны тохируулга

Ажиллах дараалал	Темп. (°C)	Налуу (сек)	Барилт (сек)	Хийн урсгал (мл/мин)	Хийн төрөл
Хатаах 1	110	1	25	250	Аргон хий
Хатаах 2	130	15	15	250	
Пиролиз	600	10	20	250	
Атомжуулах	1800	0	5	0	
Цэвэрлэх	2600	1	5	250	

Дээжийг шинжлэх

1. Автомат дээж авагчийн 2 мл-ийн бичил аяганд шингэрүүлсэн ажлын уусмал тус бүрээс 1000 мкл хийнэ. Энэ нь калибровкийн муруй байгуулах стандарт уусмалууд болно.
2. Дээжийг уншуулахдаа автомат дээж авагчийн 2 мл-ийн өөр бичил аяганд ионгүйжүүлсэн уснаас 900 мкл +100 мкл ийлдэс хийж уншуулна.
3. Багажийн мэдрэх хязгаараас их концентрацитай дээж байвал сорьцыг матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлнэ.

Хоосон туршилт

Шинжилгээнд хэрэглэж буй шил сав болон урвалж бодисын цэвэршилтийг хянахын тулд дээжний оронд ионгүйжүүлсэн усыг ашиглан дээжийг шинжлэх хэсгийн хоёр дахь аргын дагуу явуулна.

Үр дүнгийн боловсруулалт

Бэлтгэсэн уусмалыг атом шингээлтийн спектрометр багаж дээр хоосон туршилтын хамт уншуулан, тодорхойлох уусмалын хүнд металлын утгаас хоосон туршилтын утгыг хасаж тооцоо хийнэ. Хэрэв дээжийг матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлсэн бол багажнаас гарсан шингээлтийн утгыг 10-аар үржүүлж мкг/л-ээр илэрхийлнэ.

5.3.2.3 Цусанд төмөр тодорхойлох арга [101, 104-105]: Судалгаанд хамрагдагсдын цусан дахь төмрийн агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон. Энэхүү арга нь бүхэл цусанд хөндий катодтай ламп (HCL) ашиглан 248.3 нм долгионы уртад шинжлэнэ. Бүхэл цусан дээр магнийн нитрат агуулсан матриц засах уусмал нэмж тогтворжуулж шинжилнэ.

Урвалж:

1. Азотын хүчил (HNO₃), химийн цэвэршилттэй, хүнд металлын агуулга нь <0.1 ppb байх
2. 1000 мг/л төмрийн стандарт уусмал
3. Ионгүйжүүлсэн ус
4. 10 г/л концентрацитай магнийн нитрат Mg(NO₃)₂
5. 99.999% цэвэршилттэй аргон хий
6. Автомат дээж авагчийн 2 мл хэмжээтэй бичил аяга

Урвалж бэлтгэх дараалал

1. Матриц засах уусмал: 10 г/л концентрацитай магнийн нитрат $Mg(NO_3)_2$ стандарт уусмалыг матриц засах уусмал болгож хэрэглэнэ.
2. мг/л төмрийн стандарт уусмал бэлдэх: 1000 мг/л-ийн төмрийн стандарт уусмалаас 1 мл-ийг 100 мл-ийн хэмжээст колбонд хийж дээр нь 0.2 мл цэвэршүүлсэн концентрацитай азотын хүчил нэмж, хэмжээс хүртэл ионгүйжүүлсэн усаар дүүргэнэ.

Ажлын уусмал бэлдэх:

10 мг/л Fe	HNO_3 концентрацитай	Хэмжээст колбо	Төмрийн ажлын уусмал
0.05 мл	0.2 мл	50 мл	10 мкг/л
0.25 мл	0.2 мл	50 мл	50 мкг/л
0.5 мл	0.2 мл	50 мл	100 мкг/л
1 мл	0.2 мл	50 мл	200 мкг/л
1.5 мл	0.2 мл	50 мл	300 мкг/л

Шинжилгээний явц

Атом шингээлтийн спектрометр багажийн программын аргачлалын дагуу тухайн тодорхойлох элементийн долгионы урт, сорьцын хэмжээ, стандарт утга зэрэг аргын өгөгдлүүдийг урьдчилан тохируулна.

Графит зуухны тохиргоо

Ажиллах дараалал	Темп. (°C)	Налуу (сек)	Барилт (сек)	Хийн урсгал (мл/мин)	Хийн төрөл
Хатаах 1	120	5	25	250	Аргон хий
Хатаах 2	140	15	15	250	
Пиролиз	1400	10	20	250	
Атомжуулах	2400	0	5	0	
Цэвэрлэх	2500	1	5	250	

Дээжийг шинжлэх

1. Автомат дээж авагчийн 2 мл-ийн бичил аяганд шингэрүүлсэн ажлын уусмал тус бүрээс 100 мкл-ийг авч + 900 мкл матриц засах уусмалаас хийнэ. Энэ нь калибровкийн муруй байгуулах стандарт уусмалууд болно.
2. Дээжийг уншуулахдаа автомат дээж авагчийн 2 мл-ийн өөр бичил аяганд матриц засах уусмалаас 900 мкл + 100 мкл цусны дээж хийж уншуулна.
3. Багажийн мэдрэх хязгаараас их концентрацитай дээж байвал сорьцыг матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлнэ.

Хоосон туршилт

Шинжилгээнд хэрэглэж буй шил сав болон урвалж бодисын цэвэршилтийг хянахын тулд дээжний оронд ионгүйжүүлсэн усыг ашиглан дээжийг шинжлэх хэсгийн хоёр дахь аргын дагуу явуулна.

Үр дүнгийн боловсруулалт

Бэлтгэсэн уусмалыг атом шингээлтийн спектрометр багаж дээр хоосон туршилтын хамт уншуулан, тодорхойлох уусмалын хүнд металлын утгаас хоосон туршилтын утгыг хасаж тооцоо хийнэ. Матриц засах уусмалаар 10 дахин шингэрүүлсэн гэж тооцон багажнаас гарсан шингээлтийн утгыг 10-аар үржүүлж мкг/л-ээр илэрхийлнэ.

5.3.3 Цусан дахь уургийн бодисууд тодорхойлох

5.3.3.1 Цусанд нийт уураг тодорхойлох арга: Зэсийн ион шүлтлэг уусмал дахь уурагтай урвалд орж нил ягаан өнгийн нэгдэл үүсгэдэг. Энэ нэгдлийн гэрлийн шингээлт нь дээжинд агуулагдаж байгаа уургийн концентрацийг илэрхийлдэг.

Шинжилгээний явц:

1. 1000 мкл урвалжийг хоосон хуруу шилэнд хийж бланк болгож ашиглана.
2. 20 мкл дээжин дээр 1000 мкл урвалжийг хийж холиод 20-25°C-ийн температурт 10 минут байлгана.
3. Дараа нь 30 минутын дотор хоосон бланк болон дээжтэй холимогийн шингээлтийг 546 нм-ийн долгионы уртад хэмжиж, ΔA -г гаргана.

Үр дүнгийн тооцоолол:

Дараах томъёогоор бодож үр дүнг гаргана.

- Фактортай

$$C = 19 \times \Delta A \left[\frac{\text{г}}{\text{дл}} \right] \quad \text{эсвэл} \quad C = 190 \times \Delta A \left[\frac{\text{г}}{\text{л}} \right]$$

- Стандарттай

$$C = 8 \times \frac{\Delta A_{\text{дээж}}}{\Delta A_{\text{стандарт}}} [\text{г/дл}] \quad \text{эсвэл} \quad C = 80 \times \frac{\Delta A_{\text{дээж}}}{\Delta A_{\text{стандарт}}} [\text{г/л}]$$

5.3.3.2 Цусанд альбумин тодорхойлох арга: Цитратын буфер дэх альбумин нь бромкрезолтой нэгдэж ногоон өнгийн өнгөт нэгдэл үүсгэх бөгөөд энэ нэгдлийн гэрлийн шингээлт нь дээжинд агуулагдаж байгаа альбумины концентрацийг илэрхийлдэг.

Шинжилгээний явц:

1. 1000 мкл урвалжийг хоосон хуруу шилэнд хийж бланк болгож ашиглана.
2. 10 мкл дээжинд 1000 мкл урвалжийг хийж холиод 20-25°C-ийн температурт 5 минут байлгана.
3. 30 минутын дотор хоосон бланк болон дээжтэй холимогийн шингээлтийг 546 нм-ийн долгионы уртад хэмжиж, ΔA -г гаргана.

Үр дүнгийн тооцоолол:

$$C = 4 \times \frac{\Delta A_{\text{дээж}}}{\Delta A_{\text{стандарт}}} [\text{г/дл}] \quad \text{эсвэл} \quad C = 40 \times \frac{\Delta A_{\text{дээж}}}{\Delta A_{\text{стандарт}}} [\text{г/л}]$$

5.3.3.3 Цусанд преальбумин уураг тодорхойлох арга: Цэвэршүүлсэн хүний преальбумины эсрэг бие ашиглаж микро титрийн хавтангийн нүд тус бүрийг бүрж, эсрэг биеийн хатуу фазыг бий болгодог. Дараа нүд тус бүрт преальбумин нэмж өгснөөр HRP-тэй эсрэг бие холбогдож, эсрэг бие (антибоди) – эсрэгтөрөгч (антиген) – энзим – эсрэг биеийн комплекс үүсгэдэг. Дараа нь сайтар угаана. Бүрэн угаасны дараа TMB субстрат уусмалыг нэмнэ. TMB субстрат нь HRP энзимийн нөлөөгөөр катализад орж цэнхэр өнгөтэй болдог. Хүхрийн хүчлийн уусмал нэмж урвалыг дуусгах ба өнгөний өөрчлөлтийг 450 нм-ийн долгионы уртад спектрофотометрээр хэмжиж дээжин дэх хүний преальбумины түвшинг шинжилдэг кит юм. Дээжийн преальбумины агууламжийг стандарт муруй, дээжийн гэрэл шингээлтийг харьцуулж тодорхойлно.

Шинжилгээний явц:

1. Стандарт нэмэх: Стандарт тус бүрээс 50 мкл-ийг авч нүд тус бүрт хийнэ.
2. Дээж нэмэх: Бланкийн нүдийг тусад нь хоосон орхино (бланкийн нүдэнд дээж болон HRP-Conjugate урвалж хийхгүй бусад алхамуудыг яг ижил хийнэ). Дээжийн нүд тус бүрт 40 мкл дээж шингэлэгч уусмалыг хийнэ дараа нь нүд тус бүрт 10 мкл туршилтийн дээжийг нэмнэ (дээжийн эцсийн шингэрүүлэлт 5 дахин шингэрүүлсэн байна). Дээж нэмсэн нүхнүүдийн хананд аль болохоор хүргэхгүйгээр зөөлөн холино.
3. Энзим нэмэх: Бланкийн нүднээс бусад нүд тус бүр дээр 100 мкл HRP-Conjugate урвалжийг нэмнэ.
4. Инкубаци хийх: Дараа хавтанг хавтан хаах мембранаар таглаад 37⁰С-т 60 минут инкубацлана.
5. Шингэнийг тохируулах: Угаагч уусмалыг нэрсэн усаар 20 дахин шингэлж, хадгална.
6. Угаах: Хавтан хаах мембраныг хуулж аваад, шингэнийг асгана (хаяна), сальфеткан дээр савлаж үлдэгдэл шингэнийг сайтар сэгсэрч хатаана, нүд тус бүрт угаагч буферыг нэмнэ, 30-аас доошгүй удаа сэгсэрч усыг шавхана, дээрх үйлдлийг 5 удаа давтана, сайтар хатаана.
7. Өнгө: Нүд тус бүр дээр Chromogen A уусмал болон chromogen B уусмалуудаас 50 мкл-ийг нэмнэ, 37⁰С-т 15 минут гэрлээс хол байлгана.
8. Зогсоох уусмал: Нүд тус бүр дээр 50 мкл зогсоогч уусмал нэмж урвалыг зогсооно (цэнхэр өнгө өөрчлөгдөж шар өнгөтэй болно).
9. Шинжилгээ: Зогсоогч уусмал нэмсний дараа 15 минутын дотор 450 нм долгионы уртад шингээлтийг уншуулна.

Тооцоолох:

Стандартын агууламжийг хэвтээ тэнхлэгт, гэрэл шингээлтийг босоо тэнхлэгт байрлуулж, стандарт муруйг байгуулна. Стандарт муруйнаас дээжийн гэрэл шингээлтийн утгын дагуу харгалзах агууламжийг олж тогтооно, шингэрүүлсэн бол шингэрүүлэлтээр үржүүлнэ. Эсвэл гэрэл шингээлт болон стандартын агууламжаар байгуулсан стандарт муруйн шулуун шугаман регрессийн тэгшитгэлийг тооцоолж, дээжийн гэрэл шингээлтийн утгыг тухайн тэгшитгэлд орлуулж, дээжийн агууламжийг тодорхойлно.

Мэдрэх хязгаар: 25 мкг/мл – 800 мкг/мл

Анхааруулга:

1. Китийг хөргөгчнөөс гаргаад тасалгааны температурт 15-30 минут байлгана, хэрэв ELISA хавтангуудыг нээсний дараа ашиглаагүй бол бүрж, битүүмжилсэн саванд хийж хадгална.
2. Хэрэв туршилтын материалын агуулга хэтэрхий өндөр байвал (дээжний гэрэл шингээлт анхны стандартаас их бол), дээжийн шингэлнэ (n-дахин), шингэрүүлэлтийг тооцоохдоо шингэрүүлэлтийн фактораар үржүүлнэ (*n*5).
3. Хөндлөнгийн бохирдлоос зайлсхийхийн тулд хавтан хаах мембраныг нэг л удаа хэрэглэнэ, дахин хэрэглэж болохгүй.
4. Субстратыг гэрлийн шууд тусгалаас хол хадгална.
5. Дээж бүрийг угаахдаа халдвараас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж ажиллана.
6. Өөр бусад урвалжтай урвалжуудыг хольж болохгүй.
7. Дээж бүрийг угаахдаа халдвараас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж ажиллана.
8. Өөр бусад урвалжтай урвалжуудыг хольж болохгүй.

5.3.3.4 Цусанд трансферрин тодорхойлох арга: Цэвэршүүлсэн хүний трансферрины эсрэг биеийг ашиглаж микро титрийн хавтангийн нүд тус бүрийг бүрж, эсрэг биеийн хатуу фазыг бий болгодог. Дараа нүд тус бүрт трансферрин нэмж өгснөөр HRP-тэй эсрэг бие холбогдож, эсрэг бие (антибоди) – эсрэгтөрөгч (антиген) – энзим – эсрэг биеийн комплекс үүсгэдэг. Дараа нь сайтар угаана. Бүрэн угаасны дараа TMB субстрат уусмалыг нэмнэ. TMB субстрат нь HRP энзимийн нөлөөгөөр катализад орж цэнхэр өнгөтэй болдог. Хүхрийн хүчлийн уусмал нэмж урвалыг дуусгах ба өнгөний өөрчлөлтийг 450 нм-ийн долгионы уртад спектрофотометрээр хэмжиж дээжин дэх хүний трансферриний түвшинг шинжилдэг кит юм. Дээжийн трансферринийн агууламжийг стандарт муруй, дээжийн гэрэл шингээлтийг харьцуулж тодорхойлно.

Шинжилгээний явц:

1. Стандарт нэмэх: Стандарт тус бүрээс 50 мкл-ийг авч нүд тус бүрт хийнэ.
2. Дээж нэмэх: Бланкийн нүдийг тусад нь хоосон орхино (бланкийн нүдэнд дээж болон HRP-Conjugate урвалж хийхгүй бусад алхамуудыг яг ижил хийнэ). Дээжийн нүд тус бүрт 40 мкл дээж шингэлэгч уусмалыг хийнэ дараа нь нүд тус бүрт 10 мкл туршилтийн дээжийг нэмнэ (дээжийн эцсийн шингэрүүлэлт 5 дахин шингэрүүлсэн байна). Дээж нэмсэн нүхнүүдийн хананд аль болохоор хүргэхгүйгээр зөөлөн холино.
3. Энзим нэмэх: Бланкийн нүднээс бусад нүд тус бүр дээр 100 мкл HRP-Conjugate урвалжийг нэмнэ.
4. Инкубаци хийх: Дараа хавтанг хавтан хаах мембранаар таглаад 37⁰C-т 60 минут инкубацлана.
5. Шингэнийг тохируулах: Угаагч уусмалыг нэрсэн усаар 20 дахин шингэлж, хадгална.
6. Угаах: Хавтан хаах мембраныг хуулж аваад, шингэнийг асгана (хаяна), сальфеткан дээр доош харуулан тавьж, ёроол дээр нь догшиж, үлдэгдэл

шингэнийг сайтар сэгсэрч хатаана, нүд тус бүрт угаагч буферыг нэмээд 30 секунд байлгасны дараа сальфеткан дээр доош харуулан тавьж, ёроол дээр нь тогшиж, үлдэгдэл шингэнийг сайтар сэгсэрнэ. Дээрх үйлдлийг 5 удаа давтаж, сайтар хатаана.

7. Өнгө: Нүд тус бүр дээр Chromogen A уусмал болон chromogen B уусмалуудаас 50 мкл-ийг нэмнэ, 37°C-т 15 минут гэрлээс хол байлгана.
8. Зогсоох уусмал: Нүд тус бүр дээр 50 мкл зогсоогч уусмал нэмж урвалыг зогсооно (цэнхэр өнгө өөрчлөгдөж шар өнгөтэй болно).
9. Шинжилгээ: Зогсоогч уусмал нэмсний дараа 15 минутын дотор 450 нм долгионы уртад шингээлтийг уншуулна.

Тооцоолох:

Стандартын агууламжийг хэвтээ тэнхлэгт, гэрэл шингээлтийг босоо тэнхлэгт байрлуулж, стандарт муруйг байгуулна. Стандарт муруйнаас дээжийн гэрэл шингээлтийн утгын дагуу харгалзах агууламжийг олж тогтооно, шингэрүүлсэн бол шингэрүүлэлтээр үржүүлнэ. Эсвэл гэрэл шингээлт болон стандартын агууламжаар байгуулсан стандарт муруйн шулуун шугаман регрессийн тэгшитгэлийг тооцоолж, дээжийн гэрэл шингээлтийн утгыг тухайн тэгшитгэлд орлуулж, дээжийн агууламжийг тодорхойлно.

Мэдрэх хязгаар: 0.25 г/мл – 8 г/мл

Анхааруулга:

1. Китийг хөргөгчнөөс гаргаад тасалгааны температурт 15-30 минут байлгана, хэрэв ELISA хавтангуудыг нээсний дараа ашиглаагүй бол бүрж, битүүмжилсэн саванд хийж хадгална.
2. Хэрэв туршилтын материалын агуулга хэтэрхий өндөр байвал (дээжний гэрэл шингээлт анхны стандартаас их бол), дээжийн шингэлнэ (n-дахин), шингэрүүлэлтийг тооцоохдоо шингэрүүлэлтийн фактораар үржүүлнэ (*n*5).
3. Хөндлөнгийн бохирдлоос зайлсхийхийн тулд хавтан хаах мембраныг нэг л удаа хэрэглэнэ, дахин хэрэглэж болохгүй.
4. Субстратыг гэрлийн шууд тусгалаас хол хадгална.
5. Дээж бүрийг угаахдаа халдвараас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж ажиллана.
6. Өөр бусад урвалжтай урвалжуудыг хольж болохгүй.
7. Дээж бүрийг угаахдаа халдвараас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж ажиллана.
8. Өөр бусад урвалжтай урвалжуудыг хольж болохгүй.

5.3.3.5 Цусанд ретинол холбогч уураг тодорхойлох арга: Цусанд ретинол холбогч уураг (РХУ)-ийн агууламжийг судлуулагчдын хураагуур судаснаас авсан цусны ийлдсэнд фермент холбоот иммунохимийн аргаар тодорхойлсон болно. Цэвэршүүлсэн хүний РХУ-ийн эсрэг бие ашиглаж микро титрийн хавтангийн нүд тус бүрийг бүрж, эсрэг биеийн хатуу фазыг бий болгодог. Дараа нүд тус бүрт РХУ-ийг нэмж өгснөөр HRP-тэй эсрэг бие холбогдож, эсрэг бие (антибоди) – эсрэгтөрөгч (антиген) – энзим – эсрэг биеийн комплекс үүсгэдэг. Дараа нь сайтар угаана. Бүрэн

угаасны дараа TMB субстрат уусмалыг нэмнэ. TMB субстрат нь HRP энзимийн нөлөөгөөр катализад орж цэнхэр өнгөтэй болдог. Хүхрийн хүчлийн уусмал нэмж урвалыг дуусгах ба өнгөний өөрчлөлтийг 450 нм-ийн долгионы уртад спектрофотометрээр хэмжиж дээжин дэх хүний РХУ-ийн түвшинг шинжилдэг кит юм. Сорьцын РХУ-ийн агууламжийг стандарт муруй, дээжийн гэрэл шингээлтийг харьцуулж тодорхойлно.

Шинжилгээний явц:

1. Стандарт нэмэх: Стандарт тус бүрээс 50 мкл-ийг авч нүд тус бүрт хийнэ.
2. Дээж нэмэх: Бланкийн нүдийг тусад нь хоосон орхино (бланкийн нүдэнд дээж болон HRP-Conjugate урвалж хийхгүй бусад алхамуудыг яг ижил хийнэ). Дээжийн нүд тус бүрт 40 мкл дээж шингэлэгч уусмалыг хийнэ дараа нь нүд тус бүрт 10 мкл туршилтийн дээжийг нэмнэ (дээжийн эцсийн шингэрүүлэлт 5 дахин шингэрүүлсэн байна). Дээж нэмсэн нүхнүүдийн хананд аль болохоор хүргэхгүйгээр зөөлөн холино.
3. Энзим нэмэх: Бланкийн нүднээс бусад нүд тус бүр дээр 100 мкл HRP-Conjugate урвалжийг нэмнэ.
4. Инкубаци хийх: Дараа хавтанг хавтан хаах мембранаар таглаад 37°C-т 60 минут инкубацлана.
5. Шингэнийг тохируулах: Угаагч уусмалыг нэрсэн усаар 20 дахин шингэлж, хадгална.
6. Угаах: Хавтан хаах мембраныг хуулж аваад, шингэнийг асгана (хаяна), сальфеткан дээр доош харуулан тавьж, ёроол дээр нь догшиж, үлдэгдэл шингэнийг сайтар сэгсэрч хатаана, нүд тус бүрт угаагч буферыг нэмээд 30 секунд байлгасны дараа сальфеткан дээр доош харуулан тавьж, ёроол дээр нь догшиж, үлдэгдэл шингэнийг сайтар сэгсэрнэ. Дээрх үйлдлийг 5 удаа давтаж, сайтар хатаана.
7. Өнгө: Нүд тус бүр дээр Chromogen A уусмал болон chromogen B уусмалуудаас 50 мкл-ийг нэмнэ, 37°C-т 15 минут гэрлээс хол байлгана.
8. Зогсоох уусмал: Нүд тус бүр дээр 50 мкл зогсоогч уусмал нэмж урвалыг зогсооно (цэнхэр өнгө өөрчлөгдөж шар өнгөтэй болно).
9. Шинжилгээ: Зогсоогч уусмал нэмсний дараа 15 минутын дотор 450 нм долгионы уртад шингээлтийг уншуулна.

Тооцоолох:

Стандартыг агууламжийг хэвтээ тэнхлэгт, гэрэл шингээлтийг босоо тэнхлэгт байрлуулж, стандарт муруйг байгуулна. Стандарт муруйнаас дээжийн гэрэл шингээлтийн утгын дагуу харгалзах агууламжийг олж тогтооно, шингэрүүлсэн бол шингэрүүлэлтээр үржүүлнэ. Эсвэл гэрэл шингээлт болон стандартын агууламжаар байгуулсан стандарт муруйн шулуун шугаман регрессийн тэгшитгэлийг тооцоолж, дээжийн гэрэл шингээлтийн утгыг тухайн тэгшитгэлд орлуулж, дээжийн агууламжийг тодорхойлно.

Мэдрэх хязгаар: 2.5 мкг/мл – 80 мкг/мл

Анхааруулга:

1. Китийг хөргөгчнөөс гаргаад тасалгааны температурт 15-30 минут байлгана, хэрэв ELISA хавтангуудыг нээсний дараа ашиглаагүй бол бүрж, битүүмжилсэн саванд хийж хадгална.
2. Хэрэв туршилтын материалын агуулга хэтэрхий өндөр байвал (дээжний гэрэл шингээлт анхны стандартаас их бол), дээжийг шингэлнэ (n-дахин), шингэрүүлэлтийг тооцоохдоо шингэрүүлэлтийн фактораар үржүүлнэ (*n*5).
3. Хөндлөнгийн бохирдлоос зайлсхийхийн тулд хавтан хаах мембраныг нэг л удаа хэрэглэнэ, дахин хэрэглэж болохгүй.
4. Субстратыг гэрлийн шууд тусгалаас хол хадгална.
5. Дээж бүрийг угаахдаа халдвараас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж ажиллана.
6. Өөр бусад урвалжтай урвалжуудыг хольж болохгүй.

5.3.3.6 Ц урвалжит уураг тодорхойлох арга: Энэхүү арга нь хүний ийлдэсний дээжинд Ц урвалжит уураг (ЦУУ)-ийг хагас тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхойлох арга юм. ЦУУ-ийн эсрэг биеэр бүрхэгдсэн латексын хэсэгтэй үл мэдэгдэх ийлдэсийг хийхэд нүдэнд харагдахуйц агглютинаци явагдаж байвал ЦУУ-ийн түвшин өссөн байна гэж үзнэ. ЦУУ нь хэвийн ийлдсэн дэх хурц /цочмог/ үрэвслийн үед илэрдэг уураг ба Pneumococcus-ын C полисахаридыг тунадасжуулах чадвартай. Тухайн уураг нь бактерийн болон вирусын халдварын, үрэвслийн үед ийлдсэнд нэмэгддэг.

Шинжилгээнд ашиглагдах урвалж, бодис:

- Латекс - 2 мл
- Эерэг хяналт - 0.5 мл
- Сөрөг хяналт - 0.5 мл
- Урвалын хавтан
- Холигч хутгуур

Шинжилгээнд ашиглагдах материал:

- Жижиг шил эсвэл хуванцар тюрб
- Серологийн пипетка
- Цаг

Чанарын аргын үйл явц:

1. Хэрэглэгдэх бүх зүйлсийг өрөөний температурт байлгана.
2. Латекс урвалжийг зөөлөн сэгсэрч холино.
3. Урвалын хавтангийн бөөрөнхий хэсэгт шингэлээгүй дээжний ийлдсийг дусаана.
4. Латексын урвалжаас нэг дуслыг дусаана.
5. Холигч хутгуураар сайтар холино.
6. 2 минутын турш 2 секунд тутамд нэг удаа холимогтой урвалын хавтангаа 30⁰ эргүүлнэ.
7. Сүүлд нь урвалын хавтанг нэрмэл усаар угааж, хуурай болгоно.

Шинжилгээний үр дүнгийн тайлбар:

- Дээж + байвал ЦУУ түвшин их буюу агглютинаци илэрсэнийг илтгэнэ.
- Дээж - байвал ЦУУ түвшин бага буюу агглютинаци явагдаагүйг илтгэнэ.

5.3.4 Цусан дахь аминдэмүүд тодорхойлох

5.3.4.1 Цусан дахь аминдэм В₆, В₉, В₁₂ тодорхойлох [106]

Шингэний хроматографи гэдэг нь шингэн төлөвт орших хөдөлгөөнт фазын тусламжтайгаар (хөдөлгөөнт ба үл хөдлөх фазуудын хооронд бодисын бүрэлдэхүүн хэсгүүд харилцан адилгүй тархан түгэж үйлчлэлцэх зарчим дээр үндэслэн) олон бодисуудын холимгийг хооронд нь ялган салгах буюу шинжилгээ хийх арга юм. Энэхүү арга нь цусны ийлдсэнд Өндөр үзүүлэлт шингэний хроматографийн багаж ашиглан UV/VIS тодорхойлогч дээр В₉, В₆ аминдэмүүдийг 280 нм, В₁₂ аминдэмийг 230 нм долгионы уртад шинжилнэ.

Тоног төхөөрөмж:

Өндөр үзүүлэлтэт шингэний хроматографи (Perkin Elmer, Flexar LC)

- Хэт ягаан туяа-үзэгдэх гэрлийн детектор (UV /VIS detector)
- Багана ZORBAX Eclipse Plus C18, 3.0x150мм, 3.5мкм
- Хамгаалагч колонк ZORBAX Eclipse Plus, Guard Column
- Хэт авиан усан банн
- Аналитик жин, 0,0001гр нарийвчлалтай
- Центрфуг, 15000 эрг/мин
- 2 толгойтой насос
- рН метр,
- Хуруу шил сэгсрэгч
- Вакуум ууршуулагчтай центрфуг

Урвалж:

Хүснэгт 1. Хэрэглэгдэх урвалж, бодисын жагсаалт

№	Урвалж бодисын нэр	Олон улсын нэршил	Цэвэршилт
1	Метилийн спирт	Methanol	HPLC, ≥99.5%
2	Гурван фторт цууны хүчил	Trifluoroacetic acid (TFA)	HPLC, ≥99.0%
3	н-Гексан	n-Hexane	HPLC, ≥99.0%
4	Этилийн спирт	Ethanol	HPLC, ≥99.0%
5	Фолийн хүчил (В ₉)	Folic acid	HPLC, ≥99.5%
6	Пиридоксин (В ₆)	Pyridoxine	HPLC, ≥99.5%
7	Цианокобаламин (В ₁₂)	Cyanocobalamin	HPLC, ≥99.5%

Жич: Шинжилгээнд хэрэглэж байгаа бодис урвалжууд нь ӨҮШХ-ийн шинжилгээнд зориулсан цэвэршилттэй бодис, урвалжууд ашиглана.

Урвалж бэлтгэх дараалал:

0.01%-ийн гурван фторт цууны хүчлийн буфер (рН=2.9) бэлтгэх:

1000 мл-ийн хэмжээст колбонд ойролцоогоор 2/3 хүртэл ионгүйжүүлсэн ус хийж, дээрээс нь концентрацитай гурван фторт цууны хүчлээс 100 мкл-ийг хэмжин авч ионгүйжүүлсэн устай 1000 мл-ийн хэмжээст колбонд хийн, сайтар уусгаад хэмжээс хүртэл нь ионгүйжүүлсэн усаар дүүргэнэ. Бэлтгэсэн уусмалыг вакуум шүүгч багажны 0.45 микроны мембран шүлтүүрээр шүүнэ. Шүүсэн уусмалаа хроматографийн багажны хөдөлгөөнт фазны тусгай шилэн саванд юулж, хэт авиан усан баннд 120 минут тавьж хийн бөмбөлгийг арилгаж шинжилгээнд хэрэглэнэ.

1М-ийн натрийн карбонат бэлтгэх:

Натрийн карбонатын давснаас 16.4 граммыг 0.0001 г-ын нарийвчлалтай жинлэн авч 200 мл-ийн хэмжээст колбонд хийж ионгүйжүүлсэн ус (хэрэв натрийн карбонат уусахгүй бол бага зэрэг халааж өгнө) хийн сайтар уусгана.

Ажлын уусмал бэлтгэх:

V_6 болон V_{12} аминдэмийн стандартаас тус бүр 0.01 г-ыг 0.0001 нарийвчлалтай жинлэн авч 50 мл-ийн хэмжээст колбонд хийнэ. Гурван фторт цууны хүчлийн буфер ($pH=2.9$) уусмал нэмж сайтар уусгаад, хэмжээс хүртэл дүүргэнэ. Энэ нь V_6 болон V_{12} аминдэмийн 200 нг/мкл-ийн агууламжтай стандарт уусмал болно.

V_9 аминдэмийн стандартаас 0.005 г-ыг 0.0001 нарийвчлалтай жигнэн авч 50 мл-ийн хэмжээст колбонд хийнэ. 1М-ийн натрийн карбонатын уусмал нэмж сайтар уусгаад, хэмжээс хүртэл дүүргэнэ. Энэ нь V_9 аминдэмийн 100 нг/мкл-ийн агууламжтай стандарт уусмал болно.

Стандарт уусмал бэлтгэх:

V_6 болон V_{12} аминдэмүүдийн стандарт холимог уусмалаас 200, 100, 50, 25, 12.5, 0 нг/мкл концентрацитай байхаар, харин V_9 аминдэмийн стандарт уусмалыг 100, 50, 25, 12.5, 6.25, 0 нг/мкл концентрацитай байхаар гурван фторт цууны хүчлийн буфер ($pH=2.9$) уусмалаар шингэрүүлнэ. Бэлтгэсэн стандарт уусмалуудыг 0.22 микроны шүүлтүүрээр шүүж шинжилгээнд хэрэглэнэ. Хадгалах шаардлагатай бол $-40^{\circ}C$ -т нэг сар хадгална.

Сорьц цуглуулах:

Хураагуур судсыг хатгаж, шинжилгээнд цусны дээж авахдаа “Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд MNS 4621:2008” стандартыг баримтлан ажиллана. Хураагуур судаснаас цус авахдаа ямар нэгэн нэмэлтгүй вакум хуруу шил ашиглана. Цусны ийлдэс ялгахдаа цусны хуруу шилний зориулалтын тавиурт хийж бүлэгнэх хугацаа буюу 30-40 минутын турш тасалгааны хэмд байлгасны дараа 1500 эрг/мин хурдтайгаар 10-15 минут центрифугдэж ийлдсийг ялган авна. Ийлдсийг $-40^{\circ}C$ -д хадгална

Дээж бэлтгэх:

Хөлдөөж хадгалсан дээжийг тасалгааны температурт гэсгээж, бичил хуруу шилэнд 400 мкл таслан авч, 600 мкл н-гексан нэмэн, 30 секунд сэгсрэгчээр (vortex) сэгсэрнэ. Дараа нь хөргөлттэй центрифуг ашиглан $4^{\circ}C$ -д, 5000 эрг/мин хурдтайгаар 5 минут центрифугдэж, дууссаны дараа 95:5 харьцаатай этанол, метанолын холимог уусмалаас 150 мкл нэмж, 30 секунд сэгсрэгчээр (vortex) сэгсэрч, хөргөлттэй центрифугээр $4^{\circ}C$ -т 15000 эрг/мин хурдтайгаар 20 минут центрифугдэнэ. Хөргөлттэй центрифугээс гарган аваад супернатант (органик фаз) хэсгийг ялган авна. Дундах хэсгийг (усан фаз) шинэ бичил хуруу шил рүү шилжүүлнэ (Зураг 2). Бичил хуруу шилтэй усан фазыг $30^{\circ}C$ -т, 1500 эрг/мин хурдтайгаар 2 цаг 30 минут Speed Vac concentrator багажаар хатаана. Бичил хуруу шилтэй бүрэн хатсан дээжийг 1000 мкл буфер уусмалд уусгаад, 0.45 микроны филтрээр шүүж ӨҮШХ-ийн багажинд тарина.

ӨҮШХ-ийн багажийг шинжилгээнд бэлтгэх: ӨҮШХ-ын багажаар шинжилгээг хийхийн өмнө багажийн даралтыг тогтворжуулж, колонкийг метанол болон

ионгүйжүүлсэн ус (80:20)-аар угааж, багажийн хэвийн ажиллагааг шалгаж, суурь шугамыг тогтворжуулна.

Хроматографийн нөхцөл:

- А фаз: 0.01%-ийн гурван фторт цууны хүчил (pH=2.9)
- В фаз: Метанол

Дээрхи уусмалуудыг бэлтгэсний дараа шинжилгээнд ашиглахын өмнө вакуум шүүгч ашиглан 0.45 микроны мембран филтрээр шүүж хэт авианы усан баннанд 120 минутын турш хийгүүжүүлнэ. Урсгалын хурд болон элюент уусмалын харьцааг Хүснэгт 2-ын дагуу программчилна.

Хүснэгт 2. “В”-ийн төрлийн витаминуудыг салгах элюент уусмал болон урсгалын хурдны өгөгдөл


Хугацааны алхам (мин)	Урсгалын хурд (мл/мин)	А%	В%
А	Б	В	Г
1.5	0.48	70	30
3.5	0.45	70	30

- Дээжийн хэмжээ: 100мкл
- Температур: 30°C
- Долгионы урт: 230 нм, 257 нм, 280 нм

Хүснэгт 3. “В”-ийн төрлийн витаминуудыг тодорхойлох долгионы уртын өгөгдөл

Витамин	Хугацааны алхам (мин)	Долгионы урт (нм)
А	Б	В
Фолийн хүчил (B ₉)	1.5	280
Пиридоксин (B ₆)	1.0	257
Цианокобаламин (B ₁₂)	2.5	230

- Шинжилгээний үргэжлэх хугацаа: 5мин
- “В”-ийн төрлийн витаминуудын баригдах хугацаа



Зураг 1. Фолийн хүчил (200 нг/мкл), пиридоксин (200 нг/мкл) болон цианокобаламин (100 нг/мкл)-ы стандарт уусмалын холимгийг ӨҮШХ-ийн багажаар салгасан хроматограмм

График 1. В₉ аминдэмийн жиших муруй




График 2. В₆ аминдэмийн жиших муруй





График 3. В₁₂ аминдэмийн жиших муруй



Үр дүн тооцох:

Шинжилгээний үр дүнг С аминдэмийн дэс дараалсан гэрэл шингээлт, стандарт уусмалуудын шугаман хамаарлыг ашиглан багажны программаар тооцно. Дээж задаргааны дараах хатаасан дээжийг 1000 мкл буферт уусгасан тул эцсийн үр дүн дээр шингэрүүлэлтийг тооцно.

5.3.4.2 Цусан дахь С аминдэм тодорхойлох [106]

Шингэний хроматографи гэдэг нь шингэн төлөвт орших хөдөлгөөнт фазын тусламжтайгаар (хөдөлгөөнт ба үл хөдлөх фазуудын хооронд бодисын бүрэлдэхүүн хэсгүүд харилцан адилгүй тархан түгэж үйлчлэлцэх зарчим дээр үндэслэн) олон бодисуудын холимгийг хооронд нь ялган салгах буюу шинжилгээ хийх арга юм. Энэхүү арга нь цусны ийлдсэнд Өндөр үзүүлэлт шингэний хроматографийн багаж ашиглан UV/VIS тодорхойлогч дээр С аминдэмийг 230 нм долгионы уртад шинжилнэ.

Тоног төхөөрөмж:

- Өндөр үзүүлэлт шингэний хроматографи (Perkin Elmer, Flexar LC)
- Хэт ягаан туяа-үзэгдэх гэрлийн детектор (UV /VIS detector)
- Багана С18, 3.0x150мм, 3.5мкм
- Хамгаалагч колонк (Guard Column)
- Хэт авиан усан банн
- Аналитик жин, 0.0001 г нарийвчлалтай
- Хөргөлттэй центрфуг, 15000 эрг/мин

Урвалж:

Хүснэгт 1. Хэрэглэгдэх урвалж, бодисын жагсаалт

№	Урвалж бодисын нэр	Олон улсын нэршил	Цэвэршилт
1	Метилийн спирт	Methanol	HPLC, ≥99.5%
2	Гурван фторт цууны хүчил	Trifluoroacetic acid (TFA)	HPLC, ≥99.0%
3	н-Гексан	n-Hexane	HPLC, ≥99.0%
4	Этилийн спирт	Ethanol	HPLC, ≥99.0%
5	Аксорбиний хүчил (C)	Ascorbic acid	HPLC, ≥99.0%

Жич: Шинжилгээнд хэрэглэж байгаа бодис урвалжууд нь ӨҮШХ-ийн шинжилгээнд зориулсан цэвэршилттэй бодис, урвалжууд ашиглана.

Урвалж бэлтгэх дараалал:

0.01%-ийн гурван фторт цууны хүчлийн буфер (pH=2.9) бэлтгэх: 1000 мл-ийн хэмжээст колбонд ойролцоогоор 2/3 хүртэл ионгүйжүүлсэн ус хийж, дээрээс нь концентрацитай гурван фторт цууны хүчлээс 100 мкл-ийг хэмжин авч ионгүйжүүлсэн устай 1000 мл-ийн хэмжээст колбонд хийн, сайтар уусгаад хэмжээс хүртэл нь ионгүйжүүлсэн усаар дүүргэнэ. Бэлтгэсэн уусмалыг вакуум шүүгч багажны 0.45 микроны мембран шүлтүүрээр шүүнэ. Шүүсэн уусмалаа хроматографийн багажны хөдөлгөөнт фазны тусгай шилэн саванд юлж, хэт авиан усан баннд 120 минут тавьж хийн бөмбөлөгийг арилгаж шинжилгээнд хэрэглэнэ.

Ажлын уусмал бэлтгэх: С аминдэмийн стандартаас 0.01 г-ыг 0.0001 г-ын нарийвчлалтай жинлэн авч 50 мл-ийн хэмжээст колбонд хийнэ. Гурван фторт цууны хүчлийн буфер (pH=2.9) уусмал нэмж сайтар уусгаад, хэмжээс хүртэл дүүргэнэ. Энэ нь С аминдэмийн 200 нг/мкл агууламжтай ажлын уусмал болно.

Стандарт уусмал бэлтгэх: С аминдэмийн ажлын уусмалаас 200, 100, 50, 25, 12.5, 0 нг/мкл концентрацитай байхаар, гурван фторт цууны хүчлийн буфер (pH=2.9) уусмалаар шингэрүүлнэ. Бэлтгэсэн стандарт уусмалуудыг 0.22 микроны шүүлтүүрээр шүүж шинжилгээнд хэрэглэнэ. Хадгалах шаардлагатай бол -40°C-т нэг сар хадгална.

Сорьц цуглуулах:

Хураагуур судсыг хатгаж, шинжилгээнд цусны дээж авахдаа “Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд MNS 4621:2008” стандартыг баримтлан ажиллана. Хураагуур судаснаас цус авахдаа ямар нэгэн нэмэлтгүй вакуум хуруу шил ашиглана. Цусны ийлдэс ялгахдаа цустай хуруу шилийг зориулалтын тавиурт буюу 30-40 минутын турш тасалгааны хэмд байлгаж 1500 эрг/мин хурдтайгаар 10-15 минут центрифугдэж ийлдсийг ялган авна. Ийлдсийг -40°C-д хадгална (Зураг 1).

Дээж бэлтгэх:

Хөлдөөж хадгалсан дээжийг тасалгааны температурт гэсгээж, бичил хуруу шилэнд 400 мкл таслан авч, 600 мкл н-гексан нэмэн, 30 секунд сэгсрэгчээр (vortex) сэгсэрнэ. Дараа нь хөргөлттэй центрифуг ашиглан 4°C-д, 5000 эрг/мин хурдтайгаар 5 минут центрифугдэж, дууссаны дараа 95:5 харьцаатай этанол, метанолын холимог уусмалаас 150 мкл нэмж, 30 секунд сэгсрэгчээр (vortex) сэгсэрч, хөргөлттэй центрифугээр 4°C-т 15000 эрг/мин хурдтайгаар 20 минут центрифугдэнэ. Хөргөлттэй

центрифугээс гарган аваад супернатант (органик фаз) хэсгийг ялган авна. Дундах хэсгийг (усан фаз) шинэ бичил хуруу шил рүү шилжүүлнэ (Зураг 2). Бичил хуруу шилтэй усан фазыг 30°C-т, 1500 эрг/мин хурдтайгаар 2 цаг 30 минут Speed Vac concentrator багажаар хатаана. Бичил хуруу шилтэй бүрэн хатсан дээжийг 1000 мкл буфер уусмалд уусгаад, 0.45 микроны фильтрээр шүүж ӨҮШХ-ийн багажинд тарина.

ӨҮШХ-ийн багажийг шинжилгээнд бэлтгэх:

ӨҮШХ-ийн багажаар шинжилгээг хийхийн өмнө колонкийг метанол, ионгүйжүүлсэн ус (80:20)-аар угааж, багажийн даралтыг тогтворжуулж, багажийн хэвийн ажиллагааг шалган суурь шугамыг тогтворжуулна.

Хроматографийн нөхцөл:

- А фаз: 10.1-д заасны дагуу бэлтгэсэн 0.01%-ийн гурван фторт цууны хүчил (pH=2.9)
- В фаз: Метанол

Дээрх уусмалуудыг бэлтгэсний дараа шинжилгээнд ашиглахын өмнө вакуум шүүгч ашиглан 0.45 микроны мембран фильтрээр шүүж хэт авианы усан баннанд 120 минутын турш хийгүйжүүлнэ. Урсгалын хурд болон элюент уусмалын харьцааг хүснэгт 2-ын дагуу программчилна.

Хүснэгт 2. С аминдэмийг салгах элюент уусмал болон урсгалын хурдны өгөгдөл

Хугацааны алхам (мин)	Урсгалын хурд (мл/мин)	А фаз (%)	В фаз (%)
А	Б	В	Г
1.44	0.5	95	5
2.99	0.5	95	5

- Дээжийн хэмжээ: 100 мкл
- Температур: 30°C
- Шинжилгээний үргэжлэх хугацаа: 5 мин

Хүснэгт 3. С аминдэмийг тодорхойлох долгионы уртын өгөгдөл

Амин дэм	Хугацааны алхам (мин)	Долгионы урт (нм)
А	Б	В
С аминдэм	5.0	230

Хүснэгт 4. С аминдэмийн баригдах хугацаа

Баригдах хугацаа (мин)	Эхлэх хугацаа (мин)	Дуусах хугацаа (мин)
А	Б	В
1.862	1.440	2.994

Зураг 3. С амин дэмийн стандарт уусмалын хроматограмм





График 1. С аминдэмийн жиших муруй
UV/VIS 1: C



Үр дүнгийн боловсруулалт хийх

Үр дүн тооцох:

Шинжилгээний үр дүнг С аминдэмийн дэс дараалсан гэрэл шингээлт, стандарт уусмалуудын шугаман хамаарлыг ашиглан багажны программаар тооцно. Дээж задаргааны дараах хатаасан дээжийг 1000 мкл буферт уусгасан тул эцсийн үр дүн дээр шингэрүүлэлтийг тооцно.

5.4 Судалгааны үр дүнд статистик боловсруулалт хийх

5.4.1 Лавлах хэмжээ тогтоох

Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх биомаркеруудын дундаж хэмжээ болон лавлах хэмжээг тогтооходоо Эмнэлзүйн лабораторийн стандартын хүрээлэн (CLSI) болон Олон улсын клиник хими ба лабораторийн анагаах ухааны холбоо (IFCC&LM)-ноос боловсруулсан “Эмнэлзүйн лабораторийн лавлах хэмжээ тогтоох, баталгаажуулах” удирдамжийг [99] баримталсан.

5.4.2 Судалгааны мэдээллийн бааз үүсгэх, цэвэрлэх

Судалгааны мэдээлэл нь асуумж судалгааны мэдээлэл, лабораторийн шинжилгээний дүн гэсэн 2 хэсгээс тогтсон. Бүх мэдээллийг Excel программыг ашиглан компьютерийн мэдээллийн баазад шивж оруулсан. Статистикийн боловсруулалтын программд оруулсан мэдээлэлд хязгаар (ажиглалтын арга; хэт өндөр ба бага)-ын болон утгын цэвэрлэгээг хийсэн.

5.4.3 Лавлах утгыг тогтоох статистик арга

Сонгогдсон хувь хүмүүсээс авсан сорьцонд шинжилгээ хийж, хэмжилтийн утгуудыг ашиглан статистик тооцоолол хийж лавлах хэмжээг тооцсон. Лавлах хэмжээний тархалтын дүнгийн 95%-ийн итгэлцлийн хязгаарыг тооцож дээд, доод хязгаарыг оруулаад хоорондох завсарын лавлах утгуудыг тогтоосон. Энэ лавлах хэмжээг тооцоолохдоо параметрийн бус аргыг ашигласан.

Параметрийн бус аргаар лавлах хэмжээний тархалтын хэлбэрээс үл хамаарч хэмжилтийн утгуудын тархалтыг 2.5%- 97.5% хооронд 95%-ийн хязгаарт буюу нийт дүнгийн 2.5% нь доод хязгаараас их, 97.5% нь дээд хязгаараас бага байхаар тогтоосон. 95%-ийг 97.5%-аас ялгаж тооцоолохын тулд ($P=2.5$) хамгийн багадаа 39 удаагийн хэмжилт шаардлагатай [$39=(100/2.5)-1$]. Энэ аргын давуу тал нь ямарч тархалтын үед хэрэглэж боломжтой энгийн арга юм. Лавлах хэмжээг тооцоход хамгийн багадаа 120 сорьц ашиглах боловч сорьцын дүн хэвийн бус гарснаас хэвийн бус тархалтыг үзүүлж магадгүй тул аль болох олон сорьц буюу наад зах нь 120-300 сорьц авна. Хэрэв бүлэглэх шалгуурын (хүйсийн ангилал) хувьд лавлах хэмжээ нь хоорондоо ялгаатай утга гарах эсэхийг тодорхойлохын тулд бүлэг тус бүрээс хамгийн багадаа 120 хүн байхаар тооцож, түүврийн хэмжээг тодорхойлсон.

5.4.4 Өгөгдлийн алдаанд нөлөөлөх хүчин зүйлийг тооцох

Өгөгдлийн үнэн баталгаатай байдалд нөлөөлж болох алдааг олохын тулд статистик боловсруулалт хийх хэрэгтэй ба тархалтын нэг хэсэгт нөлөөлөх олон алдааны хүчин зүйлийг багасгаж, бууруулах Тукейн аргыг ашигласан.

25% – Q1

75% – Q3 гэж үзээд

IQR –ын утгыг тооцоолохдоо Q3 - Q1 ингэж тооцно.

Доод хязгаарыг олохдоо:

$Q1-1.5 \times IQR$

Дээд хязгаарыг олохдоо:

$Q3+1.5 \times IQR$ эдгээр томъёоны дагуу тооцож олсон.

Онолын хувьд энэ арга нь Гауссын тархалтад хамаарах өгөгдлийн ойролцоогоор 0.7%-ийг бууруулдаг.

5.4.5 Судалгааны түүврийн хэмжээг тооцох

95%-ийн лавлах хэмжээг тооцоолсон өгөгдлийн ажиглалтын (дээжний) тоог n гэж тэмдэглээд ажиглалтын утгыг эрэмбэлсэн. Эрэмбэлсэн утгаа r үсгээр тэмдэглэе (хамгийн бага $r = 1$, хамгийн их $r = n$ гэх мэт). Параметрийн бус аргаар лавлах хэмжээний доод утга “ $r1$ (2.5 перцентиль) $r1 = 0.025 (n+1)$ ”, лавлах хэмжээний дээд

утга “ r_2 (97.5 персентиль) $r_2 = 0.975 (n+1)$ ” тодорхойлсон. Мөн r_1, r_2 утгууд бүхэл тоо байдаггүй бөгөөд хязгаарыг r_1, r_2 утгын хоёр талын зэрэглэлд харгалзах өгөгдлийн цэгүүдийн хооронд хоёр ижил хязгаарын давхцаж буй утгыг тогтоосон. $n = 170$ байгаа тохиолдолд $r_1 - 4$ -тэй, $r_2 - 167$ -той ойрхон хамааралтай тул энэ 2 тоог төлөөлүүлэн авсан.

$$r_1 = 0.025 (171) = 4.275 \approx 4$$

$$r_2 = 0.975 (171) = 166.725 \approx 167$$

ЗУРГАА. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЦЭМЖ

6.1 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх гематологийн үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээ

Судалгаанд оролцогчдын цусны цагаан эсийн дундаж болон лавлах хэмжээг тогтоосон судалгааны дүнг (Хүснэгт 1, 2)-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн цусны цагаан эсийн дундаж $6.20 \times 10^9/\text{л}$ байсан бол, эмэгтэйчүүдийн дундаж $5.89 \times 10^9/\text{л}$ байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна ($p = 0.0964$).

Хүснэгт 1. Цусны цагаан эсийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, $10^9/\text{л}$	95% ИМ		p утга
				доод утга	дээд утга	
Цусны цагаан эс	Эрэгтэй	170	6.20	5.94	6.46	0.0964
	Эмэгтэй	170	5.89	3.92	7.86	
	Нийт	340	6.04	5.85	6.23	

Цусны цагаан эсийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд $3.98-9.11 \times 10^9/\text{л}$, эмэгтэйчүүдэд $3.50-9.08 \times 10^9/\text{л}$ байгаа нь мөн статистик ач холбогдол ялгаагүй байна.

Хүснэгт 2. Цусны цагаан эсийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, $10^9/\text{л}$	
		доод хязгаар	дээд хязгаар
Цусны цагаан эс	Эрэгтэй	3.98	9.11
	Эмэгтэй	3.50	9.08

Судалгаанд оролцогчдын цусны улаан эсийн дундаж болон лавлах хэмжээг тогтоосон судалгааны дүнг (Хүснэгт 3, 4)-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эрэгтэй хүмүүсийн цусны улаан эсийн дундаж $5.43 \times 10^{12}/\text{л}$ байсан бол, эмэгтэйчүүдийн дундаж $4.62 \times 10^{12}/\text{л}$ байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p = 0.000$).

Хүснэгт 3. Цусны улаан эсийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, $10^{12}/\text{л}$	95% ИМ		p утга
				доод утга	дээд утга	
Цусны улаан эс	Эрэгтэй	170	5.43	5.36	5.50	0.000
	Эмэгтэй	170	4.62	4.57	4.67	
	Нийт	340	5.03	4.96	5.10	

Цусны улаан эсийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд $4.69-6.04 \times 10^{12}/л$, эмэгтэйчүүдэд $4.10-5.20 \times 10^{12}/л$ байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 4. Цусны улаан эсийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, $10^{12}/л$	
		доод хязгаар	дээд хязгаар
Цусны улаан эс	Эрэгтэй	4.69	6.04
	Эмэгтэй	4.10	5.20

Судалгаанд оролцогчдын цусны гемоглобины дундаж хэмжээ ба лавлах хэмжээг тогтоосон судалгааны дүнг (Хүснэгт 5, 6)-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эрэгтэй хүмүүсийн гемоглобины дундаж 10.0 ммоль/л байсан бол, эмэгтэйчүүдийн дундаж 8.46 ммоль/л байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p = 0.000$).

Хүснэгт 5. Гемоглобины дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, ммоль/л	95% ИМ		p утга
				доод утга	дээд утга	
Гемоглобин	Эрэгтэй	170	10.0	9.91	10.09	0.000
	Эмэгтэй	170	8.46	8.38	8.54	
	Нийт	340	9.24	9.12	9.36	

Гемоглобины лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд $9.0-10.92$ ммоль/л, эмэгтэйчүүдэд $7.56-9.20$ ммоль/л байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 6. Гемоглобины лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, ммоль/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Гемоглобин	Эрэгтэй	9.0	10.92
	Эмэгтэй	7.56	9.20

Цусны гематокритын дундаж хэмжээ болон лавлах хэмжээг тогтоосон судалгааны дүнг (Хүснэгт 7, 8)-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн гематокритын дундаж 48.31 % байсан бол, эмэгтэйчүүдийн дундаж 40.44 % байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p = 0.000$).

Хүснэгт 7. Гематокритын дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, %	95% ИМ		p утга
				доод утга	дээд утга	
Гематокрит	Эрэгтэй	170	48.31	47.83	48.79	0.000
	Эмэгтэй	170	40.44	40.02	40.86	
	Нийт	340	44.44	43.84	45.04	

Гематокритын лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 42.66-52.89%, эмэгтэйчүүдэд 36.08-44.74% байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 8. Гематокритын лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, %	
		доод хязгаар	дээд хязгаар
Гематокрит	Эрэгтэй	42.66	52.89
	Эмэгтэй	36.08	44.74

Хэлцэмж: Бидний судалгааны зорилго нь насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд оролцох гематологийн үзүүлэлтийн дундаж болон лавлах хэмжээг тодорхойлох бөгөөд энэ хүрээнд ижил аргачлалын дагуу судалгаа хийсэн олон улсын судалгааны үр дүнгүүдтэй харьцууллаа. Үүнд: Баруун өмнөд Этиоп улсын харьцангуй эрүүл хүнийг хамруулан цусны гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тодорхойлох судалгааг хийсэн байна. Лавлах хэмжээг тодорхойлохдоо “Эмнэлзүйн лабораторийн стандартын хүрээлэн”-гээс гаргасан удирдамжийг ашиглан тодорхойлжээ. Уг судалгаагаар цусан дахь улаан эс, цагаан эс, гемоглобины агууламжийн лавлах хэмжээ насан хүрсэн хүнийх $5.19 \times 10^{12}/л$ ($4.08-6.33 \times 10^{12}/л$), $6.35 \times 10^9/л$ ($3.28-11.22 \times 10^9/л$), $155 г/л$ ($120.6-187.6 г/л$ тус тус үр дүн гарсан ба хүйсийн хувьд эмэгтэйчүүдийн улаан болон цагаан эс, гемоглобин, гематокритийн агууламжийн лавлах хэмжээ $4.62 \times 10^{12}/л$ ($4.10-5.20 \times 10^{12}/л$), $5.89 \times 10^9/л$ ($3.50-9.08 \times 10^9/л$), $136.30 г/л$ ($121.80-148.20 г/л$), эрэгтэйчүүдэд $5.43 \times 10^{12}/л$ ($4.69-6.04 \times 10^{12}/л$), $6.20 \times 10^9/л$ ($3.98-9.11 \times 10^9/л$), $161.20 г/л$ ($145-176 г/л$) байгаа нь бидний судалгааны үр дүнтэй харьцуулахад дундаж болон лавлах хэмжээ ойролцоо гарсан байна. Энэ нь судалгаанд харьцангуй эрүүл насны бүлгийг сонгохдоо скрийнинг тест болох CRP үзүүлэлтийг хийх, тамхины хэрэглээ, жирэмсэн эсэх, архаг, хурц өвчтэй эсэх, эмчилгээ хийлгэж байгаа эсэх, биологийн нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэж байгаа эсэх гэх мэт шалгуурыг хангаж байгаа хүмүүсийг судалгаандаа хамруулсан бөгөөд эдгээр нь бидний судалгааны шалгууртай ижил байна.

Мөн судалгаагаар Африкийн бусад орон болон Кавказын хүн амын гематологийн үзүүлэлт статистик ач холбогдол бүхий ялгаатай байгаа бүс нутгийн хүрээнд эмнэлзүйн үзүүлэлтийн лавлах хэмжээг тодорхойлох шаардлагатай гэдгийг онцлон дүгнэжээ [107].

Баруун хойд Марокко улсын харьцангуй эрүүл хэмээн тодорхойлсон хүн амд хийсэн гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоосон судалгаагаар 18–55 насны 15840 хүнийг хамруулсан байна. Судалгааны дүнд хүйсийн ангиллын хувьд лимфоцит эсийн агууламжаас бусад гематологийн үзүүлэлт нь $p < 0.001$ буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай гарсан байна. Уг судалгааны дүнг Араб, Кавказ, Африкийн бусад орны хүн амын цусны үзүүлэлттэй харьцуулах зорилготой хийгдсэн бөгөөд судалгааны дүнгээр статистик ач холбогдол бүхий ялгаатай байгааг тогтоосон байна [108].

Ирак улсын харьцангуй эрүүл хүний цусны гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоох судалгаанд нийт 762 хүнийг хамруулжээ. Лавлах хэмжээг тодорхойлохдоо “Эмнэлзүйн лабораторийн стандартын хүрээлэн”-гээс гаргасан удирдамжийг ашиглан тодорхойлжээ. Харьцангуй эрүүл тодотголтой, бүлгээр ангилсан дор хаяж 120 хүнийг хамруулан тодорхойлох шаардлагын дагуу хасах шалгуураар сонгон судлуулагчдыг хамруулсан байна. Насны ангиллаар 3 дэд бүлэг (18-39, 40-59, 60-95) болгон гематологийн үзүүлэлтийг тодорхойлсон байна. Үр дүнд эрэгтэй хүмүүсийн хувьд гемоглобины агууламж нас ахихын хэрээр буурсан буюу ($p = 0.01$) статистик ач холбогдол бүхий ялгаатай гарсан бол эмэгтэйчүүдийн хувьд ялгаа ажиглагдаагүй байна. Судалгааны дүнд лабораторийн оношлогоонд хүйсээс хамааран лавлах хэмжээг ашиглах нь зүйтэй гэж дүгнэжээ [109].

Бидний судалгааны ажлын хүрээнд хийгдсэн гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тодорхойлсон дүнгээр монгол эрэгтэй хүний цусны улаан эсийн агууламж олон улсын лавлах хэмжээ ($4.6-6.2 \times 10^{12}/л$)- тай харьцуулахад ойролцоо буюу ($4.69- 6.04 \times 10^{12}/л$), гемоглобины хэмжээ олон улсын лавлах хэмжээ (140-180 г/л) байхад бидний судалгаагаар (145-176 г/л), гематокритын хэмжээ олон улсын лавлах хэмжээ нь (40-54%) байхад бидний судалгаагаар (42.6-52.9 %) тус тус гарсан бол цагаан эсийн агууламж олон улсын лавлах хэмжээ ($3.5-12 \times 10^9/л$)-тай харьцуулахад дээд хязгаар нь бага буюу $3.98-9.11 \times 10^9/л$ байна [110].

Харин Монгол хүний цусны улаан эсийн агууламж олон улсын лавлах хэмжээ ($4.2-5.4 \times 10^{12}/л$)-тэй харьцуулахад ойролцоо буюу ($4.1-5.2 \times 10^{12}/л$), гемоглобины хэмжээ олон улсын лавлах хэмжээ (120-160 г/л)-тай харьцуулахад (121-148 г/л) дээд хязгаар нь бага, гематокритын хэмжээ олон улсын лавлах хэмжээ (37-47%)-тай харьцуулахад бага буюу (36-44.7%), цагаан эсийн агууламж олон улсын лавлах хэмжээ ($3.5-12 \times 10^9/л$)- тай харьцуулахад дээд хязгаар нь бага буюу ($3.5-9.08 \times 10^9/л$) байна [110]. Олон улсад мөрдөгдөж буй цагаан эсийн лавлах хэмжээ нь хүйс заагаагүй эсвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан лавлах хэмжээний утгатай байдаг ба бидний хийсэн судалгааны үр дүн ($p = 0.0964$ статистик ач холбогдол сул) мөн адил хүйсийн хамаарал бага гарсан. Энэ чиглэлийн судалгааг цаашид өргөжүүлэн хийх шаардлагатай бөгөөд бусад улс орны хувьд ч мөн өөрийн бүс нутгийн хэмжээнд мөрдөх гематологийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоох судалгаануудын дүнд ерөнхий үзүүлэлтийн олон улсын стандарт утгатай харьцуулахад тухайн бүс нутгийн иргэдийг хамарсан лавлах хэмжээг ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан байна [111, 112].

6.2 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь зарим элемент (цайр, зэс, төмөр)-үүдийн дундаж болон лавлах хэмжээ

Судалгааны шаардлага хангасан оролцогчдын цусны цайрын дундаж хэмжээ 11.40 (ИМ 95%; 11.05-11.76) мкмоль/л байна (Хүснэгт 9), Үүнээс эрэгтэйчүүдэд 11.0 (ИМ 95%; 10.69-11.31) мкмоль/л эмэгтэйчүүдэд 11.79 (ИМ 95%; 11.39-12.19) мкмоль/л байгаа нь цайрын дундаж хэмжээ нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.002$).

Хүснэгт 9. Цусны цайрын дундаж хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, мкмоль/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Цайр	Эрэгтэй	170	11.00	10.69	11.31	0.002
	Эмэгтэй	170	11.79	11.39	12.19	
	Нийт	340	11.40	11.05	11.76	

Хүснэгт 10-т цайрын лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 8.20-14.92 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 8.52-16.67 мкмоль/л байгаа нь эмэгтэйчүүдийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдийхээс бага зэрэг өндөр байгаа боловч уг ялгаа статистик ач холбогдолгүй байв.

Хүснэгт 10. Цусны цайрын лавлах хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, мкмоль/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Цайр	Эрэгтэй	8.20	14.92
	Эмэгтэй	8.52	16.67

Судалгаанд оролцогчдын цусны зэсийн дундаж хэмжээ 16.68 (ИМ 95%; 15.99-17.38) мкмоль/л байна (Хүснэгт 11), Үүнээс эрэгтэйчүүдэд 15.28 (ИМ 95%; 14.64-15.89) мкмоль/л эмэгтэйчүүдэд 18.08 (CI 95%; 17.30-18.86) мкмоль/л байгаа нь зэсийн дундаж хэмжээ нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байв ($p=0.0001$).

Хүснэгт 11. Цусны зэсийн дундаж хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, мкмоль/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Зэс	Эрэгтэй	170	15.28	14.64	15.89	0.00
	Эмэгтэй	170	18.08	17.30	18.86	
	Нийт	340	16.68	15.99	17.38	

Цусан дахь зэсийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 9.72-22.34 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 11.18-27.27 мкмоль/л байгаа нь хүйсийн хувьд статистик ач холбогдолгүй байв (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Цусан дахь зэсийн лавлах хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, мкмоль/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Зэс	Эрэгтэй	9.72	22.34
	Эмэгтэй	11.18	27.27

Судалгаанд оролцогчдын цусны төмрийн дундаж хэмжээ 30.71 (ИМ 95%; 29.88-31.55) мкмоль/л байна (Хүснэгт 13), Үүнээс эрэгтэйчүүдэд 30.50 (ИМ 95%; 29.71-31.29) мкмоль/л эмэгтэйчүүдэд 30.91 (ИМ 95%; 30.03-31.79) мкмоль/л байгаа нь төмрийн дундаж хэмжээ хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй ($p = 0.49$)

Хүснэгт 13. Цусны төмрийн дундаж хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, мкмоль/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Төмөр	Эрэгтэй	170	30.50	29.71	31.29	0.49
	Эмэгтэй	170	30.91	30.03	31.79	
	Нийт	340	30.71	29.88	31.55	

Цусны төмрийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 21.39-37.72 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 19.87-39.67 мкмоль/л байгаа нь хувьд хүйс хоорондын статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Цусны төмрийн лавлах хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, мкмоль/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Төмөр	Эрэгтэй	21.39	37.72
	Эмэгтэй	19.87	39.67

Хэлцэмж: Монгол хүний цусны зэс, цайр болон төмрийн лавлах хэмжээ тодорхойлсон судалгаа хийгдээгүй боловч зарим эмгэгийн үеийн эрдэсийн түвшинг судалсан цөөн тооны судалгаа хийгдсэн байна.

Б.Батболд нар [119] элэгний эмгэгтэй 50 өвчтөний цусны төмрийн хэмжээг биохимийн автомат анализатор дээр колориметрийн аргаар тодорхойлоход 189.84 мг/дл (34.00 ммоль/л) гарсан нь бидний тодорхойлсон дундаж хэмжээнээс даруй 1000 дахин их байсан ба харин уг үзүүлэлтийг ммоль/л-ээр бус мкмоль/л-ээр илэрхийлбэл тодорхойлсон дундаж хэмжээнүүдийн хооронд бараг ялгаагүй болох

юм. Олон улсын эрүүл мэндийн мэргэжлийн мэдээллийн хэрэгслүүдэд [120-122] заасан цусны төмрийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдийн хувьд 14-34 мкмоль/л, эмэгтэйчүүдийн хувьд 10-31 мкмоль/л байгаа нь бидний судалгаагаар тогтоосон лавлах хэмжээнээс бага байгаа боловч уг зөрүү ач холбогдол бүхий бус юм.

Манай оронд цусны цайрын түвшний судалгаа 6-36 сартай хүүхдүүдийн дунд хийгдсэн байдаг [113] ба уг судалгаагаар тогтоосон цайрын дундаж хэмжээ 8.9 мкмоль/л байсан нь бидний судалгааны дүнгээс бага зэрэг доогуур байна. Гэвч бага насны хүүхдийн цусны цайрын хэмжээ насанд хүрсэн хүнээс бага зэрэг доогуур байдгийг гадаадын судлаачид тогтоосон байдаг [1114, 115]. Манай судалгаагаар тодорхойлсон насанд хүрсэн хүний цусны цайрын дундаж хэмжээ болон лавлах хэмжээ гадаадын судлаачдын тогтоосон дүнтэй (дундаж хэмжээ 10.78 мкмоль/л ба лавлах хэмжээ 9-19 мкмоль/л [115]) ойролцоо байна.

Монгол малын цусанд зэсийн хэмжээ тогтоосон судалгаа байдаг боловч хүний цусанд уг минералын түвшинг тодорхойлсон судалгаа байхгүй байна. Харин гадаад орны сурах бичгүүдэд заасан цусны зэсийн дундаж хэмжээ 15.74 мкмоль/л [117] ба лавлах хэмжээ 10-22 мкмоль/л [118]-тэй бидний тогтоосон дүн тохирч байна. Герман улсын насанд хүрсэн хүмүүсийн ийлдсийн лавламж хэмжээ тогтоосон дүнгээс харахад (дундаж ± 2 SD) зэсийн хувьд 16.5 ± 8.6 мкмоль/л, цайрын хувьд 16.6 ± 6.2 мкмоль/л [123] байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харахад зэсийн хэмжээ бидний судалгаатай тохирч байна. Харин цайрын дундаж хэмжээ бага зэргийн ялгаа ажиглагдсан.

Энэтхэг, Пакистанд хийсэн 83 хүний цусан дах цайр 0.71 ± 0.11 , зэс 0.9 ± 0.10 , төмөр 0.80 ± 0.12 мг/л дундажтай байна. Судалгааны дүнгээс судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 50 орчим хувь төмөр болон цайрын түвшин бага, эдгээр элементүүдийн цусан дах түвшин нь эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс бага байгаа нь судалгаагаар тогтоогдсон [124]. Бидний судалгаанаас харахад эмэгтэйчүүдийн эрдсийн хэмжээ нь эрэгтэйчүүдээс өндөр байсан.

6.3 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь уургийн бодисуудын дундаж болон лавлах хэмжээ

Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын ийлдсийн нийт уургийн дундажийг (Хүснэгт 15)-т, лавлах хэмжээг (Хүснэгт 16)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад судлуулагчдын цусны ийлдсийн нийт уургийн дундаж хэмжээ 74.06 (ИМ 95%; 72.96-75.16) г/л байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 74.54 (ИМ 95%; 72.67-76.41) г/л, эмэгтэйчүүдэд 73.59 (ИМ 95%; 72.39-74.79) г/л байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна ($p > 0.40$).

Хүснэгт 15. Цусны ийлдсийн нийт уургийн дундаж, г/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, г/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Нийт уураг	Эрэгтэй	170	74.54	72.67	76.41	0.40
	Эмэгтэй	170	73.59	72.39	74.79	
	Нийт	340	74.06	72.96	75.16	

Нийт уургийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 55.26-95.79 г/л, эмэгтэйчүүдэд 58.38-84.72 г/л байна.

Хүснэгт 16. Цусны ийлдсийн нийт уургийн лавлах хэмжээ, г/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, г/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Нийт уураг	Эрэгтэй	55.26	95.79
	Эмэгтэй	58.38	84.72

Судлуулагчдын цусны ийлдсийн альбумины дундаж хэмжээг (Хүснэгт 17)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад альбумины дундаж хэмжээ 47.23 (ИМ 95%; 46.47-47.99) г/л байна. Үүнээс эрэгтэйчүүдэд 48.20 (ИМ 95%; 47.04-49.36) г/л, эмэгтэйчүүдэд 46.28 (ИМ 95%; 45.32-47.24) г/л байгаа нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.012$).

Хүснэгт 17. Цусны ийлдсийн альбумины дундаж хэмжээ, г/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, г/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Альбумин	Эрэгтэй	170	48.20	47.04	49.36	0.012
	Эмэгтэй	170	46.28	45.32	47.24	
	Нийт	340	47.23	46.47	47.99	

Цусны ийлдсийн альбумины лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 37.14-60.01 г/л, эмэгтэйчүүдэд 34.97-57.60 г/л байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Цусны ийлдсийн альбумины лавлах хэмжээ, г/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, г/л	
		Доод хязгаар	Дээд хязгаар
Альбумин	Эрэгтэй	37.14	60.01
	Эмэгтэй	34.97	57.60

Судлуулагчдын цусны ийлдсийн преальбумины дундажийг (Хүснэгт 19)-т үзүүлэв. Хүснэгтээс харахад преальбумины дундаж хэмжээ 358.80 (ИМ 95%; 343.61-373.96) г/л байна. Үүнээс эрэгтэйчүүдэд 332.43 (ИМ 95%; 311.28-353.58) мг/л, эмэгтэйчүүдэд 381.67 (ИМ 95%; 360.98-402.36) мг/л байгаа нь ийлдсийн преальбумины дундаж хэмжээ эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.0012$).

Хүснэгт 19. Цусны ийлдсийн преальбумины дундаж хэмжээ, мг/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, мг/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Преальбумин	Эрэгтэй	170	332.43	311.28	353.58	0.0012
	Эмэгтэй	170	381.67	360.98	402.36	
	Нийт	340	358.80	343.61	373.96	

Цусны ийлдсийн преальбумины лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 171.3-485.0 мг/л, эмэгтэйчүүдэд 215.5-535.0 мг/л байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Цусны ийлдсийн преальбумины лавлах хэмжээ, мг/л

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, мг/л	
		доод хязгаар	дээд хязгаар
Преальбумин	Эрэгтэй	171.3	485.0
	Эмэгтэй	215.5	535.5

Судлуулагчдын цусны ийлдсийн трансферрины дундажийг (Хүснэгт 21)-д үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад цусны ийлдсийн трансферрины дундаж хэмжээ 4.24 (ИМ 95%; 4.07-4.41) г/л байна. Үүнээс эрэгтэйчүүдэд 4.01 (ИМ 95%; 3.76-4.26) г/л, эмэгтэйчүүдэд 4.43 (ИМ 95%; 4.20-4.66) г/л байгаа нь ийлдсийн трансферрины дундаж хэмжээ нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.017$).

Хүснэгт 21. Цусны ийлдсийн трансферрины дундаж хэмжээ, г/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, г/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Трансферрин	Эрэгтэй	170	4.01	3.76	4.26	0.017
	Эмэгтэй	170	4.43	4.20	4.66	
	Нийт	340	4.24	4.07	4.41	

Трансферрины лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 2.20-6.92 г/л, эмэгтэйчүүдэд 2.44-7.05 г/л байгаа нь хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн лавлах хэмжээнээс эмэгтэйчүүдийн лавлах хэмжээ нь бага зэрэг өндөр байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Цусны ийлдсийн трансферрины дундаж, лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Дундаж, г/л	Лавлах хэмжээ, г/л	
			доод хязгаар	дээд хязгаар
Трансферрин	Эрэгтэй	4.01	2.20	6.92
	Эмэгтэй	4.43	2.44	7.05

Судлуулагчдын цусны ийлдсийн ретинол холбогч уургийн дундажийг 1.87 (ИМ 95%; 1.78-1.96) мкмоль/л байна (Хүснэгт 23). Үүнээс эрэгтэйчүүдэд 1.73 (ИМ 95%; 1.61-1.85) мкмоль/л, эмэгтэйчүүдэд 2.01 (ИМ 95%; 1.89-2.13) мкмоль/л байгаа нь ретинол холбогч уургийн дундаж хэмжээ нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.0017$).

Хүснэгт 23. Цусны ийлдсийн ретинол холбогч уургийн дундаж хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн хэмжээ	Дундаж, мкмоль/л	Итгэлцлийн муж		P утга
				доод утга 2.5%	дээд утга 97.5%	
Ретинол холбогч уураг	Эрэгтэй	170	1.73	1.61	1.85	0.0017
	Эмэгтэй	170	2.01	1.89	2.13	
	Нийт	340	1.87	1.78	1.96	

Цусны ийлдсийн ретинол холбогч уургийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 0.73-3.08 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 0.74-3.49 мкмоль/л (Хүснэгт 24) байна.

Хүснэгт 24. Цусны ийлдсийн ретинол холбогч уургийн лавлах хэмжээ, мкмоль/л

Үзүүлэлт	Хүйс	Дундаж, мкмоль/л	Лавлах хэмжээ, мкмоль/л	
			доод хязгаар	дээд хязгаар
Ретинол холбогч уураг	Эрэгтэй	1.73	0.73	3.08
	Эмэгтэй	2.01	0.74	3.49

Хэлцэмж: Өвчтөний эмчилгээний чиглэлийг тодорхойлохын тулд хоол тэжээлийн байдлыг үнэлэх нь чухал ач холбогдолтой байдаг. Насанд хүрсэн хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэхэд ашигладаг уургуудын дундаж болон лавлах хэмжээг тодорхойлж, ижил аргачлалын дагуу судалгаа хийсэн олон улсын судалгааны үр дүнгүүдтэй харьцууллаа. Гемодиализын шалтгаант нас баралтад хоол тэжээлийн дутагдал хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохоор Макао дахь “Бөөр судлалын хүрээлэн”-гийн эрдэмтэд судалгаа хийсэн байна. Судалгаанд оролцогчдын биеийн жингийн индексийг тооцох, ийлдэсний альбумин, креатинин, гемоглобины зэрэг клиник үзүүлэлтийг тодорхойлсон байсан. Лабораторийн шинжилгээг COBAS 6000 ашиглан хийсэн бөгөөд статистик боловсруулалтыг SPSS 22.0 программ дээр боловсруулсан. Судалгаанд оролцсон 204 эрэгтэй хүмүүсийн дундаж альбумины хэмжээ 539.6 ± 51.8 , 156 эмэгтэй хүмүүсийн хувьд 524.1 ± 51.6 байгаа нь статистик ач холбогдолгүй байна. Судалгааны үр дүнгээс харахад гемодиализд ордог өвчтнүүдэд хоол тэжээлийн дутагдал зонхилж байгаа бөгөөд судалгаанд ашигласан үзүүлэлт нь анхдагч байдлаар үнэлгээ өгөх боломжтой гэж дүгнэсэн байна [125].

Насанд хүрсэн эрүүл хүний ийлдсийн нийт уургийн лавлах хэмжээ В.К.Кухта ба бусад 1986, В.В. Меньшинков 1987, Капитанеко 1988, нарын судалгаагаар 65-85 г/л байсан. Мөн АНУ болон Англи зэрэг орны судлаачид Robert. E (1985), Peter J.J (1987), Kaplan.O (1985), Henry J (1982) нар эрүүл хүний ийлдсийн нийт уураг 62-82 г/л гэж тогтоосон нь бидний судалгаагаар эрэгтэйчүүдэд 55.26-95.79 г/л,

эмэгтэйчүүдэд 58.38-84.72 г/л байгаа нь олон улсын судлаачдын үр дүнтэй ойролцоо гарсан байна.

Намиб улсын эрдэмтэд нийт уургийн лавлах хэмжээг тодорхойлох судалгааг хүйс, нас, газарзүйн мужийн ангиллаар ангилж хийсэн байна. Нийт 78,477 эрүүл бүлгийг сонгон авсан. Нийт уургийг тодорхойлохдоо Биуретийн аргаар, молекул шингээлтийн спектрофотометрийг ашиглан дээжний шингээлтийг хэмжиж, г/л нэгжид шилжүүлэн тооцоолсон байна. Лавлах хэмжээг тархалтын 2.5 болон 97.5 персентиль байхаар тооцож, статистик боловсруулалтыг SPSS 25, Graph Pad prism ашиглан боловсруулжээ. Судалгааны дүнгээр нийт уургийн лавлах хэмжээ 51-91 г/л гарсан бидний судалгааны үр дүн (эрэгтэйчүүдэд 55.26-95.79 г/л, эмэгтэйчүүдэд 58.38-84.72 г/л)-тэй харьцуулахад статистик бүхий ач холбогдол бүхий ялгаагүй гарсан байна [126-129].

Альбумины лавлах хэмжээ насанд хүрсэн хүмүүсийн хувьд 35-55 г/л байгааг судлаачид тогтоосон байна. Цюрихийн их сургуулийн Spichigen нарын судалгаагаар альбумин лавлах хэмжээ 35-50 г/л, C.W.Denko.P, Gabriel нарын судлагаагаар 21-93 насны эрэгтэйчүүдэд 27.8-61.2 г/л, 20-81 насны эмэгтэйчүүдэд 24.6-54.4 г/л гэж тогтоосон бол бидний судалгааны үр дүн (эрэгтэйчүүдэд 37.14-60.01 г/л, эмэгтэйчүүдэд 34.97-57.60 г/л)-тэй харьцуулахад дүйж байна.

Ийлдсийн преальбумин эрүүл хүнд 0.1-0.4 г/л хэмжээтэй агуулагдах бөгөөд хэлбэлзэл бага, харьцангуй тогтвортой байдаг. Katherine Chen нарын хамтран хийсэн судалгаагаар насанд хүрсэн эрүүл хүний ийлдсийн альбумин 35-52 г/л, преальбумин 0.17-0.42 г/л, трансферрин 2.16-3.99 г/л, РХУ 0.04-0.06 г/л гэж тогтоосон байна [65]. Судалгаагаар насанд хүрсэн хүмүүсийн преальбумины лавлах хэмжээ нь 0.2-0.4 г/л байна [66]. Burtis CA ба бусад (2012), Ledue TB, Collins MF (2011) нарын судалгаагаар ретинол холбогч уургийн лавлах хэмжээ 0.03-0.06 г/л байна [67] гэж тус тус тогтоосон байна. Насанд хүрсэн монгол хүний ийлдсийн уургууд болох преальбумины лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 171.3-485 мг/л (0.17-0.48 г/л), эмэгтэйчүүдэд 215.5-535 мг/л (0.21-0.53г/л), трансферрин эрэгтэйчүүдэд 2.2-6.92 г/л, эмэгтэйчүүдэд 2.44-7.05 г/л, ретинол холбогч уураг эрэгтэйчүүдэд 0.73-3.08 мкмоль/л (0.015-0.065 г/л), эмэгтэйчүүдэд 0.74-3.47 мкмоль/л (0.015-0.073 г/л) гарч байгаа нь гадны судлаачдын лавлах хэмжээнүүдтэй харьцуулахад преальбумин эмэгтэйчүүдэд бага зэрэг өндөр, РХУ, трансферрин уургуудын лавлах дээд хэмжээ нь өндөр гарсан байна. Энэ манай орны уур амьсгал, хүн амын хоолны хэрэглээтэй холбоотой байх гэж үзэж байна.

Цаашид монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх уургуудын дундаж болон лавлах хязгаарыг бүс нутаг газарзүйн онцлогоос нь шалтгаалан бүсчлэн тогтоох, өмнө тогтоож байсан лавлах хэмжээг шинэчлэх шаардлагатай байна.

6.4 Хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх цусан дахь аминдэм (С, В₁₂, В₉, В₆)-үүдийн дундаж болон лавлах хэмжээ

Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын цусны ийлдсийн С аминдэмийн дундаж хэмжээг (Хүснэгт 25)-т, лавлах хэмжээг (Хүснэгт 26)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад С аминдэмийн дундаж хэмжээ 10.76 (ИМ 95%; 9.72-11.8) мг/л байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 11.88 (ИМ 95%; 10.47-13.29) мг/л, эмэгтэйчүүдэд

9.62 (ИМ 95%; 8.11-11.13) мг/л байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.0074$).

Хүснэгт 25. Цусны ийлдсийн С аминдэмийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, мг/л	95% ИМ		р утга
				доод утга	дээд утга	
С аминдэм	Эрэгтэй	170	11.88	10.47	13.29	0.0074
	Эмэгтэй	170	9.62	8.11	11.13	
	Нийт	340	10.76	9.72	11.8	

Цусны ийлдсийн С аминдэмийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 1.40-19.40 мг/л, эмэгтэйчүүдэд 1.17-18.04 мг/л байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 26. Цусны ийлдсийн С аминдэмийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, %	
		доод хязгаар	дээд хязгаар
С аминдэм	Эрэгтэй	1.40	19.40
	Эмэгтэй	1.17	18.04

Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын цусны ийлдсийн В₁₂ аминдэмийн дундажийг (Хүснэгт 27)-т, лавлах хэмжээг (Хүснэгт 28)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад судлуулагчдын ийлдсийн В₁₂ аминдэмийн дундаж хэмжээ 904.62 (ИМ 95%;753.30-1055.95) нг/л байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 938.45 (ИМ 95%; 747.22-1129.68) нг/л, эмэгтэйчүүдэд 864.03 (ИМ 95%; 603.81-1124.25) нг/л байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна ($p>0.76$).

Хүснэгт 27. Цусны ийлдсийн В₁₂ аминдэмийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, нг/л	95% ИМ		р утга
				доод утга	дээд утга	
В ₁₂ аминдэм	Эрэгтэй	170	938.45	747.22	1129.68	0.7592
	Эмэгтэй	170	864.3	603.81	1124.25	
	Нийт	340	904.62	753.30	1055.94	

Цусны ийлдсийн В₁₂ аминдэмийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 233-1597 нг/л, эмэгтэйчүүдэд 132.45-1623.86 нг/л байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна.

Хүснэгт 28. Цусны ийлдсийн В₁₂ аминдэмийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, %	
		доод хязгаар	дээд хязгаар
В ₁₂ аминдэм	Эрэгтэй	233	1597
	Эмэгтэй	132.45	1623.86

Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын цусны ийлдсийн В₉ аминдэмийн дундажийг (Хүснэгт 29)-т, лавлах хэмжээг (Хүснэгт 30)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад В₉ аминдэмийн дундаж хэмжээ 7.56 (ИМ 95%; 5.92-9.20) нг/мл байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 8.47 (ИМ 95%; 5.64-11.30) нг/мл, эмэгтэйчүүдэд 6.91 (ИМ 95%; 4.89-8.93) нг/мл байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p > 0.000$).

Хүснэгт 29. Цусны ийлдсийн В₉ аминдэмийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, нг/мл	95% ИМ		p утга
				доод утга	дээд утга	
В ₉ аминдэм	Эрэгтэй	170	8.47	5.64	11.30	0.0002
	Эмэгтэй	170	6.91	4.89	8.93	
	Нийт	340	7.56	5.92	9.20	

Цусны ийлдсийн В₉ аминдэмийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 1.04-24.74 нг/мл, эмэгтэйчүүдэд 1.04-21.46 нг/мл байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 30. Цусны ийлдсийн В₉ аминдэмийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, %	
		доод хязгаар	дээд хязгаар
В ₉ аминдэм	Эрэгтэй	1.04	24.74
	Эмэгтэй	1.04	21.46

Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын цусны ийлдсийн В₆ аминдэмийн дундажийг (Хүснэгт 31)-т, лавлах хэмжээг (Хүснэгт 32)-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад В₆ аминдэмийн дундаж хэмжээ 39.22 (ИМ 95%; 34.91-43.53) нг/мл байсан ба үүнээс эрэгтэйчүүдэд 44.42 (ИМ 95%; 37.01-51.83) нг/мл, эмэгтэйчүүдэд 34.67 (ИМ 95%; 29.97-39.39) нг/мл байгаа нь уг үзүүлэлтийн хувьд хүйсийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна ($p > 0.24$).

Хүснэгт 31. Цусны ийлдсийн В₆ аминдэмийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Түүврийн тоо	Дундаж, нг/мл	95% ИМ		р утга
				доод утга	дээд утга	
В ₆ аминдэм	Эрэгтэй	170	44.42	37.01	51.83	0.2411
	Эмэгтэй	170	34.67	29.97	39.39	
	Нийт	340	39.22	34.91	43.53	

Цусны ийлдсийн В₆ аминдэмийн лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 5.90-79.02 нг/мл, эмэгтэйчүүдэд 5.27-61.72 нг/мл байгаа нь мөн статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна.

Хүснэгт 32. Цусны ийлдсийн В₆ аминдэмийн лавлах хэмжээ

Үзүүлэлт	Хүйс	Лавлах хэмжээ, %	
		доод хязгаар	дээд хязгаар
В ₆ аминдэм	Эрэгтэй	5.90	79.02
	Эмэгтэй	5.27	61.72

Хэлцэмж: Сүүлийн жилүүдэд манай улсад усанд уусдаг аминдэмүүд болох В₆, В₉, В₁₂ болон С аминдэмүүдийг хүний цусанд тодорхойлсон судалгааны дүн тун ховор байдаг ба тэдгээрийн лавлах хэмжээг тогтоосон ажил огт хийгдээгүй байна.

Манай оронд хийсэн Р.Ландер нарын 6-36 сартай хүүхдүүдийн цусанд В₉ аминдэмийн хэмжээг тодорхойлоход 8.94 нг/мл байсан [130] нь бидний тогтоосон дундаж хэмжээнээс бага зэрэг өндөр байгаа боловч хүүхдийн цусны В₉ аминдэмийн хэмжээ насанд хүрсэн хүнээс ялимгүй өндөр байдгийг гадаадын судлаачид тогтоосон байдаг [131].

Гадаад орны судлаачдын хийж гүйцэтгэсэн судалгааны дүнтэй бидний тодорхойлсон дүнг харьцуулахад, жишээлбэл Испанийн судлаачдын [132] тогтоосон 18-65 насныхны В₉ аминдэмийн лавлах хязгаар 2.2-18 нг/мл, мөн Угандын насанд хүрэгчдийн В₉ аминдэмийн лавлах хязгаар 4.17-20 нг/мл [133] байсан нь бидний тодорхойлсон лавлах хэмжээтэй аль аль нь тохирч байна.

Дээрх хоёр судалгаагаар мөн В₁₂ аминдэмийн түвшинг тодорхойлоход Испанийн насанд хүрэгчдийн лавлах хязгаар 213.8-763.3 нг/л байсан [10] бол Угандын судлаачдын тогтоосон лавлах хэмжээ 117-1158 нг/л байсан нь [133] бидний тооцоолон гаргасан лавлах хэмжээтэй ойролцоо байлаа.

Насанд хүрэгчдийн цусанд В₆ аминдэмийн лавлах хэмжээ тогтоосон Норвегийн судалгааны дүн (5.68-55.11 нг/мл) [134], мөн Америкийн судлаачдын тодорхойлсон уг үзүүлэлт (4.91-49.51 нг/мл) [135]-ээс бидний судалгааны дүн их зөрүүгүй байна.

Германы судлаачид 300 насанд хүрэгчдийн цусанд С аминдэмийн лавлах хязгаар тодорхойлоход 5–15 мг/л гарсан [136] ба мөн Америкийн судлаачдын тогтоосон С аминдэмийн дундаж хэмжээ 9.05 мг/л [137] байсан нь тус судалгаагаар тооцоолон гаргасан дүнтэй дүйцэж байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Монгол хүний хоол тэжээлийн байдлыг үнэлэх биомаркерийн багц үзүүлэлтүүдийн дундаж болон лавлах хэмжээг тогтоох судалгааг хийж дараах үр дүнгүүд гарсан. Үүнд:

1. Цусны эсүүд болон гемоглобины лавлах хэмжээг тогтооход цусны цагаан эс эрэгтэйчүүдэд $3.98-9.11 \times 10^9/\text{л}$, эмэгтэйчүүдэд $3.50-9.08 \times 10^9/\text{л}$; цусны улаан эс эрэгтэйчүүдэд $4.69-6.04 \times 10^{12}/\text{л}$, эмэгтэйчүүдэд $4.10-5.20 \times 10^{12}/\text{л}$; гемоглобин эрэгтэйчүүдэд 145-176 г/л, эмэгтэйчүүдэд 121.80-148.20 г/л; гематокритын лавлах хэмжээ нь эрэгтэйчүүдэд 42.6-52.89 %, эмэгтэйчүүдэд 36.08-44.74 % байв. Бидний хийж гүйцэтгэсэн судалгааны дүнгүүд олон улсын судлаачдын үр дүнтэй тохирч байна.
2. Цусан дахь минералуудын дундаж хэмжээг тогтооход төмөр 30.71 мкмоль/л, зэс 16.68 мкмоль/л, цайр 11.40 мкмоль/л, лавлах хэмжээг тогтооход зэс эрэгтэйчүүдэд 9.72-22.34 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 11.18-27.27 мкмоль/л; цусан дахь төмрийн лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 21.39-37.72 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 19.87-39.67 мкмоль/л; цайрын лавлах хэмжээ эрэгтэйчүүдэд 8.20-14.92 мкмоль/л, эмэгтэйчүүдэд 8.52-16.67 мкмоль/л байсан ба уг үзүүлэлтүүд гадаад орны судлаачдын тогтоосон лавлах хэмжээтэй ойролцоо байна.
3. Цусан дахь уургийн бодисуудын дундаж болон лавлах хэмжээ (ЛХ)-г тогтооход нийт уураг эрэгтэйчүүдэд 74.54 г/л (ЛХ:55.26-95.79 г/л), эмэгтэйчүүдэд 73.59 г/л (ЛХ:58.38-84.72 г/л); альбумин эрэгтэйчүүдэд 48.20 г/л (ЛХ:37.14-60.01г/л), эмэгтэйчүүдэд 46.28 г/л (ЛХ: 34.97-57.60г/л); преальбумин эрэгтэйчүүдэд 332.43 мг/л (ЛХ:171.3-485.0 мг/л), эмэгтэйчүүдэд 381.67 мг/л (ЛХ:215.5-535.0 мг/л); трансферрин эрэгтэйчүүдэд 4.01 г/л (ЛХ:2.20-6.92 г/л), эмэгтэйчүүдэд 4.43 г/л (ЛХ:2.58-7.05 г/л); ретинол холбогч уураг эрэгтэйчүүдэд 1.73 мкмоль/л (ЛХ:0.73-3.08 мкмоль/л), эмэгтэйчүүдэд 2.01 мкмоль/л (ЛХ:1.16-3.49 мкмоль/л) байв. Цусны ийлдсийн уургийн бодисуудаас нийт уургаас бусад нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. Олон улсын судлаачдын тогтоосон лавлах хэмжээтэй харьцуулахад РХУ болон трансферринээс бусад уургуудын лавлах хэмжээ ойролцоо байсан ба харин РХУ, трансферрин уургуудын лавлах дээд хэмжээ нь өндөр гарсан байна.
4. Цусан дахь аминдэмүүдийн дундажийн тогтооход С аминдэм 10.76 мг/л, В₁₂ аминдэм 904.62 нг/л, В₉ аминдэм 7.56 нг/мл, В₆ аминдэм 39.22 нг/мл байв. Цусан дахь аминдэмүүдийн лавлах хэмжээ нь С аминдэм эрэгтэйчүүдэд 1.4-19.4 мг/л, эмэгтэйчүүдэд 1.17-18.04 мг/л, В₁₂ аминдэм эрэгтэйчүүдэд 233-1597 нг/мл, эмэгтэйчүүдэд 132.45-1623.86 нг/л, В₉ аминдэм эрэгтэйчүүдэд 1.04-24.74 нг/мл, эмэгтэйчүүдэд 1.04-21.46 нг/мл, В₆ аминдэм эрэгтэйчүүдэд 5.9-79.02 нг/мл, эмэгтэйчүүдэд 5.27-61.72 нг/мл байв. Бидний тооцоолон гаргасан аминдэмүүдийн дундаж болон лавлах хэмжээ нь олон улсын судлаачдын тогтоосон дундаж хэмжээ болон лавлах хязгаартай дүйж байна.
5. Энэхүү судалгааны дүнд тогтоосон монгол насанд хүрэгчдийн цусны уургийн бодисууд, минералууд, аминдэмүүд болон эсүүдийн лавлах хэмжээг өвчтөний хоол тэжээлийн байдлыг үнэлж, эмнэлзүйн шийдвэр гаргахад ашиглах боломжтой юм.

НАЙМ. АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Butterworth CE. The skeleton in the hospital closet. *Nutr Today* 1974;9:4-8.
2. Banh L. Serum proteins as markers of nutrition: what are we treating?. *Pract Gastroenterol* 2006;30:46-64.
3. Fuhrman MP, Charney P, and Mueller CM. Hepatic proteins and nutrition assessment. *J Am Diet Assoc* 2004;104:1258-64.
4. Rosalind.S Gibson Principles of Nutritional assessment. Second edition.
5. <https://en.wikipedia.org/wiki/Nutrition>
6. <https://www.drderryberry.com/what-is-the-history-of-clinical-nutrition/>
7. <https://www.health.nutritionalconference.com/events-list/clinical-nutrition>
8. Jarrah, Abughaith. (2017) The physiology of nutrition in haematology *IJAR* 5 (11): 1424-1434
9. Elliott, S. (2008) Erythropoiesis-stimulating agents and other methods to enhance oxygen transport *British Journal of Pharmacology* 154: 529-541.
10. Gan, B. Hu, J. Jiang, S. Liu, Y. Sahin, E. Zhuang, L. DePinho, R.A(2010) *Nature* 468 (7324): 701-704.
11. Tortora, G. & Derrick, B (2008) Principles of anatomy and physiology. New Jersey, NJ: John Wiley & Sons, Inc.
12. Angeli, Ambayya. Anselm, Ting Su. Nadila, Haryani Osman. (2014) Haematological Reference Intervals in a Multiethnic Population *PLoS ONE* Retrieved from www.plosone.org
13. Malone, A and Hamilton, C. (2013) The Academy of Nutrition and Dietetics/The American Society for Parental and Enteral Nutrition consensus malnutrition characteristics: application in practice. *Nutr Clin Pract*; 28: 639–50.
14. Delliere, S. Cynober L. (2017) Is transthyretin a good marker of nutritional status. *Clinical Nutrition* (36): 364-370
15. Hemoglobin. Retrieved from <https://en.wikipedia.org/wiki/>
16. Kuwabara, T. Mori, K. Mukoyama, M. Kasahara, M. Yokoi, H. Saito, Y. Yoshioka, Ogawa, Y. Imamaki, H. Kusakabe, T. (2009) Urinary neutrophil gelatinase-associated lipocalin levels reflect damage to glomeruli, proximal tubules, and distal nephrons. *Kidney Int.* 75, 285–294
17. Red blood cell structure. Retrieved from <https://en.wikipedia.org/wiki/>
18. http://www.drkaslow.com/html/blood_cell_counts.html
19. Melissa Wright, Clifford W Lo. Laboratory Assessment of Nutritional status. *Nutrition in Pediatrics* 4: Basic Science, Clinical Applications. 15, 21-22, (2008)
20. Li, L. Dai, L. Wang, X. Wang, Y. Zhou, L. Chen, M. Wang, H. (2017) Predictive value of the C-reactive protein-to-prealbumin ratio in medical ICU patients. *Biomarkers in Medicine* vol. 11, no. 4: 243-248.
21. White blood cell. Retrieved from <https://en.wikipedia.org/wiki/>
22. Gibson RS. (1990) Assessment of protein status. In: Gibson RS (ed). Principles of Nutritional Assessment. New York: Oxford University Press,307
23. Chaves, GV. Ferreira Peres, WA. Goncalves, JC and Ramalho, A. (2014) Vitamin a and retinol-binding protein deficiency among chronic liver disease patients. *Nutrition*.

24. Д. Пүрэв., Н.Цэвэгсүрэн “Биохими, 2006 он
25. “Concentrations of macro- and micro-elements in the milk of pasture-fed thoroughbred mares.” *Aust Vet J.* 1999 Mar;77(3):177-80.
26. “Variation in Macro and Trace Elements in Progression of Type 2 Diabetes” *The Scientific World Journal* Volume 2014 (2014), Article ID 461591, 9 pages
27. *J Res Med Sci.* 2014 Feb; 19(2): 164–174.Review on iron and its importance for human health
28. Methods of assessment of copper status in humans: a systematic review Linda J Harvey, Kate Ashton, Lee Hooper, Amélie Casgrain, Susan J Fairweather-Tait
29. *Rev Esp Fisiol.* 1986 Jun;42(2):213-7. Whole blood and serum copper levels in relation to sex and age.
30. *Rev Esp Fisiol.* 1985 Dec;41(4):463-70.Whole blood and serum zinc levels in relation to sex and age.
31. В.Хадхүү. Монгол хүний ийлдсийн зарим уургийн лавлах хэмжээ. Анагаах ухааны докторын зэрэг горилох диссертаци, Монгол улсын анагаах ухааны их сургууль, Улаанбаатар хот, 1994 он
32. Mears E. Nutritional assessment: The key to positive outcomes and financial impact. *Lab Med* 2007;38:43-7
33. http://aya_8830.blog.gogo.mn/read/entry380808
34. Sabatino, A.; Regolisti, G.; Karupaiah, Protein-energy wasting and nutritional supplementation in patients with end-stage renal disease on hemodialysis. *Clin. Nutr.* 2017, 36, 663–671.
35. American Dietetic Association., HIV/AIDS medical nutrition therapy protocol: medical nutrition therapy across the continuum of care, 1998 Chicago, IL
36. Mulasi U, Kuchnia AJ, Cole AJ, et al. Bioimpedance at the bedside: current applications, limitations, and opportunities. *Nutr Clin Pract* 2015;30:180–93.
37. Shishira Bharadwaj, Shaiva Ginoaya, Parul Tandon, Tushar D. Gohel, John Guirguis, Hiren Vallabh, Andrea Jevonn, Ibrahim Hanouneh, *Gastroenterology Report*, 4(4), 2016, 272–280.
38. Konstantinides F. Nutritional Assessment of Hospitalized Patients, a long overlooked area of lab testing. *Clinical Laboratory News (American Association for Clinical Chemistry)* Feb 1998: <http://www.aacc.org/>
39. Ferard G., Gaudias J., Bourguignat A., Ingenbleek Y.C-reactive protein to transthyretin ratio for the early diagnosis and follow-up of postoperative infection. *Clin Chem Lab Med* 2002;40 (12): 1334-1338.
40. Spiekerman A.M. Proteins used in nutritional assessment. *Clin Lab Med* 1993;13:353-69.
41. Kudsk KA, Tolley EA, DeWitt RC, Janu PG, Blackwell AP, Yearly S., King BK Preoperative albumin and surgical site identify surgical risk for major postoperative complications. *J. Parenter. Enter. Nutr.* 2003; 27 :1–9. doi: 10.1177/014860710302700101.
42. Hernández JL, Riancho JA, Matorras P., González-Macías J. Clinical evaluation for cancer in patients with involuntary weight loss without specific symptoms. *Am. J. Med.* 2003; 114 :631–637.

43. Bernstein L.H., Ingenbleek Y. Transthyretin: Its response to malnutrition and stress injury. Clinical usefulness and economic implications. *Clin Chem Lab Med* 2002;40 (12): 1344-1348.
44. Dellièrre S., Cynober L. Is transthyretin a good marker of nutritional status? *Clin. Nutr.* 2017; 36 :364–370.
45. Li L., Dai L., Wang X., Wang Y., Zhou L., Chen M., Predictive value of the C-reactive protein-to-prealbumin ratio in medical ICU patients. *Biomark. Med.* 2017; 11 :329–337.
46. Harriman S., Rodych N., Hayes P., Moser MA The C-reactive protein-to-prealbumin ratio predicts fistula closure. *Am. J. Surg.* 2011; 202 :175–178.
47. Shen Q., Liu W., Quan H., Pan S., Li S., Zhou T., Ouyang Y., Xiao H. Prealbumin and lymphocyte-based prognostic score, a new tool for predicting long-term survival after curative resection of stage II/III gastric cancer. *Br. J. Nutr.* 2018; 120 :1359–1369.
48. Shimura T., Shibata M., Inoue T., Owada-Ozaki Y., Yamaura T., Muto S., Hasegawa T., Shio Y., Suzuki H. Prognostic impact of serum transthyretin in patients with non-small cell lung cancer. *Mol. Clin. Oncol.* 2019; 10 :597–604.
49. Wang W., Wang C.-S., Ren D., Li T., Yao H.-C., Ma S.-J. Low serum prealbumin levels on admission can independently predict in-hospital adverse cardiac events in patients with acute coronary syndrome. *Medicine.* 2018; 97:e11740.
50. Shenkin A., Cederblad G., Elia M., Isaksson B. (1996) 'Laboratory assessment of protein-energy status', *Clinica Chimica Acta*; 253:S5-S59
51. Sergi G, Coin A, Enzi G, et al. Role of visceral proteins in determining malnutrition in the elderly. *Eu J Clin Nutr* 2005; 60 :203–9.
52. Goodman DS. Plasma retinol-binding protein. *Ann N Y Acad Sci* 1980;348:378-90.
53. Chaves GV, Ferreira Peres WA, Gonçalves JC, and Ramalho A. Vitamin A and retinol-binding protein deficiency among chronic liver disease patients. *Nutrition* 2014.
54. Cano N, Di Costanzo-Dufetel J, Calaf R, Durbec JP, Lacombe P, and Pascal S et al. Prealbumin-retinol-binding-protein-retinol complex in hemodialysis patients. *Am J Clin Nutr* 1988;47:664-7.
55. Pallet N, Chauvet S, Chassat JF, Vincent M, Avillach P, and Levi C et al. Urinary retinol binding protein is a marker of the extent of interstitial kidney fibrosis. *PLoS One* 2014;9:e84708.
56. Shima H, Okano H, Tadokoro S, Hirose K, Tomuro Y, and Huruiki S et al. Evaluation of the assays of serum transferrin, retinol binding protein, and prealbumin by Behring Nephelometer Analyzer (BNA). *Jpn J Med Pharm Sci* 1994;32:145-53.
57. Ihara H, Matsumoto T, Shino Y, Hashizume N, Takase M, and Nagao J et al. Selective use of transthyretin and retinol-binding protein as markers in the postoperative assessment of protein nutritional status. *J Clin Lab Anal* 2003;17:1-5.
58. Bae SI, Yu HC, Jung MJ, Yang JD, Kim DS, and Lee MR et al. Assessment of serum retinol binding protein as a marker of nutritional status after pancreaticoduodenectomy. *Surg Metab Nutr* 2013;4:25-30.
59. Josephine N Henok¹, Benjamin I Okeleye², Elizabeth I Omodanisi², Seteno K O Ntwampe^{2,3}, Yapo G Aboua .Analysis of Reference Ranges of Total Serum Protein in Namibia: Clinical Implications. 2020 Apr 15;8(2):7.

60. Alemnji, G.A.; Mbuagbaw, J.; Folefac, E.; Teto, G.; Nkengafac, S.; Atems, N.; Kwingwah, B.B.W.; Asonganyi, T. Reference physiological ranges for serum biochemical parameters among healthy Cameroonians to support HIV vaccine and related clinical trials. *Afr. J. Health Sci.* 2010, 17, 71–82. [Google Scholar]
61. Katayev, A.; Balciza, C.; Seccombe, D.W. Establishing reference intervals for clinical laboratory test results: Is there a better way? *Am. J. Clin. Pathol.* 2010, 133, 180–186.
62. Furuq, S.; Anitha, D.; Venkatesh, T. Estimation of reference values in liver function test in health plan individuals of an urban South Indian population. *Indian J. Clin. Biochem.* 2004, 19, 72–79.
63. Ibrahim, K.; Zuberi, S.J. Serum total protein, albumin, globulin population of various ages and sex in Karachi and their ratio in apparently healthy. *J. Pak. Med. Assoc.* 1989, 39, 12–16.
64. Gahutu, J.B.; Wane, J. Reference values for serum protein and electrolyte study from Rwanda. *East Afr. Med. J.* 2006, 83, 64–67.
65. Katherine Chen et al, Albumin, transferrin, prealbumin and retinol binding protein: Markers for nutritional status in total parenteral nutrition patients, *Clin. Chem* 1991, 37/6, 985
66. Ritchie RF, Palomaki GE, Neveux LM et al (1999) Reference distributions for the negative acute-phase serum proteins, albumin, transferrin and transthyretin: a practical, simple and clinically relevant approach in a large cohort. *J Clin Lab Anal* 13:273-279
67. Ledute TB, Collins MF (2011) Development and validation of 14 human serum protein assays on the Roche cobas c 501. *J Clin Lab Anal* 25(1):52-60
68. Kim Kuling et al, Serum prealbumin levels in normal individuals of various age, and in patients with acquired immunodeficiency syndrome, *Clin Chem.* 35/6, 1989, 1115
69. “Nutritional Assessment –Vitamin Testing” Elizabeth Frank, PhD, D(ABCC), Medical Director Analytic Biochemistry, Calculi and Manual Chemistry, Mass Spectrometry ARUP Laboratories, Inc. Professor of Pathology University of Utah Department of Pathology, October 24, 2016
70. Estimation of vitamin B12 in plasma by High Performance Liquid Chromatography” Fahmida Hasnat, Habiba Akhter Bhuiyan and Mir Misbahuddin Department of Pharmacology, Bangabandhu Sheikh Mujib Medical University, Shahbag, Dhaka, Bangladesh. Correspondence to Mir Misbahuddin at mmisbah@bssmm.edu.bd, Published: 12 July, 2017
71. Watanabe F. Vitamin B12 sources and bioavailability. *Exp. Biol Med.* 2007;232:1266
72. <http://nsp.mn/29-vitamin-e-vitamin-e-.html>
73. https://en.wikipedia.org/wiki/Vitamin_B6
74. S Pirouzpanah, F-A Taleban, P Mehdipour, M Atri, A Hooshyareh-rad and S Sabour. (2013) The biomarker-based validity of a food frequency questionnaire to assess the intake status of folate, pyridoxine and cobalamin among Iranian primary breast cancer patients. *European Journal of Clinical Nutrition* (2014) 68, 316–323
75. Carmel R. How I treat cobalamin (vitamin B12) deficiency. *Blood.* 2008;112:2214–2221

76. Stabler S.P., Allen R.H. Vitamin B12 deficiency as a worldwide problem. *Annu. Rev. Nutr.* 2004;24:299–326. [PubMed]
77. Cerit L, Duygu H, Gulsen K, Kemal H, Tosun O, Ozcem B, Cerit Z, Gonsel A, *Cardiol Pol.* Vitamin B12 and SYNTAX score ratio. 2017; 75 (1): 65-70.
78. Luciana Hannann, Vegard Lysne, Anne-Lise Bjørke-Monsen, Sidney Behringer, Sarah K. Guner, Ute Spiekerkoetter, Donald W. Jacobsen, Henk J. Blom, *Diagnosis of Vitamin B Deficiency and Facial Molecules Bioski.* 2016; 3:27, doi: 10.3389 / fmolb.2016.00027
79. <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/19116332/>
80. <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/19141696/>
81. <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/12571671/>
82. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles>
83. <https://www.omet-endojournals.ru/jour/article/view/10144/0#>
84. Li Y, Schellhorn HE. New developments and novel therapeutic perspectives for vitamin C. *J Nutr* 2007;137:2171-84. [PubMed abstract]
85. Carr AC, Frei B. Toward a new recommended dietary allowance for vitamin C based on antioxidant and health effects in humans. *Am J Clin Nutr* 1999;69:1086-107.
86. Frei B, England L, Ames BN. Ascorbate is an outstanding antioxidant in human blood plasma. *Proc Natl Acad Sci U S A* 1989;86:6377-81.
87. Jacob RA, Sotoudeh G. Vitamin C function and status in chronic disease. *Nutr Clin Care* 2002;5:66-74.
88. Gershoff SN. Vitamin C (ascorbic acid): new roles, new requirements? *Nutr Rev* 1993;51:313-26.
89. Institute of Medicine. Food and Nutrition Board. *Dietary Reference Intakes for Vitamin C, Vitamin E, Selenium, and Carotenoids*. Washington, DC: National Academy Press, 2000.
90. Francescone MA, Levitt J. Scurvy masquerading as leukocytoclastic vasculitis: a case report and review of the literature. *Cutis* 2005;76:261-6.
91. King, CG, Waugh, WA. The chemical nature of vitamin C. *Science* 1932;75:357-358.
92. Bjelakovic G, Nikolova D, Simonetti RG, Gluud C. Antioxidant supplements for preventing gastrointestinal cancers. *Cochrane Database Syst Rev* 2008;(3):CD004183.
93. Coulter I, Hardy M, Shekelle P, Udani J, Spar M, Oda K, et al. Effect of the supplemental use of antioxidants vitamin C, vitamin E, and coenzyme Q10 for the prevention and treatment of cancer. Evidence Report/Technology Assessment Number 75. AHRQ Publication No. 04-E003. Rockville, MD: Agency for Healthcare Research and Quality, 2003.
94. <http://www.khuns.nemegdel.pms.mn>
95. <http://babyzone.mn/n/2629>
96. <https://en.wikipedia.org/wiki/Folate>
97. Lynn B Bailey, Patrick J Stover, Helene McNulty, Michael F Fenech, Jesse F Gregory III, James L Mills, Christine M Pfeiffer, Zia Fazili, Mindy Zhang, Per M Ueland, Anne M Molloy, Marie A Caudi II, Barry Shane, Robert J Berry, Regan L Bailey, Dorothy B Hausman, Ramkripa Raghavan and Daniel J Raiten. (2015) Biomarkers of Nutrition

- for Development - Folate Review. The Journal of Nutrition - Supplement: Biomarkers of Nutrition for Development (BOND) Expert Panel Reviews, Part 2
98. Wulf Becker, Anna Karin Lindroos, Cecilia Nälsén, Eva Warensjö Lemming & Veronica Öhrvik. (2016) Dietary habits, nutrient intake and biomarkers for folate, vitamin D, iodine and iron status among women of childbearing age in Sweden. *Uppsala Journal of Medical Sciences*
 99. Defining, Establishing, and Verifying Reference Intervals in the Clinical laboratory: Approved Guideline-Third Edition 2010
 100. Цусны цайрын агууламжийг атом шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлох стандарт ажиллагааны заавар-САЗ:ША–3.9
 101. Determination of Iron in Serum or Plasma by Atomic Absorption Spectrophotometry Denis O Rodgerson, Ray E Helfer *Clinical Chemistry*, Volume 12, Issue 6, 1 June 1966, Pages 338–349
